



Миний хүү Мио

Астрид Линдгрен



Миний хүү Мио

Астрид Линдгрен

Зургийг Илон Викланд
Орчуулсан Хатанбаатарын Хулан

Улаанбаатар хот
2007он

Астрид Линдгрэн

Миний хүү Мио

"Миний хүү Мио" нэртэй монгол хэл дээрх орчуулгын эрх © Интерпресс ХХК 2007

Зохиогчийн эрх © *Saltkrökan AB / Astrid Lindgren 1954*

Астрид Линдгрений "*Mio, min Mio*" нэртэй зохиолыг анх швед хэл дээр *Rabén & Sjögren Bokförlag AB, Stockholm* хэвлэн нийтэлсэн

Зохиогчийн эрхийг *Saltkrökan AB, SE-181 10 Lidingö, Sweden* хаягаар дамжуулж авна.

Зохиолч, түүний уран бүтээлийн талаар дараах вэбсайтийг үзнэ үү:
www.astridlindgren.net

Швед хэлнээс орчуулсан Х.Хулан
Хянан тохиолдуулсан Ж.Дашдондог
Хянагч Ж.Гэрэлмаа
Хэвлэлийн эх бэлтгэсэн Н.Хөдөлмөр
Зураач Илон Викланд



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК
2007 он

Зууны манлай хүүхдийн зохиолч

Энэ зууны эхээр Мюнхен дахь олон улсын хүүхдийн номын санд очиж, дэлхийн хүүхдийн утга зохиолтой танилцах завшаан надад олдож билээ. Уншлагын их танхимын хананд Х.К.Андерсен, А.Линдгрэн хоёрын зургийг өөд өөдөөс нь харуулан байрлуулсан байв. Үнэхээр Андерсен 19 дүгээр зууныг, Линдгрэн 20 дугаар зууныг эзэлсэн суут үлгэрч гэдэг нь хэнд ч ойлгомжтой. Өнгөрсөн зуунд Астрид Линдгренийг гүйцэх хүүхдийн зохиолч манай гариг дээр гараагүй гэхэд хилсдэхгүй байх. Өөрийнх нь амьдрал ч бүхэл бүтэн зуун дамнан үргэлжилсэн. 1907 онд Шведэд төрж, 2002 онд насан эцэс болтлоо хүүхдийн зохиол туурвисан. Түүний *"Урт оймст Пиппи"*, *"Дээвэр дээр суудаг Карлсон жаал хүү хоёрын үлгэр"*, *"Миний хүү Мио"*, *"Арслан зүрхт ах дүү хоёр"*, *"Лённебергийн Эмиль хүүгийн адал явдал"*, *"Дээрэмчний охин Роня"* зэрэг олон зохиолыг нь дэлхий дахинаараа андахгүй. Тийнхүү ганц Шведийн төдийгүй дэлхийн хүүхдүүдэд оюуны хөрөнгө оруулалт хийснийхээ төлөө 1958 онд Андерсений шагнал хүртжээ. Монголын бяцхан уншигчид 1959 онд нуруундаа сэнстэй нисдэг хүний тухай алдарт үлгэрийг нь эх хэл дээрээ уншсан билээ. Харин энэ удаа Астрид Линдгрений 100 жилийн ойд нь зориулж "Миний хүү Мио" хэмээх уран сэтгэмжийн үлгэрийг нь мэргэжлийн орчуулагч Хатанбаатарын Хулангийн орчуулгаар та бүхэнд толилуулж байна.

Жамбын Дашдондог

Гарчиг

Өдөр шөнийг туулан аялсан нь	5
Сарнайн цэцэрлэгт	18
Мирамис	29
Одод бас хөгжимд дуртай юу?	39
Үдэш үлгэр шивнэдэг худаг	48
Харанхуй ой дундуур давхисан нь	61
Илбэдүүлсэн шувууд	77
Сөнөсөн ойд	87
Хараас хар уулын гүнээс гүн агуйд	101
Төмөр сарвуу	114
Аюултай илд	125
Миний хүү Мио	141



Өдөр шөнийг туулан аялсан нь

Өнгөрсөн оны арван сарын арван таванд радио сонссон хүн байна уу? Сураггүй алга болсон нэгэн хүүгийн тухай сонссон хүн байна уу? Ингэж ярьж байсан юм:

"Стокхольм хотын цагдан сэргийлэх газар уржигдар оройн 18 цагаас хойш сураггүй алга болсон 13-р Уппландсготан гудамжинд суудаг 9 настай Бу Вильхельм Ольссоныг хайж байна. Бу Вильхельм Ольссон нь цайвар шар үстэй цэнхэр нүдтэй, алга болох үедээ бор өнгийн богино өмд, саарал ноосон цамц, жижиг улаан малгайтай байсан. Хүүг харсан үзсэн хүн байвал цагдан сэргийлэх газарт мэдэгднэ үү."

Тийм ээ, тэд ингэж хэлсэн юм. Гэвч Бу Вильхельм Ольссоны талаар ямар ч мэдээлэл очоогүй. Тэр зүгээр л

алга болчихсон. Түүний хаашаа явсныг хэн ч мэдсэнгүй. Энэ талаар надаас өөр хэн ч юу ч мэдэхгүй. Учир нь Бу Вильхельм Ольссон гэгч нь би өөрөө юм.

Би тохиолдсон бүхнээ ганцхан Бэнкад ч болов ярьж өгөх юм сан гэж хүснэ. Бэнка бид хоёр хамт тоглодог байлаа. Тэр ч гэсэн Уппландсготан гудамжинд аж төрдөг. Түүнийг уг нь Бэнгт гэдэг. Гэвч хэн хүнгүй л Бэнка гэж дууддаг бөлгөө. Намайг мэдээж Бу Вильхельм Ольссон гэж хэн ч дууддаггүй. Тэд зүгээр л Боссэ гэдэг.

Тийм ээ, тэд зүгээр л Боссэ гэдэг байсан. Одоо би алга болсон байгаа тул намайг хэн ч дуудахгүй. Эдла эгч Сикстэн ах хоёр л намайг Бу Вильхельм гэдэг. Үгүй, Сикстэн ах ер нь юу ч гэж хэлдэггүй. Тэр надтай бараг ам нээдэггүй байсан.

Эдла эгч Сикстэн ах хоёр намайг өргөж авсан юм л даа. Би энд нэг настайдаа ирсэн. Урьд нь би асрамжийн газарт байв. Эдла эгч намайг тэндээс гэртээ аваачсан юм. Тэр уг нь охин үрчилж авах санаатай байсан ч тэр нь байгаагүй учраас л би тэднийх болсон юм. Сикстэн ах Эдла эгч хоёр ер нь эрэгтэй хүүхдэд дургүй. Ялангуяа найм есөн настай бол бүр ч дургүй. Тэд намайг гэрт чимээ их гаргадаг, гадаа Тэгнэрлюндэн цэцэрлэгт хүрээлэнд тоглоод орохдоо шороо чирч ирдэг, хаа сайгүй л хувцсаа хаядаг, хэтэрхий чанга ярьж, инээдэг гэж төвөгшөөн үздэг. Эдла эгч намайг тэднийд ирэхэд маш азгүй өдөр байсан гэж дандаа ярьдаг. Сикстэн ах ч нэг их юм хэлэх биш дээ. Гэхдээ тэр хааяа ингэж хэлдэг юм.

"Гадаа гарч нүднээс далд ороод өгөөч!"

Би голдуу Бэнкагийн д л өнждөг сөн. Аав нь хүүтэйгээ

дандаа ярьж, онгоц хийж хөөргөхөд нь тусалж, хэр зэрэг том болж байгааг нь гал тогооны хаалган дээрээ зураасаар тэмдэглэх гээд л барагдахгүй их ажилтай. Бэнка ёстой зоргоороо инээж, ярьж, хувцсаа хаа хамаагүй тайчиж хаядаг. Тэгсэн ч аав нь түүнд хайртай. Хөвгүүд Бэнкагийн ирж тоглож болдог байв. Харин манайд хэн ч ирж болохгүй. Учир нь Эдла эгч хүүхдийн бужигнаан шуугианд маш дургүй. Сикстэн ах ч мөн адил. "Манайд нэг хүүхэд л хангалттай" гэж тэр хэлдэг байв.

Хааяа би орондоо ороод хэвтэж байхдаа "Бэнкагийн аав бас миний ч байдаг ч болоосой," гэж мөрөөддөг байлаа. Тэгээд би миний төрсөн эцэг хэн юм бол? Би яагаад жинхэнэ ээж аав хоёртойгоо байж болоогүй, асрамжийн газарт юм уу, эсвэл Эдла эгч Сикстэн ах нартай нэг гэрт суух болсон тухай боддог байв. Эдла эгч, "Ээжийг минь намайг төрүүлээд өнгөрсөн гэнэ лээ," гэж хэлсэн. Миний аавыг хэн ч мэдэхгүй. "Ямар өөдгүй амьтан болохыг нь тааж ядаад байх юмгүй" гэж тэр ярьдаг. Аавын минь тухай ингэж ярьдаг болохоор Эдла эгчид миний дургүй хүрдэг. Ээж намайг төрүүлээд нас барсан нь үнэн байх л даа. Харин аав өөдгүй амьтан яавч биш, түүнийг би сайн мэдэж байна. Хааяа аавыгаа бодохоор нүдэнд нулимс аяндаа мэлтрээд ирдэг.

Харин надад сайнаар ханддаг нэг хүн бий. Тэр нь жимсний дэлгүүрийн Люндин эгч билээ. Надад байсхийгээд л чихэр жимс өгдөг.

"Люндин эгч ер нь хэн юм бол?," гэж би одоо өөрөөсөө асууж сууна. Өнгөрсөн жилийн арван сарын тэр нэгэн өдөр би түүнийг зорьж очсоноор бүх хэрэг эхэлсэн юм.

Тэр нэгэн өдөр манайд ирсэн нь золгүй явдал болсон

гэж Эдла эгч надад дахин дахин ярьж байсан. Оройн арван найман цагийн хавьцаа Хатан хааны гудамжинд байдаг нэгэн нарийн боовны дэлгүүрээс идэх дуртай жигнэсэн талхаа авуулахаар намайг явууллаа. Би улаан малгайгаа өмсөөд гарав.

Жимсний дэлгүүрийн хажуугаар өнгөрөхөд Люндин эгч хаалган дээрээ зогсч байлаа. Тэр намайг эрүүдэж аваад удаан гэгч нь нэг л сонин харцаар харав. Тэгснээ,

- Чи алим идэх үү? гэж асуулаа.

- Тэгье, баярлалаа гэж би хариулав. Тэгээд надад бөөр улаан, гоё алим өглөө. Дараа нь надаас,

- Чи миний энэ ил захидлыг шуудангийн хайрцагт хийгээд өгөхгүй юу? гэж хүслээ.

- Тэгье, тэгье гэж би хариулав. Ил захидал дээрээ хэдэн мөр бичээд надад өглөө.

- Сайн яваарай, Бу Вильхельм Ольссон гэж Люндин эгч хэлэв.

- Сайн яваарай, Бу Вильхельм Ольссон!

Ийнхүү үгээ давтан давтан хэлсэн нь нэг л гайхалтай санагдав. Намайг уг нь Боссэ л гэж дууддаг сан.

Хэдэн байшингийн цаана орших шуудангийн хайрцаг уруу би яаравчлан гүйлээ. Ил захидлыг нь хайрцаг уруу яг хийх гэтэл галын дөл шиг гэрэлтээд ирлээ. Тийм ээ, Люндин эгчийн бичсэн үсэг бүхнээс галын дөл дүрэлзэх шиг. Намайг унш гэсэн юм шиг. Ил захидал дээр ингэж бичсэн байлаа:




Алс холын оронд суугаа

Эзэн хаанд:

Удаан хүлээсэн хүн чинь замдаа явж байна. Тэр өдөр шөнийг туулан аялах бөгөөд гартаа алтан алим барьсан байгаа. Тэр бол түүнийг таних тэмдэг юм.

Би юу ч ойлгосонгүй. Бие минь нэг л хачин хүйтэн оргиод явчихлаа. Би ил захидлыг хурдан гэгч нь хайрцагт хийлээ.

Өдөр шөнийн ертөнцөөр аялдаг нь хэн юм бол? Тэгээд бас алтан алим барьж яваа гээд байгаа.



Тэгсэн чинь нүд Люндин эгчийн өгсөн алим дээр тогтлоо. Тэр нь алтан алим. Тийм шүү, үнэхээр алтан алим байсан. Би гартаа түүнийг барьж байлаа.

Тэгээд бараг уйлах шахав. Жинхнээсээ биш л дээ, гэхдээ л уйлмаар санагдаад. Би маш их ганцаардаж эхлэв. Би Тэгнэрлюндэний цэцэрлэгт хүрээлэн орж, сандал дээр суулаа. Тэнд ганц ч хүн байсангүй. Бүгд хоолоо идэхээр гэртээ харьсан байлаа. Цэцэрлэгт хүрээлэнд харуй бүрий болж, бас бороо шивэрч эхлэв. Харин зэргэлдээх байшингууд гэрэлтэй харагдана. Бэнкагийн цонх бас гэрэлтэй байгааг би олж харав. Тэр ээж аавтайгаа зэрэгцэн суугаад вандуй, өндөгтэй шарвин идэж байгаа даа. Ер нь гэрэлтэй цонх бүрийн цаана хүүхдүүд ээж аавтайгаа хамт сууж байгаа байх гэж би бодлоо. Ганцхан би л харанхуйд ганцаараа.



Ямар хэрэгтэйг одоохондoo үл мэдэх алтан алимнаас ондоо юу ч үгүй.

Тийнхүү бодох зуураа би нөгөө алимыг сандал дээрээ болгоомжтой гэгч тавилаа. Гудамжны дэнлүүний гэрэл над дээр ч алиман дээр ч ялгаагүй тусна. Гэрэл газар хэвтээ бас нэг юман дээр тусах ажээ. Тэр нь нэг муу шар айрагны хоосон лонх байлаа. Ам уруу нь мод чихэж орхисон байна. Тэр нь үдээс өмнө тэнд тоглож байсан жаалуудын хийсэн ажил биз. Шилэн дээрх шошгыг уншвал "Стокхольмын шар айрагны үйлдвэр-Хувьцаат компани 2" гэж бичсэн байна. Тийнхүү унших зуураа шилэн дотор нэг юм бүртэсхийх шиг болохыг олж харлаа.

Би нэг удаа номын сангаас *"Мянга нэгэн шөнийн үлгэр"* номыг авч уншиж байсан. Тэнд шилэнд хоригдсон бирдийн тухай өгүүлдэг. Гэхдээ тэр чинь мянгаад жилийн өмнө, өнө эртний Араб оронд л байсан хэрэг. Гэхдээ арай жирийн нэг шар айрагны шилэнд байгаагүй биз. Харин Стокхольмын шар айрагны үйлдвэрийн шилэн дотор бирд байна гэдэг ховорхон тохиол биз ээ. Тэнд яахын аргагүй нэг юм байх нь байна. Сайн хартал үнэхээр нэг бирд сууж байлаа. Шилнээс гарахыг хүсэж буй нь илт. Модон бөглөө үрүү байн байн зааж, ихэд гуйсан янзтай над уруу харна. Урьд нь тийм юм үзээгүй болоод тэр үү шилний бөглөөг авна гэдэг нэг л аймшигтай санагдаж байлаа. Гэсэн ч яая гэхэв, бөглөөг мулталлаа. Исгэрэх их чимээ гарч, нөгөө муу жаахан бирд чинь улам томорч эхлэв. Тэгснээ тэр хавийн бүх байшингаас ч том боллоо. Ер нь энэ бирд гэгч мангаа ямар ч жижиг шилэнд жижгэрэн агшиж ордог атлаа,

гарахаараа мянга дахин томорч чадна.

Хэчнээн их айсны минь хэн ч төсөөлж үл чадна. Хөлөөс толгой хүртэл дагжин чичирч байлаа. Түүний ярих гэж бөөн тэнгэрийн дуу. Исгэчээд л, хашгичаад л. Эдла эгч Сикстэн ах хоёр намайг гэрт чанга ярилаа гэдэг. Бирдийн дууг тэр хоёрт сонсгох юм сан.

Надад хандаж хэлсэн эхний үг нь “Хүүхэд”, тэгээд цааш нь:

- Чи намайг шоронгоос суллалаа. Чамайг яаж шагнавал зохистойг өөрөө шийд гэв. Шилнээс анх гаргахдаа юун шагнал магнал бодохтой манатай. Бирд өчигдөр орой Стокхольм хотноо хүрэлцэн ирж, шилэн дотор унтахаар орсноо ярив. Лонх бол тэдний хувьд унтахад хамгийн тохиромжтой газар нь юм. Унтах ч биш, үгүй ч биш байх хооронд шилний ам таглагдсан аж. Хэрэв би түүнийг гаргаагүй байсан бол, хөөрхий бирд лонхон дотроо модон бөглөөг илжиртэл мянган жил ч хэвтэх байсан юм билүү, хэн мэдэх вэ?

“Ийм явдал тохиосон бол миний эзэн болох хаанд лав таалагдахгүй дээ” гэж бирд өөртөө хэлэв.

Би зориглон асуув,

- Бирд ээ, чи хаанаас ирсэн бэ?

Хэсэгхэн чимээгүй байснаа бирд хариулав,

- Би Алс холын орноос ирсэн.

Тийнхүү толгой доргитол, сэтгэл догдолтол чанга хэлэхийг нь сонсоод ямар орон байдаг юм бол доо гэсэн бодол надад төрлөө. Тийш очиж үзэх бодол өөрийн эрхгүй сэтгэлийг минь эзэмдээд ирлээ. Би бирдэд гараа сарвайн,

- Алив, намайг тэр орондоо аваад яваач! Алс холын

оронд чинь хамт очъё! Тэнд намайг хүлээж байгаа хүн бий.

Бирд толгой сэгсрэв. Тэгэхлээр нь би түүнд алтан алимаа үнэмлэх мэт үзүүлэхэд бирд дуу алдаж,

- Тэмдэг нь мөн байна! Авч явах хүн маань ч чи мөн байна. Хааны удтал хайсан хүн нь чи мөн байна!

Тэр тонгойсноо намайг өргөлөө. Тэгснээ нирхийсэн их чимээ, уянгалсан зөөлөн чимээ хослон агаарт хөөрлөө. Тэгнэрлюндэн тэртээ дор үлдлээ. Харанхуй Тэгнэрлюндэн цэцэрлэгт хүрээлэн, эцэг эхтэйгээ хооллож байгаа хүүхдүүд, гэрэлтсэн цонхтой байшингууд бүгд өлмий дор үлдэж, би оддын өөхий доогуур нисч яваагаа мэдлээ.

Бид үүлний дээгүүр гялсхийн цахих цахилгаанаас ч хурдан, нирхийн нүргэлэх аянганаас ч чанга дуу гарган урагшилж байлаа. Дэргэдүүр одод жингэнэн, нар сар гялалзан өнгөрлөө. Үе үе шөнө мэт харанхуйлж, үе үе нүд гялбасан хурц гэрэлтэй байх нь сонин.

"Өдөр, шөнийг туулан аялах гэдэг нь энэ байх" гэж би дотроо шивнэн явав. Ил захидал дээр ингэж бичсэн байсан.

Тэгтэл бирд гэнэт гараа дэлгэн, цэнхэр тунгалаг усаар хүрээлүүлж, нарны цацраг тодоос тод туссан алст буй нэгэн ногоон газар луу заалаа.

- Алс холын орон харагдаж байна гэж бирд хэлэв. Бид тэр ногоон газар тийш зүглэв.

Тэр нь далайд хөвж яваа нэгэн арал байлаа. Агаарт мянган сарнай, сараана цэцгийн үнэр анхилж, ертөнцийн бүх хөгжмөөс илүү сайхан нэгэн хосгүй ая сонстоно.

Далайн эргийн нэгэн том цагаан шилтгээн дээр бид



буулаа.

Эрэг даган нэгэн хүн ирж явна. Тэр бол *миний хаан аав* байв. Би түүнийг харангуутаа л танилаа. Миний аав мөн гэдгийг би мэдэж байсан юм. Тэр гараа алдлахад би гүйн очиж цээжинд нь наалдав. Тэр намайг удтал тэвэрлээ. Бид юу ч ярилгүй хүзүүгээр нь тас тэвэрсээр байлаа.

Эдла эгч хаан аавыг минь хардаг ч болоосой гэж би ямар их хүснэ вэ? Тэр ямар сайхан царайтай, хувцас нь ямар гоё алт, очир эрдэнэсээр гялалзана вэ? Тэр Бэнкагийн аавтай төстэй ч түүнээс хамаагүй илүү гоё. Эдла эгч түүнийг харж чадахгүй нь харамсалтай. Харсан сан бол аавыг минь өөдгүй амьтан биш гэдгийг ойлгох

байсан даа.

Гэхдээ Эдла эгчийн хэлж байснаар, ээж намайг төрүүлээд нас барсан нь үнэн байжээ. Хүүхэд асрамжлан халамжлах төвийн унхиагүйчүүд хаана байгааг минь хаан аавд хэлэх талаар зүүдлээ ч үгүй байх. Аав намайг есөн жил хайсан гэнэ. Би хүссэн газраа хүрэлцэн ирсэндээ маш их баяртай байна.

Ирсээр нэлээн удлаа. Өдөр хоногийг дэндүү сайхан өнгөрөөж сууна. Орой бүр хаан аав минь өрөөнд орж ирдэг. Бид хоёр онгоцны загвар хийж, бас энэ тэрийг ярьж суудаг юм.

Алс холын оронд өсч торнино гэдэг надад сайхан байна. Сар бүр аав гал тогооны хаалган дээр хэр зэрэг өсч байгааг зураасаар тэмдэглэж байгаа.

"Хүү минь, чи ямар хурдан том болж байна аа" гэж хэмжээсийг харах бүртээ хэлнэ.

"Мио, хүү минь" гэж дуудах нь сэтгэлд ямар зөөлөн, дулаан байдаг гээч. Тэр намайг Боссэ гэдэггүй л дээ.

- Би чамайг есөн жил хайлаа. Шөнө би нойр хулжин хэвтэж байхдаа миний хүү Мио гэж боддог байв. Тэгэхлээр чиний нэрийг мэддэг байсан байгаа биз гэж аав хэлэв.

Тэгэлгүй яахав. Боссэ гэдэг нь миний Уппландсготан гудамжинд сууж байх үеийн амьдрал урвуугаараа эргэж байх үеийн нэр. Харин одоо зөвөөрөө эргэлээ.

Хаан аав бид хоёр бие биедээ маш их хайртай.

Бэнка энэ бүх явдлын талаар мэддэг ч болоосой. Би ер нь түүнд нэг захиа бичээд шилэн дотор хийнэ ээ. Дараа нь би шилээ бөглөөд, Алс холын орныг хүрээлсэн цэнхэр далай уруу шиднэ ээ. Бэнка ээж аав хоёртойгоо

Ваксхольм дахь зуслангийн байшиндаа амрах үеэрээ усанд орж, миний явуулсан шилтэй захиаг авах байлгүй. Тэгдэг бол сайхан аа! Надтай тохиолдсон энэ бүх гайхалтай адал явдлын талаар тэр мэдвэл тун догь! Тэгвэл тэр сэргийлэх үрүү утасдаж "Мио хэмээх жинхэнэ нэртэй Бу Вильхельм Ольссон нь хаан аавтайгаа Алс холын оронд амар тайван сууна шүү," гэх байх даа.



Сарнайн цэцэрлэгт

Гэхдээ би Бэнкад яаж бичихээ мэдэхгүй л байна. Энэ явдал бусад хүмүүст тохиолдсон явдалтай зүйрлэшгүй өөр учраас тэр. Бэнкад би ойлгож сэнхэртэл нь ярих учраа олохгүй л байна. Илэрхийлэх үг хайсан ч олдсонгүй. “Надтай ер бусын явдал тохиолоо” гээд л бичиж эхэлдэг юм билүү? За, тэгж бичлээ ч Бэнка лс холын оронд ямаршуухан байгааг яаж төсөөлөх билээ. Хаан аав, түүний сарнайн цэцэрлэг, миний Юм-Юм найз, цагаан Мирамис морь, Харанхуй орны хэрцгий дээрэмчин Катогийн талаар ярьж өгөх гэвэл дор хаяж арван хоёр шил дүүрэн захидал явуулах хэрэгтэй. Үгүй, би энд тохиолдсон явдлаа бүгдийг нь хэзээ ч ярьж

чадахгүй.

Ирэнгүүт л хаан аав сарнайн цэцэрлэгтээ намайг дагуулж орлоо. Үдэш болж, салхинд мод найгаж байлаа. Сарнайн цэцэрлэгт оронгуут мянган шилэн хонхны дуу зэрэг эгшиглэх мэт нэгэн гайхалтай хөгжим сонсогдлоо. Намуухан боловч, сонссон хэний ч болов сэтгэл уяран хайлмаар эгшиглэнэ.

- Миний мөнгөн улиангарын дууг чи сонсч байна уу? гэж аав асуулаа.

Тэр намайг хөтлөн дагуулж явлаа. Эдла эгч Сикстэн ах хоёр намайг ямар ганц удаа ч болов хөтөлж явсан биш дээ. Ер нь урьд өмнө нь хэн ч намайг хөтөлж байсангүй. Би хэдий том болсон ч хаан аавынхаа гараас атгаад эцгийн хайрыг мэдэрч явах туйлын сайхан байлаа.

Сарнайн цэцэрлэгийг өндөр ханатай хашаа хүрээлж байв. Аав нэгэн жижиг хаалгыг нээж, бид дотогш орлоо.

Хэдэн жилийн өмнө би Бэнкагийн Ваксхольм дахь зуслангийн байранд очиж байсан. Бид хоёр нар жаргахын өмнө хавтгай хадан дээр суугаад загасчилж байв. Тэнгэр ув улаан, ус чимээ аниргүй. Хээрийн сарнай яг цэцэглэдэг үе сэн. Хадны цаана дүүрэн сарнай. Тохойн сэжүүрээс хөхөө донгодох нь тодхон. Хорвоод олон сайхан зүйл байдаг ч түүнээс сайхан нь үгүй шиг санагдана. Хөхөө харагдахгүй байсан ч дуу нь бүх юмыг сайхан харагдуулж байлаа. Би энэ талаар Бэнкад хэлэлгүй, зүгээр дотроо л бодож суув. Хорвоогийн хамгийн сайн сайхан тэнд цогцлон бүрджээ.

Гэхдээ би тэр үед аавынхаа сарнайн цэцэрлэгийг үзээгүй байсан юм. Усан мандал мэт улаан сарнай,

цасан ширхэг мэт цагаан сарааныг би урьд нь үзсэнгүй. Бас тэнгэрт тултал ургасан мөнгөн навчтай улиангар модыг үзээгүй байжээ. Үдэш болохоор модны оройд одод асна. Сарнайн цэцэрлэг дундуур цагаан шувууд ниснэ. Мөнгөн модны навчсын сэрчигнэх эгшиглээн, дээгүүр нь нисэх шувуудын ганганаа хослон, ер бусын гайхамшигт аялгуу үүсгэх ажээ. Урьд нь би тийм дуу сонссон удаагүй. Ер нь тийм ер бусын цэцэрлэгийг хэн ч үзээгүй биз ээ. Би аавынхаа гарыг атган, чимээгүй зогсож байлаа. Аав дэргэд байвал л боллоо. Ийм гайхамшгийг ганцаараа харах нь хэцүү л дээ. Тэгээд аав хацрыг минь илээд,

- Мио, сарнайн цэцэрлэг чамд таалагдаж байна уу? гэв.

Би хариулах гээд чадсангүй, учир нь надад нэг л сонин санаа төрөөд явчхав.

Гунигтай ч юм шиг, би уг нь гунигтай бус, харин ч эсрэгээр нь! Би аавдаа баяртай байгаагаа хэлэх гэтэл тэр хариулах нь:

- Чи аз жаргалтай байгаа нь тун сайн хэрэг. Миний хүү Мио, чи ямагт энэ хэвээрэй яваарай.

Дараа нь тэр өөрийг нь хүлээж буй сарнайн цэцэрлэгийн цэцэрлэгчтэй уулзахаар явлаа. Би ганцаараа гүйж, эргэн тойрноо ажлаа. Гайхамшгаар цогцолсон тэр бүхнийг хараад миний толгой эргэн алдана. Эгээтэй л намайг гаазтай ундаагаар дүүргэчхэв үү гэлтэй. Баярласандаа болоод хөл минь өөрөө гүйгээд байгаа юм шиг, бас гарын хүч нэмэгдчихсэн ч юм шиг. Хэрвээ Бэнка тэнд байсан бол мэдээж бид хоёр ноцолдож тоглоно доо. Тийм ээ, Бэнкаг тэнд байгаасай

гэж би хүслээ. Хамгийн гол нь сэтгэлээ хуваалцах үе тэнгийн найзтай болохыг би мөрөөдлөө. Хөөрхий Бэнка одоо Тэгнэрлюндэний цэцэрлэгт хүрээлэнд л байгаа биз. Тэнд салхи бороотой, харанхуй бүрэнхий л байгаа байх даа. Намайг алга болсныг тэр өдий болоход лавтайяа мэдсэн дээ. Хөөрхий Бэнка намайг “Хаачсан бол? Ер нь дахин уулзах болов уу?,” гэж бодож байгаа даа. Бэнка бид хоёр их зугаатай сайхан байдаг байсан тул би түүнийг хаан аавынхаа сарнайн цэцэрлэг дундуур явж байхдаа санаж эхлэв. Хуучин үеийн өнгөрсөн бүхнээс надад дутагдаж байгаа цорын ганц хүн бол Бэнка байлаа. Би үнэхээр өөр хэнийг ч санахгүй байна. Аа тийм, бас Люндин эгчийг санах ч шиг. Яагаад гэвэл тэр надад дандаа сайн ханддаг байсан. Гэхдээ би Бэнкаг л ямагт бодон, хэсэг хугацаанд чив чимээгүйгээр сарнайн цэцэрлэгийн нарийнхан, мурилзсан замаар цааш алхах зуур, намайг гаазтай ундаагаар дүүргэсэн мэт байдал ариллаа. Би нэлээд гуниглангуй алхалж явлаа. Тэгээд харсан чинь өмнөх зам дээр хэн байсан гээч? Бэнка арай биш байгаа? Биш, биш! Юм-Юм зогсож байлаа. Түүний нэрийг Юм-Юм гэж би мэдээгүй л дээ. Бэнкатай адил бор нүдтэй, бор үстэй нэгэн хөвгүүн зогсож байх нь тэр.

- Чи хэн бэ? гэж би асуув.

- Намайг Юм-Юм гэдэг гэж тэр хариулав.

Сайн ажиглавал, тэр Бэнкагаас арай өөр. Тэгэхдээ Бэнкагаас илүү томоотой бөгөөд илүү нөхөрсөг байдалтай. Бэнка хүнтэй найзлахдаа надархуу гэх юм уу даа. Нөхөрсөг байдал нь дунд зэрэг, гэхдээ гар зөрүүлэх явдал гаралгүй л яахав. Хааяа бид хоёр муудалцдаг

байсан ч дорхноо л буцаад сайдчихна. Харин энэ Юм-Юм бол хэзээ ч зодолдохгүй байлгүй. Тэр хүмүүжил сайтай хүүхэд шиг харагдлаа.



- Миний нэрийг мэдмээр байна уу? гэж би асуугаад,

- Намайг Боссэ ... үгүй, Мио гэдэг гэлээ.

- Чамайг Мио гэдгийг би мэднэ ээ. Манай эзэн хаан Мио гэртээ ирсэн гэсэн мэдээг орон даяар түгээсэн шүү дээ гэж Юм-Юм өгүүлэв.

Хаан аав минь намайг олсондоо баярлаад, хаа сайгүй мэдээлжээ.

- Чи аавтай юу? гэж би Юм-Юмаас асуугаад, аавтай гэж хэлээсэй хэмээн би бодож зогслоо. Би өөрөө удтал аавгүй байсан тул ямар гунигтайг мэднэ.

- Надад аав байлгүй яахав гэж Юм-Юм хариулав.

- Эзэн хааны сарнайн цэцэрлэгийн цэцэрлэгч чинь миний аав байхгүй юу. Чи надтай хамт явж, миний хаана суудгийг үзэх үү?

Би үзэхийг хүслээ. Тэгээд тэр миний өмнө гарч,



мурилзсан зөргөөр дагуулан, сарнайн цэцэрлэгийн хамгийн захын булан хүртэл гүйлээ. Тэнд яг үлгэрт гардаг шиг сүрлэн дээвэртэй жижигхэн цагаан байшин харагдав. Хана, дээврээр нь дүүрэн сарнай цэцэг ургаж, байшин нь бараг харагдахгүй байлаа. Нээлттэй цонхоор цагаан шувууд дураараа орж гарсаар. Байшингийн нэг талд модон сандал, ширээ, мөн эгнүүлэн тавьсан зөгийн олон үүр байлаа. Зөгийнүүд сарнай цэцгийн дунд дүнгэнэлдэнэ. Эргэн тойрон сарнай цэцгийн шугуй. Бас мөнгөн навчтай улиангар, уд мод. Гэтэл гал тогооноос,



- Юм-Юм, чи оройн хоолоо идсэн үү? гэх сонстов.

Тэр нь Юм-Юмын ээж байлаа. Тэр хаалган дээрээ инээмсэглэн зогсож байв. Яг Люндин эгч шиг харагдав. Арай илүү царайлаг ч юм уу. Түүний хацар дахь хонхорхой нь Люндин эгчийнхтэй адил юм. Тэгээд бас "Сайн яваарай, сайн яваарай! Бу Вильхельм Ольссон," гэж хэлж байхдаа миний эрүүнд гар хүрч байсантай адил эрүүг минь барив. Юм-Юмын ээж:

- Сайн байна уу? Мио! Чи Юм-Юмтай хамт оройн хоол идэх үү? гэхэд,

- Тэгье, танд нэг их төвөг удахгүй бол гэж би хариулав. Тэр,

- Ямар ч төвөг болохгүй гэв. Ингээд Юм-Юм бид

хоёр байшингийн өмнөх ширээний ард суув. Ээж нь бидэнд зориулж өндөгтэй шарвин, гүзээлзгэний шүүс болон сүү авчирлаа. Юм-Юм бид хоёр цадталаа идээд, бие бие үрүүгээ харан инээлдэж байв. Түүнтэй ийнхүү хамт байгаадаа би баяртай байлаа. Цагаан шувуудын нэг нь хажуугаар нисэхдээ миний тавагнаас нэг өндөгтэй шарвин шүүрэхэд Юм-Юм бид хоёр улам их инээлдэв. Яг энэ мөчид хаан аав минь сарнайн цэцэрлэгийн цэцэрлэгчтэй хамт ирлээ. Гэнэт би сандран өндөсхийв. "Энд сууж хооллоод, чанга инээж суугаа минь аавд таалагдахгүй байвал яана," гэж би бодлоо. Учир нь би аавынхаа ааш зан, бас надад ямар хайртай, намайг инээгээсэй гэж хүсдэг эсэхийг мэдэхгүй байлаа.

Аав намайг хараад зог туссанаа,

- Хүү минь, чи энд инээж суугаа юм уу? гэж тэр асуув.

- Тийм ээ, намайг уучлаарай гэж би хэлэв. Аав минь



намайг чанга инээхэд Эдла эгч Сикстэн ах хоёрын адил дургүйцэх байх гэж би бодсон юм.

- Зүгээр зүгээр, инээ инээ гэж аав хэллээ. Тэгээд цэцэрлэгчдээ хандан,

- Би шувуу жиргэхэд дуртай, мөнгөн улиангарын аялгуунд бас дуртай. Харин хүү минь сарнайн цэцэрлэгт инээж суухад бүр илүү дуртай гэж өгүүллээ.

Тэгэхэд л би анх удаагаа "Хаан ааваас хэзээ ч эмээх хэрэггүй юм байна," гэдгийг ойлголоо. Ямар ч юм хийсэн яг одоо намайг харж байгаа энэ л найрсаг харцаараа дандаа харж байх юм байна. Аав цэцэрлэгчийн мөрөн дээр гараа тавин зогсох хооронд цагаан шувууд тойрон нисэлдэнэ. Ямар сайхан юм бэ? Аавын тэр сайхан хандлагыг мэдсэнээс хойш баяр хөөр цээжээр дүүрээд л, урьд нь би тэгж их баярласнаа мэдэхгүй юм. Тэгээд би тас тас хийтэл чанга инээлээ. Толгойгоо савчин, шувуудыг дэрхийн үргэтэл чанга инээлээ. Юм-Юм намайг шувуунд өндөгтэй шарвингаа шүүрүүлсэндээ л инээж байна гэж бодоо доо. Юм-Юм ч бас байдгаараа чанга инээлээ. Миний аав ч, Юм-Юмын ээж аав хоёр ч бүгд даган инээлдлээ. Тэд юунд инээлдсэн юм бол? Харин би бол хаан аавдаа хандан инээж байгаагаа л мэднэ.

Юм-Юм бид хоёр хоолны дараа сарнайн цэцэрлэг дундуур гүйдэж, өвсөн дээр тонгорцоглон, сарнайн бутны ард нуугдаж тоглолоо. Тэнд нуугдах газар мундахгүй. Тэгнэрлюндэний цэцэрлэгт хүрээлэн болон тэндэхийн орчин тойронд энэ нуугдаж тоглодог газрын аравхан хувь нь л байсан бол Бэнка бид хоёр хэчнээн сэтгэл хангалуун байх сан билээ. Бэнка л баярлах байсан

даа гэж хэлэх гэсэн юм. Одоо бол Тэгнэрлюндэний цэцэрлэгт хүрээлэнд нуугдах газар хэзээ ч хайх хэрэггүй болжээ. Тэр нь ч сайн боллоо.

Үдшийн бүрэнхий орж эхэллээ. Сарнайн цэцэрлэг зөөлөн цэнхэр мананд хучигджээ. Цагаан шувууд жиргэлдэхээ больж, үүрээ хайна. Мөнгөн улиангар ч бас чимээгүй. Сарнайн цэцэрлэгт чимээ аниргүй боллоо. Мөнгөн улиангарын оройд нэгэн том хар шувуу гав ганцаараа үлдээддуулжгарав. Тэрбүхцагааншувуунаас илүү гоё дуулж буй нь зөвхөн надад зориулсан мэт санагдлаа. Гэхдээ тэр шувуу зүрх шимширтэл дуулж байсан тул би сонсохыг нэг их хүссэнгүй.

- Шөнө боллоо, би гэртээ харилаа гэж Юм-Юм хэлэв.

- Үгүй, битгий яваач гэж би хэлэв. Учир нь би тэр гайхалтай аялгууг ганцаараа сонсч үлдмээргүй байв.

- Юм-Юм, энэ юу вэ? гэж би том хар шувууны зүг зааж асуулаа.

- Мэдэхгүй, би түүнийг гунигийн шувуу гэж нэрлэдэг. Яагаад гэвэл тэр тас хар. Гэхдээ өөр нэртэй ч байж магадгүй гэж тэр хэлэв.

- Санаанд минь нэг л сайн буухгүй байна гэж би хэллээ.


- Харин миний санаанд нийцдэг шүү гэж Юм-Юм хариулав.

- Гунигийн шувуу нүд сайтай. Сайхан нойрсоорой! Мио гэж тэр хэлснээ гүйгээд явчлав.

Яг тэр мөчид аав ирлээ. Тэр намайг хөтлөн, бид сарнайн цэцэрлэг дундуур явж гэрийн зүг алхлаа. Гунигийн шувуу дуугаа аялаад л, харин одоо энэ дуунд

зүрх шимшрэхээ болив бололтой. Учир нь би аавынхаа гараас хөтөлж яваа юм чинь. Тэгээд би тэр шувуу дуугаа дуулаад л байгаасай гэж хүслээ.

Бид хоёрыг цэцэрлэгийн хаалгаар гарахаас өмнө гунигийн шувуу том хар далавчаа алдлаад тэнгэр өөд нисэхийг би харлаа. Тэнгэрт гурван жижиг од бүдэг бадаг анивчиж эхлэв.



Мирамис

Алтан дэлтэй, алтан туурт цагаан морийг минь Бэнка харвал юу гэж хэлэх бол?

Бэнка бид хоёр уул нь моринд дуртай. Намайг Уппландсготан гудамжинд суудаг байхад Бэнка Люндин эгч хоёроос өөр дотно найз байдаг байсан. Би өөр нэг найзынхаа талаар дурьдахаа мартжээ. Түүнийг Каллэ Пунт гэдэг бөгөөд шар айрагны үйлдвэрийн хөгшин морь л доо. Тэр үйлдвэрийн тэрэг долоо хоногт хэд хэд ирж, Уппландсготан гудамжны дэлгүүрүүдэд шар айраг авчирч өгдөг байлаа. Голдуу л намайг сургуульд явах үед, өглөө эрт ирдэг сэн. Би Каллэ Пунттэй жаахан ч гэсэн юм ярих гэж, тэрэг ирэхийг дандаа хүлээдэг байв. Тэр хэдий хөгширсөн ч сайн морь байсан бөгөөд би түүнд

ёотон, талхны зах хадгалж өгдөг байлаа. Бэнка ч гэсэн бас л тэгнэ. Хөгшин моринд тэр бас л над шиг хайртай байв. Тэр Каллэ Пунтыг өөрийнхөө морь гэнэ, би ч бас минийх гэнэ, түүнээсээ болж хааяа маргалдах нь ч бий. Бэнкаг сонсоогүй байхад би Каллэ Пунтын чихэнд, “Чи ямар ч байсан миний морь шүү!” гэж шивнэдэг байлаа. Калле Пунт миний хэлснийг ойлгон, тийм тийм гэх шиг толгой дохидог байлаа. Бэнкад аав ээж гээд л ер нь дутуу юмгүй. Ямар гон бие гозон толгой, над шиг биш. Тэр мориор л юу гэж дутаа гэж. Харин минийх байсан бол уу, яг таарах байсан шиг санагдана. Ний нуугүй хэлэхэд, Калле Пунт бид хоёрын алиных нь ч биш л дээ. Нөгөө үйлдвэрийн морь шүү дээ! Яагаад ч юм бид хоёр дэмий л өөр өөрийн мэтээр өмчилж ярьдаг. Гэхдээ би миний л морь байсан болоосой гэж ихэд хүсэх тул минийх гэдэгт бараг итгэдэг байв. Заримдаа би Каллэ Пунттай юм ярьсаар яваад хичээлээсээ хоцорсон ч удаатай. Багш надаас яагаад хоцорсныг асуухад би юу гэж хариулах учраа олдоггүй байлаа. Багшдаа би ямар шар айрагны үйлдвэрийн хөгшин морьтой юм ярьж байгаад гэж хэлэлтэй биш. Үйлдвэрийн тэрэг хааяа хоцорч ирнэ. Тэгээд би Каллэ Пунтыг ирэхээс өмнө сургууль уруугаа гүйдэг байв. Хөдөлж ядан явсан хөтчид нь уур хүрэхийг яана? Тэгээд ангидаа очсон хойноо халааснаасаа ёотон, талхны зах гарган үйрүүлж, Каллэ Пунтыг санан, мөн түүнтэй мөд уулзахгүй байх даа гэж бодолхийлдэг байв. Багш тэгэхлээр:

- Боссэ, чи яагаад санаа алдаад байгаа юм бэ? Чиний юу чинь ингэтлээ их өвдөөд байна? гэж хэлдэг байв.

Би үүнд нь ямар ч хариу өгдөггүй байлаа. Би юу гэж хэлэх байсан гэж? Багш намайг Каллэ Пунтэд дуртайг хэзээ ч ойлгохгүй юм чинь.

Одоо тэр морь Бэнкагийнх болоо биз дээ. Тэгэх нь ч зөв. Каллэ Пунт намайг байхгүй болохоор Бэнкагийн сэтгэлийг тайтгаруулах байлгүй.

Надад алтан дэлтэй Мирамис морь байгаа юм чинь.

Бэнка аавтайгаа онгоц эвлүүлэн суудаг сан. Түүний адил аав бид хоёр ч мөн адил онгоц эвлүүлж суухдаа би Каллэ Пунтын тухай ярьж өгсөн юм.

- Мио, Миний хүү чи тэгвэл моринд дуртай юм уу? гэж аавын хэлэхэд.

- Тийм ээ, дуртай гэв. Ингэж хэлэхэд би моринд нэг их дуртай бус мэт сонсогдож байгаа биз. Гэхдээ миний хаан аав надад дутуу юм байхгүй гэж бодоосой гэсэндээ тэгж хэлсэн юм.

Маргааш өглөө намайг сарнайн цэцэрлэгт ирэхэд урдаас нэгэн цагаан морь цахилан айсуй. Би урьд нь морь ингэж давхихыг ер хараагүй билээ. Алтан дэл нь сагсалзаж, алтан туурай нь нарны туяанд гялалзана. Хөлийн тавилт нь ердийн мориныхоос хамаагүй уужуу хол ажээ. Дэргэд минь ирж морь сүрлэг чангаар янцаав. Би хирдхийн цочиж, аавдаа наалдлаа. Аав харин хүчирхэг гараараа алтан дэлнээс нь атган авахад морь тэр даруйдаа эргэцэн зогсов. Дараа нь тэр зөөлөн хамраараа миний халаасыг үнэрлэн, ёотонгийн хэлтэрхий хайлаа. Каллэ Пунт ч гэсэн дандаа ингэдэг байсан. Надад үнэхээр ёотон байв. Хуучин зуршлаараа би авч явжээ. Морь ёотонг идчихлээ. Аав:

- Мио, энэ бол чиний морь. Нэр нь Мирамис гэлээ.

Миний Мирамис гэнэ! Анх харуут л тэр морь таатай сайхан санагдсан юм. Улдаж туйлдсан Каллэ Пунттай адилгүй, дэлхийн бүх мориноос хамгийн сайхан нь лавтайяа мөн биз. Зүйрлэх ч юм алга. Мирамис толгойгоо өргөж над уруу харахад, Каллэ Пунтын нүдтэй яг ижил байв. "Хаа газрын морьдын нүд адил байх нь ээ," гэж би бодож зогслоо.

Би хэзээ ч морь унаж байгаагүй. Аав намайг Мирамист мордуулахаар өргөв.

"Би чадах болов уу" гэж би эргэлзэв.

- Мио, чи айгаагүй биз дээ? гэж хаан аав минь өгүүлэв.

Би цулбуур авч, Мирамисыг унан сарнайн цэцэрлэг дундуур давхилаа. Мөнгөн улиангарын доогуур давхихад мөнгөн навчис нь толгой дээр унаж байв. Би улам л хурдалсаар. Мирамис хамгийн өндөр сарнайг даван үсэрлээ. Тэр өлхөн харайсан ч, цэцэгсийг яльгүй шүргэх агшинд сарнайн навчис бороо мэт унав.

Гэнэт Юм-Юм гарч ирээд миний давхихыг харлаа. Тэр алгаа ташин,

- Мио Мирамисаа унаж явна, Мио Мирамисаа унаж явна! гэж хашгирав.

Би мориныхоо амыг татаад Юм-Юмаас,

- Морь унамаар байна уу? гэж асуулаа. Мэдээж тэр татгалзсангүй. Тэр агшин зуур ирж надтай сундаллаа. Тэгээд бид сарнайн цэцэрлэгийн өмнөх ногоон нуга уруу давхилаа. Амьдралдаа үзсэн бүх юмнаас хамгийн сайхан нь тэр байлаа.

Хаан аавын харьяалсан орон их том. Алс холын



орон гэгч нь орон орны дотроос хамгийн том нь. Тэр нь зүүнээс баруун, хойд зүгээс өмнө зүг хүртэл хязгааргүй уудам. Аавын шилтгээн сүндэрлэж буй газрыг Ногоон нугын арал гэдэг. Гэвч тэр нь Алс холын орны өчүүхэн нэг хэсэг. Өчүүхнээс ч өчүүхэн дээ.

- Усны нөгөө тал, уулын хойгуурх газар нутаг бас манай эзэн хааных гэж сарнайн цэцэрлэгийн өмнөх ногоон нуга дундуур давхих үед Юм-Юм хэлсэн юм.

Нарны туяанд нисэх зуураа би Бэнкагийн тухай бодлоо. Намайг Ногоон нугын арал дээр жаргалангийн дээдийг амсч байхад хөөрхий тэр Уппландсготан гудамжиндаа, шиврээ бороонд цохиулан, харанхуйд зогсч байгаа даа. Энд ямар сайхан гээч. Нялх ногоо,

хаа сайгүй гэрэлтэх цэцэгс, зөөлөн, ногоон дов толгод, тэндээс урсах тунгалаг горхи юутай сайхан. Тэнд бас цагаан хурга сүргээрээ бэлчиж байлаа.

Малчин хүүгийн үлээх лимбэний шингэн эгшиг сэтгэлд нэг л дотно. Энэхүү содон аяыг би урьд өмнө нь сонсож байсан ч юм шиг, харин хаана хэзээ билээ? Уппландсготан гудамжинд лав би сонсож байгаагүй нь лавтай.

Бид түр саатаж малчин хүүтэй хууч хөөрөв. Түүнийг Нонно гэдэг аж. Би түүнээс түр зуур лимбээ өгөөч гэхэд дургүйцсэнгүй. Тэр надад нөгөө содон аяа хэрхэн тоглохыг зааж өглөө.

- Хэрэв хүсвэл та хоёрт лимбэ хийж өгье гэж Нонно хэлэв.

Бид нэг нэг лимбэтэй болохыг хүслээ. Ойролцоо горхи хоржигноно. Уд модны мөчир усан дээр унжина. Нонно тийшээ гүйж очоод модны нэг мөчир огтоллоо. Нонног лимбэ урлах агшинд бид хоёр горхины эрэг дээр хөлөө усанд дүрэн суув. Тэр содон аяыг Юм-Юм ч гэсэн тоглож сурлаа. Нонно хэлэхдээ,

- Энэхүү хуучин ая ертөнцийн хамгийн анхных нь гэв. Энэ аяыг малчид мянга мянган жилийн өмнөөс нугынхаа энгээр эгшиглүүлсээр иржээ.

Бидэнд лимбэ хийн өгч, эртний аялгуу тоглож сургасанд талархав. Тэгээд Мирамисдаа мордон, дахин замд гарлаа. Нонно ард лимбээ үлээсээр үлдэв. Тэр ая аажим аажмаар замхарлаа.

- Бидэнд лимбэ маш хэрэгтэй. Бие биенээсээ төөрвөл энэ аяыг л тоглоно шүү гэж би Юм-Юмд хэлэв. Юм-Юм мориноосоо унахгүйн тулд намайг тас тэвэрсэн



байлаа. Тэр толгойгоо миний нуруунд наагаад,

- Тийм ээ Мио, хоёулаа лимбэнийнхээ аялгууг сайн сонсч явна шүү. Хэрэв намайг хөгжимдвөл дуудаж байна гэж ойлгоорой гэв.

- Тэгнэ ээ, чи бас хөгжимдөхийг минь сонсвол дуудаж байна гэж бодоорой гэж би хэлэв.

- За гэж Юм-Юм хариулаад намайг чанга тэврэв. Тэр бол миний хамгийн сайн найз. Гэхдээ би хаан аавдаа хамгаас илүү хайртай гэж бодож явлаа. Харин Юм-Юм бол над шиг л нэгэн жаал бөгөөд Бэнкатай уулзахаас нэгэнт өнгөрсөн болохоор миний хамгийн сайн найз болсон юм.

Надад аав, Юм-Юм, Мирамис байна, би нов ногоон зүлгэн дээгүүр салхи мэт хурдлан давхиж байж гэж төсөөл дөө. Намайг аз жаргалтай байгаад гайхах юмгүй байгаа биз.

- Голын цаадах, уулын ар дахь оронд яаж очдог вэ? гэж би асуулаа.

- Үүрийн гэгээний гүүрээр дамжина гэж Юм-Юм хариулав.

- Үүрийн гэгээний гүүр хаана байдаг юм? гэхэд,

- Бид удахгүй үзэх болно гэж Юм-Юм хариу өгөв. Тэгээд бид түүнийг олж харлаа. Тэр нь эхлэл төгсгөл нь харагдахгүй уртаас урт, өндрөөс өндөр гүүр байв. Өглөөний наранд гялалзаад, алтан өнгийн туяагаар барьсан мэт харагдлаа.

- Энэ нь ертөнцийн хамгийн урт гүүр. Энэ гүүр Ногоон нугын арлыг голын тэртээ орших оронтой холбодог. Шөнө болохоор харин манай эзэн хаан биднийг тайван унтуулахын тулд гүүрээ татаж авдаг юм гэж Юм-Юм

надад тайлбарлав.

- Яагаад? Шөнө хэнийг ирүүлэхгүй гэж?

- Дээрэмчин Катог гэж Юм-Юм хариулав.

Тийнхүү хэлэнгүүт хүйтэн салхи үлээж, Мирамис чичирч эхлэв. Би анх удаа тэр нэрийг сонслоо. Би дээрэмчин Като гэж чанга хэлэхэд даарч эхлэв.

- Тийм ээ, догшин дээрэмчин Като гэж Юм-Юм хэлэв. Мирамис тэнгэр нуртал чанга янцгаав. Тэгэхлээр нь бид хоёр дээрэмчин Катогийн тухай яриагаа дуусгав.

Үүрийн гэгээний гүүрээр давхихыг би хүслээ. Гэхдээ ааваас зөвшөөрөл авах хэрэгтэй байв. Бид сарнайн цэцэрлэгтээ буцаж ирээд, тэр өдөр дахин морь унасангүй. Бид хоёр Мирамисыг сойздон угааж, алтан дэлийг нь самнаад, Юм-Юмын ээжээс авсан ёотон, талхны захыг өглөө.

Дараа нь Юм-Юм бид хоёр сарнайн цэцэрлэгт



овоохой бариад, дотор нь орж, чихэртэй, нимгэн өндөгний шарвин идлээ. Ямар сайхан амттай гээ. Бэнкагийн ээж бас дандаа ийм өндөгтэй шарвин хийж, би хааяа түүнээс нь иддэг байсан. Харин Юм-Юмын ээжийн хийсэн нь бүр илүү амттайхан.

Овоохой барих их зугаатай. Би ингэх юм сан гэж дандаа хүсдэг. Бэнка надад Ваксхольм дахь зуслангийн байрныхаа гадаа яаж овоохой босгодог байсныг их ярьдаг сан. Би түүнд Юм-Юм бид хоёрын босгосон овоохойн талаар бичихийг үнэхээр их хүслээ. "Найз аа! Алс холын оронд ямар гоё овоохой барьсан гээч" гээд л бичиж гарна.



Одод бас хөгжимд дуртай юу?

Маргааш нь бид Нонног зорьж давхив. Очингуутаа түүнийг олсонгүй. Толгодын цаанаас харин хөгжимдөх нь сонстлоо. Хөгжмийн яруу эгшигт хонин сүрэг нь тойрон бэлчинэ. Биднийг хараад тэр лимбэдэхээ больж, инээмсэглэн,

- Өө, та хоёр хүрээд ирэв үү? гэв.

Дахин ирсэнд маань баярлаж байгаа нь илт байлаа. Бид хоёр бас лимбээ гаргаж, гурвуулаа хөгжимдлөө. Аялгуу чихэнд улам чимэгтэй болж, бид ийм гоё ая тоглож буйдаа өөрөө өөртөө гайхан байлаа.



- Бидний ийм сайхан хөгжмийг хэн ч сонсохгүй нь харамсалтайяа гэж би хэлэв.

- Өвс биднийг сонсч байна. Цэцэгс, салхи, усан дээр унжих уд мод ч мөн адил биднийг сонсч байгаа гэж Нонно хариулав.

- Нээрэн үү? Тэдэнд таалагддаг болов уу? гэж намайг сонирхоход,

- Тийм ээ, тэд маш дуртай гэж Нонно хэлэв.


Бид өвс, цэцэгс, салхи, модонд зориулж удаан хөгжимдлөө. Бидний хөгжмийг сонсох хүн байхгүй нь надад харамсалтай санагдлаа.

- Хэрэв хүсвэл манайд очоод, миний эмээд тоглож өг. Би эмээ дээрээ байдаг юм гэж Нонно өгүүлэв.

- Танайх эндээс хол уу? гэж би лавлав.

- Тийм ээ, гэхдээ бүгдээрээ зам зуур хөгжимдөн явбал дөт болно гэж Нонно хэлэв.

- Тэгье тэгье, удахгүй биз! Бид харин замдаа лимбэдэх л хэрэгтэй гэж Юм-Юм санал болгов. Тэр ч,



би ч Нонногийн эмээгийнд очихыг хүсч байв.

Үлгэрт сайхан сэтгэлтэй эмээ дандаа гарч байдаг шүүдээ. Тэд олон байдаг ч би бодит амьдралдаа жинхэнэ эмээтэй ер учирч байсангүй. Тийм учраас Нонногийн эмээгийнд очих надад маш сайхан санагдлаа.

Нонно хурга, хонь, Мирамисыг дагуулан явцгаахад жингийн цуваа мэт харагдав. Эхэнд нь Юм-Юм, Нонно бид гурав, хойноос нь хонь, хурга, хамгийн сүүлд нь Мирамис бараг Каллэ Пунт шиг удаан явав. Бид лимбээ үлээн толгод даван алхалж явлаа. Хаачих гэж яваг хурганууд мэдэх гэсэн мэт урд хойноо орон гүйдэнэ. Тийнхүү явах нь зугаатай байсан тул биднийг тойрон майлан гүйдэх нь цаанаа л нэг цоглог. Хэчнээн ч олон толгодыг ардаа орхив, бүү мэд. Олон цаг явсаар эцэст нь Нонногийнд ирлээ. Сүрлэн дээвэртэй бяцхан байшингийн өмнө голт бор, мэлрэг цэцэгс алаглаад яг л

үлгэрт гардаг шиг.

- Чишш! Чимээгүй, эмээд бэлэг барья гэж Нонно хэлэв.

Гэрт ямар нэг хүн байгаа нь нээлттэй цонхны цаанаас мэдэгдэв. Нонно Юм-Юм бид гурав цонхны өмнө нэг эгнээ болж зогслоо.

- Нэг, хоёр, гурав. Одоо бүгдээрээ эхэлцгээе гэж Нонно хэлэв.

Ингээд бид нэгэн баясгалант ая тоглолоо. Хурганууд бүжиглэж, үсэрч гарав. Харахад эелдэг байрын нэг эмгэн цонхны цаанаас харагдав. Тэр нь Нонногийн эмээ байсан бөгөөд алга ташиж,

- Хөөх, ямар сайхан хөгжим бэ гэлээ.

Бид түүний сонорыг сайхан аялгуугаар мялааж, түүнийг эмээ цонхны дэргэд зогсон, сонслоо. Өндөр настай тэр жинхэнэ эмээ үлгэрийн мэт харагдана.

Удалгүй бид гэрт орлоо. Нонногийн эмээ биднээс,

- Өлсөж байна уу? гэж асуухад,

- Тийм гэгцгээв. Тэр талх гаргаж ирээд, том том зүсэн таваглаж бидний өмнө тавив. Амьдралдаа идэж үзээгүй тийм амттай талх байлаа.

- Ямар сайхан амттай юм бэ. Энэ ямар талх вэ? гэхэд,

- Бусад талхнаас ялгаатай эсэхийг яаж би мэдэх билээ. Бид үүнийг "цатгадаг талх," гэдэг гэж Нонно хэлэв.

Мирамис ч гэсэн мөн адил юм идэхийг хүсч буй бололтой. Толгойгоо нээлттэй цонхоор оруулж, намдуухан янцгаав. Тэр инээдтэй харагдсан тул бид хөхрөлдөв. Нонногийн эмээ Мирамисын хамрыг илж,

талхнаасаа өгөв. Миний ам цангаж, Ноннод хэлтэл тэр,

- Нааш ир! гэлээ.

Биднийг цэцэрлэг ороход, тэнд тунгалаг булаг оргилж байв. Нонно модон хувингаар ус хутгаж авлаа. Бид уснаас нь залгилав. Би амьдралдаа ийм сайхан дотор сэнгэнүүлсэн хүйтэн ус ууж байсангүй.

- Ямар сайхан юм бэ. Энэ ямар булаг вэ? гэхэд,

- Булаг булгаас нэг их өөр гэж үү? Бид үүнийг "амны цангаа тайлдаг булаг," гэлцдэг юм гэж Нонно хариулав.





Мирамис ч гэсэн цангасан тул хонь хурганы хамт уснаас уулаа.

Удалгүй Нонно хонио бэлчээхээр гарах болов. Тэгээд шөнө хонио бэлчээхдээ нөмөрч унтдаг нөмрөгөө эмээгээсээ асуув. Эмээ нь нэг бор нөмрөг өгөв. Нонно хээр хонохдоо баярладаг байх даа гэсэн бодол надад төрлөө. Би хэзээ ч тэгж байсангүй. Бэнка хааяа ээж аавтайгаа хамт дугуйн аялалаар явж, майханд хонодог. Тэд ойн захад майхнаа босгож, шөнө болохоор аяны хөнжилдөө ордог. Бэнка үүнээс илүү сайхан юм гэж байхгүй гэдэг сэн.

- Би ч гэсэн шөнө гадаа хонож үзэх юм сан гэж би Ноннод хэлэв.

- Болно шүү дээ. Хамт явцгаая! гэж Нонно уриалав.

- Үгүй дээ, аав намайг гэртээ харихгүй бол санаа нь зовно гэж би хэлэв.

- Би эзэн хаанд очоод чамайг өнөө шөнө гадаа хонуулаач гэж гуйя хэмээн Нонногийн эмээ өгүүлэв.

- Миний аавд бас хэлэх үү? гэж Юм-Юм асуулаа.

- Сарнайн цэцэрлэгийн цэцэрлэгчид бас хэлнэ ээ гэж Нонногийн эмээ амлав.

Юм-Юм бид хоёр баярласандаа хурганаас илүү өндөр харайж үсрэв. Гэтэл Нонногийн эмээ бидний өмсөж явсан богино цагаан хүрмийг хараад,

- Шүүдэр буувал та хоёр даарна даа гэв. Тэгснээ царай нь гуниглангуй болж аяархнаар,

- Надад өөр хоёр нөмрөг бий гээд өрөөний буланд байсан нэгэн хуучин авдраас нэг нь улаан, нөгөө нь цэнхэр хоёр нөмрөг гаргалаа.

- Миний ах нарынх гэж Нонно хэлээд дуугүй болон

доош харав.

- Ах нар чинь хаана байгаа юм? гэж би асуув.

- Дээрэмчин Като. Хэрцгий дээрэмчин Като тэднийг булааж авсан юм гэж Нонно шивнэв.

Түүнийг сонсмогцоо Мирамис гаднаас ташуурдуулсан мэт чанга янцгаав. Хурганууд эх үрүүгээ гүйлдэж, хонинууд эцсийн мөч нь ирсэн мэт майлалдав.

Нонногийн эмээ надад улаан, Юм-Юмд цэнхэр нөмрөг өглөө. Тэр Ноннод цатгадаг талхнаасаа нэжгээдийг, амны цангаа тайлдаг булгийн уснаас нэг домбыг өгөхөд, бид ирсэн замаараа буцлаа.

Нонногийн ах нарт тохиолдсон явдлыг сонсоод би



уйтгарт автав. Гэхдээ би гадаа унтах болсондоо баяртай байлаа.

Удын найлзуур усанд шүргэн алдсан газар бид ирлээ. Нонно бидэнд энд хононо гэв.

Бид дүрэлзсэн их түүдэг гал асаав. Бид галын дэргэд сууж цатгадаг талхнаасаа идэж, амны цангаа тайлдаг булгийн уснаасаа уулаа. Шүүдэр бууж, бүрэнхий ч болов. Гэвч галын дэргэд дулаахан, гэрэлтэй байлаа. Бид нөмрөгөө нөмөрч, галдаа ойртлоо. Хонь хурганууд нойрмоглон, Мирамис нэг их холгүй бэлчинэ. Бид хажуулж өвсөөр наадах салхин шивнээг сонсч, алсад очтон гялалзах түүдэг галыг харлаа. Ногоон нугын арал малчдаар дүүрэн тул тийнхүү олон түүдэг гал дүрэлзэн гэрэлтэнэ. Хоньчдын мянга мянган жилийн урьдаас тоглож ирсэн гэж Нонногийн ярьж байсан ая харанхуйн дундаас тодхон сонстож байлаа. Үл таних малчдын хөгжимдөхийг шөнөжин сонсч хэвтэхэд таатай. Тэр ая надаас нэг л юм хүсээд байх мэт санагдав.

Тэнгэрийн одод томоос том хэлбэртэй, тодоос тод гэрэлтэй харагдав. Би түрүүлгээрээ харж, нөмрөгөө нөмрөн дулаахан хэвтээд оддыг харж байлаа. Өвс, цэцэгс, салхи, модонд зориулж хөгжим тоглосноо би санав. Нонно тэдэнд лав таалагдсан гэж хэлж байсан. Харин бид одод ертөнцөд хандан хөгжимдөөгүй. Одод бас хөгжимд дуртай болов уу? гэж би Нонногоос асуухад,

- Тийм байх аа гэж хариулав. Бид өндийж суугаад, лимбээ гарган одод зориулсан нэг аялгуу тоглолоо.

Үдэш үлгэр шивнэдэг худаг

Голын цаана, уулын ард орших орныг би үзээгүй. Нэг өдөр аавтайгаа сарнайн цэцэрлэг дундуур зугаалах үедээ түүнээс,

- Үүрийн гэгээний гүүрээр давхиж болох уу? гэж асуулаа. Аав миний толгойг хоёр гараараа барьж ихэд эелдэгхэн, ихэд бодлогошронгүй харав.

- Мио, чи миний эзэнт гүрэнд дураараа явж болно. Чи Ногоон нугын арал дээр тоглож, голын цаана орших оронд очиж, уулын араар морь унаж дураараа давхи. Мирамисын хүрэх газар, зүүнээс баруун, өмнөөс хойд зүг үрүү давхиж болно. Гэвч чи нэг л зүйлийг битгий март! Харанхуй орон гэдэг нэг газар бий гэж хэллээ.

- Тэнд хэн амьдардаг юм бэ? гэж би сонирхов.

- Дээрэмчин Като, хэрцгий дээрэмчин Като гэхэд аавын нүүр сүүдэртэх шиг болов.

Тэр энэ нэрийг хэлмэгц сарнайн цэцэрлэгт ямар нэг муу юм, аюул занал нүүрлэх шиг боллоо. Цагаан шувууд үүрэндээ орлоо. Хар шувуу чанга дуугарч, том хар далавчаа дэвэв. Тэр мөчид олон сарнайн дэлбээ тасарч унав.

- Мио, чи бол надад байгаа бүхний хамгийн үнэтэй нь. Дээрэмчин Катогийн тухай бодохоор зүрх шимшрээд ирэх юм гэж аав хэлэв.

Мөнгөн улиангар модод шуурганд автсан мэт

шуугив. Навчис тасран, газар унах нь хэн нэгний уйлах мэт зэвүүн. Като дээрэмчинг бодохоос надад маш их айдас төрлөө.

- Таны зүрх шимширч зовоогоод байвал түүний талаар бодох хэрэггүй гэж би хэлэв,

Аав толгой дохин гар бариад,

- Чиний зөв. Түр зуур ч гэсэн түүний тухай бодлоо орхиё доо. Харин чи лимбэдэж, сарнайн цэцэрлэгтээ овоохой барьж тоглоорой гэв.

Дараа нь бид хоёр Юм-Юмыг хайхаар явлаа.

Хаан аав эзэнт гүрэндээ хийх ажил мундахгүй ч надад ямагт цаг гаргадаг. Тэр хэзээ ч "Би завгүй байна!" гэж хэлдэггүй. Надтай хамт байх дуртай. Өглөө бүр сарнайн цэцэрлэг орж, шувууд үүрээ хаана барьсныг зааж өгч, бидний овоохойг үзэж, Мирамис морио яаж унахыг зааж, Юм-Юм бид хоёртой бүхний талаар ярилцдаг билээ. Тэр Юм-Юмтай бас дотно байдаг нь надад их таатай байдаг. Бэнкагийн аав надад бас ямагт дотно ханддаг байлаа. Хэдийгээр миний аав боловч чамтай харьцаж байгаа нь надад таалагдаж байна гэх шиг Бэнка ч сэтгэл хангалуун харагддаг сан. Миний аав Юм-Юмтай ярилцахад надад яг л тийм сэтгэгдэл төрдөг.

Юм-Юм бид хоёр улс дотроо морин аялал их хийдэг. Тэгэхгүй бол хаан аавд их эзэнт улсаа авч явах цаг яаж гарах вэ? Бид хэрэв дандаа гэртээ өнждөг сөн бол надтай тоглож, ярилцаар хамаг хийх ажлаа мартах ч юм билүү. Надад Юм-Юм, Мирамис хоёр байгаа нь юутай сайхан бэ.

Өө, миний Мирамис! Би түүн дээр мордоод яаж

давхидаг гээч! Мирамис намайг Үүрийн гэгээний гүүр лүү анх удаа авч явсныг би хэзээ ч мартаггүй.

Үүр цайхад, манаачид нь гүүрээ дөнгөж буулгачхаад байсан юм. Өвсөнд буусан шүүдэрт Мирамисын алтан туурай норсон ч зүв зүгээр байлаа. Юм-Юм бид хоёр эрт боссон тул бага зэрэг нойрмогдуу байв. Харин цэнгэг сайхан агаар нүүрийг минь илэн таална. Нугын дундуур давхихад нойрмог байдлаас салсан байлаа. Нар мандахад бид Үүрийн гэгээний гүүрэн дээр ирэв. Гүүрээр гарахад алтран гэрэлтэх туяан дундуур давхих мэт санагдав. Гүүр өндрөөс өндөрт байх тул доошоо харвал толгой эргэнэ. Энэ бол ертөнцийн хамгийн өндөр, хамгийн урт гүүр билээ. Мирамисын алтан дэл наранд гялалзана. Өндрөөс өндөрт, хурднаас хурдан давхисаар бид гүүрэн дээгүүр гарлаа. Мирамисын туурай аянгын дуу мэт тачигнана. Энэ бүхэн гайхалтай сайхан байлаа. Удахгүй, тун удахгүй би голын тэртээх орныг үзнэ.

"Юм-Юм, чи сэтгэл хангалуун байна уу? гайхалтай байгаа биз ... "

Тэгтэл би аюул нүүрлэж буйг олж харлаа. Мирамис чанх дээш ангал тийш давхина. Гүүр тасарч үзэгдлээ. Агаар дунд тасарсан гүүрийг манаачид нь эргүүлэхээ мартжээ. Голын цаадах орон хүртэл бас л зайтай. Гэтэл гүүр алга болж байдаг. Эцэс төгсгөлгүй гүнзгий ангал л харагдана. Би хэзээ ч ингэж айж байсангүй. Юм-Юмыг дуудах гэсэн боловч дуу гарсангүй. Мирамисын жолоог татаж зогсоох гэсэн ч хүслээр минь болсонгүй. Тэр чанга янцгааж, улам хурдлан давхина. Туурай нь тачигнаад үнэхээр аймаар. Удалгүй бид ангал уруу

унах нь бололтой. Би нүдээ аниад хаан ааваа бодлоо. Мирамисын туурай аянга мэт дуугарна.

Гэнэт чимээгүй боллоо. Туурайны оронд өөр чимээ гарлаа. Мирамис ямар нэгэн зөөлхөн юман дээр давхих шиг болов. Нүдээ нээтэл, Мирамис агаарт цогиж байлаа. Алтан дэлтэй Мирамис минь агаарт газар дээрээс ялгаагүй намалзан давхина. Хэрвээ хүсвэл үүлэн дээгүүр дүүлэн, оддын дундуур цойлон явж чадна. Тийм морь хаа ч байхгүй. Түүний нуруун дээр агаарт нисч, голын цаадах орныг үзэхээр нарны туяатай айлсан явж байхад ямар сайхан байдгийг хэн ч мэдэхгүй дээ.

- Юм-Юм! Мирамис үүлэн дундуур давхиж чаддаг юм байна! гэж би хэллээ.



- Чи мэддэггүй байсан юм уу? гэж Юм-Юм нэг их гайхсан шинжгүй надаас асуув.

-Үгүй, би яаж мэдэх юм бэ гэж намайг хариулахад Юм-Юм инээв.

- Мио, чи ер нь бага мэдэж байна шүү гэж тэр хэллээ.

Бид тэнгэрээр зөндөө давхиж, Мирамис бяцхан цагаан үүлс дээгүүр дүүлж, тун ч зугаатай байлаа. Сүүлд нь бид газар буухыг хүсэв. Мирамис алгуурхан доошилж газарт буулаа. Бид голын цаадах оронд ирсэн байв.

Алтан дэлтэй Мирамис чинь энэ нугад үлдэг. Хоёулаа Йири дээр очоод ирэх хооронд морь маань өвс идэж байг гэж Юм-Юм хэлэв.

- Йири гэж хэн юм бэ? гэж би асуув.

- Чи харах болно оо. Йири болон түүний ах дүү нар энд байдаг юм аа гэж Юм-Юм надад тайлбарлав.

Намайг тэр хөтөлсөөр нэгэн байшингийн гадаа авчрав. Яг л үлгэрт гардаг шиг сүрлэн дээвэртэй жижигхэн цагаан байшин байлаа. Байшин яагаад үлгэрийнх мэт харагддагыг тайлбарлах нь илүүц биз ээ. Агаар юм уу, байшин тойрсон модод юм уу, гайхалтай сайхан үнэртэх цэцэрлэг дэх цэцэгс юм уу эсвэл өөр юм ингэж харагдуулж байна уу? Йиригийн байрны өмнө эрт цагийн нэгэн дугуй худаг харагдав. Энэ худаг л бараг Йиригийн байшинг үлгэрийн юм шиг харагдуулж байна гэж би бодлоо. Учир нь иймэрхүү хуучин худаг энэ хир байхаа больсон, урьд нь би ганцыг ч хараагүй.

Таван хүүхэд худаг тойроод сууж байлаа. Хамгийн том нь нэг жаал хүү инээж үзэгдэнэ. Тэр нь их аятайхан харагдав.

Та хоёрын ирж явааг би харсан. Сайхан морьтой юм гэж тэр хэлэв.

Мирамис гэдэг юм. Энэ бол Юм-Юм, намайг Мио гэдэг гэж би хариулав.

Би мэднэ ээ. Намайг Йири гэдэг, эд нар миний ах дүүс гэж жаал хүү өгүүлэв.

Йири болон түүний ах дүүс биднийг хүрэлцэн ирсэнд баярласан мэт найрсаг хандаж байлаа.

Уппландсготан гудамжинд суудаг байхад хэзээ ч тийм найрсаг байдал угтаж байсангүй. Дотно танил бус хүүхэд хажуугаар нь зөрөхөд тэндхийн хөвгүүд чоно мэт архиралдана. Тэд заавал хэн нэгнийг гадуурхаж, тоглоомондоо оролцуулахгүй хавчдаг билээ. Би голдуу тэдний золиос болдог байж билээ. Надтай тоглохыг хүсдэг цорын ганц нь Бэнка. Тэнд Яннэ гэдэг нэг том хөвгүүн байдаг сан. Би түүнд ямар ч муу юм хийгээгүй атал тэр намайг харуутаа л "Эндээс зайлаарай, тэгэхгүй бол ухаан алдтал чинь дэлсээд өгнө шүү!" гэж загнана.

Иймээс би тэдэнтэй хамт тоглоё гэж оролдохоо ч больсон. Бусад хөвгүүд бүгд Яннэгийн талд орж, түүний амаар болдог. Яагаад гэвэл Яннэ тэдэн дундаа хамгийн том нь юм чинь.

Яннэ мэт яхиржаалуудтай харьцаж байсан болохоор Йири, Юм-Юм, Нонно, Йиригийн ах дүүс гээд дандаа найрсаг зантай хүүхдүүдийг хараад үнэхээр их гайхсан билээ.

Юм-Юм бид хоёр Йиригийн хажууд очиж худгийн ирмэг дээр суулаа. Худаг уруу тонгойж харахад ёроол нь харагдахгүй гүнзгий байв.

- Та нар усаа эндээс яаж гаргаж авдаг юм бэ? гэж



би асуув.

- Бид нар эндээс ус гаргаж авдаггүй. Энэ бол усны худаг биш л дээ гэж Йири хариуллаа.

- Тэгвэл юуны худаг юм бэ?

- Бид нар түүнийг Үдэш үлгэр шивнэдэг худаг гэдэг юм.

- Яагаад?

- Орой болохоор чи мэдэх болно оо.

Бидийнхүү ярилцаад Йири болон түүний ах дүүсийнд өдөржин зочилж, хөгшин моддын дор сайхан наадаж тоглолоо. Биднийг өлсөхөд Йиригийн дүү Минонна-Нэлль гал тогоо уруугаа гүйж ороод, талх авчирч өгөв. Тэр нь бас л цатгадаг талх тул би урьдын адил дуртайяа амтлан идлээ.

Модны доорх өвсөн дундаас би нэг жижиг мөнгөн



халбага оллоо. Түүнийгээ Йирид үзүүлтэл түүний царай маш гунигтай болоод явчхав.

- Манай дүүгийн халбага байна гэж тэр хэлэв.

- Мио дүүгийн маань халбагыг олжээ! гэж тэр ах дүүстээ хэлэв.

- Танай дүү чинь хаана байгаа юм бэ?

- Дээрэмчин Като. Хэрцгий дээрэмчин Като түүнийг булаасан юм гэж Йири хэлэв.

Тэр энэ нэрийг дурдмагц агаар мөс шиг цэл хүйтэн болов. Түүгээр ч барахгүй цэцэрлэгт ургаж байсан том наран цэцэг хатаж үхэв. Тэгээд бас зөндөө олон эрвээхий далавчаа гээн нисч чадахаа болив. Би тэр дээрэмчин Катогоос маш их айж эхлэв.

Йирид жижиг мөнгөн халбагыг өгтөл, тэр:

Чи манай дүүгийн халбагыг ав даа. Түүнд одоо наадах чинь хэзээ ч хэрэг болохгүй, чи харин олсноороо аваарай хэмээв.

Отгон дүүд нь халбага хэзээ ч хэрэг болохгүй гэдгийг сонсоод Йиригийн ах дүүс уйллаа. Гэвч бид тоглож эхлээд тэрхүү гунигт явдлыг умартав. Халбагыг би халаасандаа хийгээд удалгүй түүнийг мартлаа.

Гэхдээ би тоглож эхлэхээсээ л орой хурдан болоосой гэж бодож байсан юм. Учир нь би тэр учир битүүлэг худгийн талаар мэдэхийг хүссэнийх.

Өдөр өнгөрч, оройн бүрий ч орлоо. Йири болон ах дүүс нь бие бие үрүүгээ нэг л жоготой хараад,

- Одоо! гэлээ.


Тэд бүгдээрээ худаг уруу очиж, ирмэгт нь суулаа. Юм-Юм бид хоёр бас хажууд нь суув.

- Чив чимээгүй байгаарай! гэж Йири анхааруулав.

Бид чив чимээгүй сууж хүлээж эхэллээ. Хөгшин моддын дунд улам харанхуй болж, Йиригийн байшин жинхэнэ үлгэрийн юм шиг харагдав. Үдшийн гэгээ тасрах цагт тас харанхуй бус, харин саарал, нэг л сонин харуй бүрий орлоо. Байшин, модод, ялангуяа бидний ирмэг дээр нь тойрон суугаа худгийг нэг л зэгэл саарал, хуучин юм бүрхсэн мэт буй нь гайхмаар.

- Чив чимээгүй байгаарай! гэж Йири биднийг түрүүнээс хойш юу ч яриагүй байхад хэллээ. Ингээд бид ямар ч чимээ анир гаргалгүй сууцгаагаад л, улам харанхуй нөмрөөд л, чив чимээгүйд юу ч үл сонсогдоно.

Гэнэт би нэг юм сонслоо. Тийм ээ, надад нэг юм



дуулдлаа. Худгийн ёроолоос шивнэх чимээ сонслоо. Гүн гүнзгийгээс шивнэх, бөвтнөх чимээ дуулдав. Юутай ч зүйрлэшгүй тийм нэгэн гайхалтай хоолой байлаа. Ингээд тэр хоолой ертөнц дээрх бүх үлгэрээс сайхан, алинтай нь ч зүйрлэшгүй сонин үлгэрүүд шивнэж эхэллээ. Надад үлгэрээс илүү дуртай юм гэж бараг байхгүй дээ. Би тэр шивнэх хоолойг сайтар сонсох гэж худгийн ирмэг үрүү улам тонгойлоо. Үе үе тэр хамгаас сонсголонтой, хачирхалтай дуу дуулна.

- Энэ ямар шидтэй худаг вэ? гэж би Йиригээс шивнэн асуулаа.

- Үлгэр, дуугаар дүүрэн худаг, миний мэдэх нь л тэр. Олон жилийн өмнө ертөнц дээр байж байгаад аль хэдийн алга болсон мартагдсан үлгэр, дуугаар дүүрэн худаг. Үдэш үлгэр шивнэдэг энэ худаг л тэдгээрийг мэднэ гэж Йири хэлэв.

Хэдий болтол сууснаа би мэдэхгүй байна. Моддын дундах харанхуй ихэсч, худагнаас гарах дуу улам намдсаар. Ингээд тэр дуу тасарлаа.

Хажуугийн ногоон нугаас Мирамис янцгаав. Хаан аав дээрээ эргэж очих цаг болсныг тэр надад сануулж байх шиг байна.

- Сайн сууж байгаарай, Йири. Минонна-Нэлль, бүгдээрээ сайн сууж байгаарай!

- Сайн яваарай Мио, сайн яваарай Юм-Юм. Удахгүй дахиад ирээрэй!

- Тэгнэ ээ, бид удахгүй дахиж ирнэ ээ гэж би хариулав.

Бид хоёр Мирамис мориндоо мордоод, буцах замдаа хурдлан давхив. Сар гарч, ногоон нуга, аниргүй



моддыг гэрэлтүүлэн байлаа. Тэдгээр мод аавын сарнайн цэцэрлэг дахь мөнгөн улиангар мэт гэрэлтэнэ.

Бид Үүрийн гэгээний гүүрэн дээр ирэхэд би түүнийг бараг таньсангүй. Тэр их өөрчлөгджээ. Түүнийг мөнгөн туяагаар барьсан мэт харагдана.

- Шөнө болохоор гүүр өөр нэртэй болчихдог гэж Юм-Юм гүүрээр гарах зуур хэллээ.

- Шөнө ямар нэртэй вэ? гэж би асуув.

- Сарны туяан гүүр гэж Юм-Юм хариулав.

Бид Сарны туяан гүүрээр давхилаа. Гүүрийг манаач нар удахгүй хураана. Ногоон нугын арал дээрх малчдын түүдэг гал алсад жижиг дөл мэт анилзана. Ертөнц тэр чигээрээ чив чимээгүй, гүүрэн дээр нижигнэх Мирамисын туурайнаас өөр юу ч үл сонстоно. Мирамис сарны туяанд хий үзэгдлийн морь мэт бас алтан бус мөнгөн дэлтэй харагдана.

Би Үдэш үлгэр шивнэдэг худаг, сонссон бүх үлгэрийнхээ тухай бодож эхэллээ. Нэг үлгэр надад гоц таалагдсан юм. Тэр үлгэр ингэж эхэлдэг юм.

Эрт урьд цагт морьтой нэгэн ханхүү сарны гэрэлд алс хол газар давхинам ...

Тэр нь бараг би байж болохоор байгаа биз! Би чинь хан хүү мөн шүү дээ.

Ногоон нугын аралд улам ойртсоор, Мирамисын туурай аянга мэт нижигнэнэ. Сэтгэлд минь нийцсэн тэр нэгэн сайхан үлгэр толгойноос минь гардаггүй.

Эрт урьд цагт морьтой нэгэн ханхүү сарны гэрэлд алс хол газар давхинам...

Харанхуй ой дундуур давхисан нь

Би Сикстэн ах, Эдла эгчтэй хамт суудаг байхдаа хотын номын сангаас үлгэрийн ном авч уншдаг байлаа. Харин Эдла эгч түүнийг нэг их таашаадаггүй байсан юм.

“Чи дахиад л номон дунд шигдээд суучхав уу. Хүүхдүүд гадаа бужигнаж байхад чи гардаггүй болоод л ийм жижигхэн, сул дорой, өрөвдөлтэй байгаа чинь тэр” гэдэгсэн.

Уг нь би ихэнх цагаа гадаа өнгөрөөдөг байсан юм. Сикстэн ах Эдла эгч хоёр намайг гэрт биш тэр чигээрээ гадаа байгаасай гэж боддог байсан байх. Харин одоо би тийшээ хэзээ ч очихгүй болсон тул тэр хоёр баярлаж суугаа биз.

Би зөвхөн орой үдшээр л ном гартаа барьж, бага зэрэг уншихыг хичээдэг байсан нь миний сул дорой байдлын учир шалтгаан яаж болоо аж. Эдла эгч одоо намайг хэчнээн том, хүчтэй бас эрүүл байгааг хараасай гэж би хүснэм. Хэрвээ би Уппландсготан гудамжинд суугаа хэвээрээсэн бол Яннэг нэг гараа нуруундаа уясан байсан ч өрөөсөн гараараа зодож дийлнэ. Гэхдээ би ингэхийг хүсэхгүй учраас ийм хэрэг хийхгүй л дээ.

Эдла эгч Үлгэр шивнэдэг худгийн тухай сонсвол юу гэж хэлэхийг нь мэдэх юм сан. Заавал гэртээ цонхийтлоо сууж ном уншихгүйгээр гадаа эрүүл агаарт зөндөө олон үлгэр сонсч болохыг мэддэгсэн бол юу ч сэтгэлд нь

нийцдэггүй Эдла эгчид хүртэл таалагдах байсан даа.

Тийм ээ, Алс холын оронд үлгэр ярьдаг нэгэн худаг байдгийг тэр мэддэг ч болоосой.

Эрт урьд цагт морьтой нэгэн ханхүү сарны гэрэлд алс хол газар давхинам. Тэр Харанхуй ой дундуур давхина...

Худаг тэгж өгүүлсэн. Энэ үлгэр миний оюун санаанд эргэлдсээр л байлаа. Энэ түүхээр дамжуулж худаг нэг онцгой зүйлийг надад хэлэх гэсэн мэт санагдана. Харанхуй ойгоор давхих ханхүү нь би юм шиг, үүнийг заавал биелүүлэх хэрэгтэй мэт. Худаг бүтэн оройжингоо надад юу хийх ёстойг сануулан ярьж, дуулсан мэт.

Би ааваасаа Харанхуй ой хаана байдгийг асуухад гуниглангүй харцаар намайг ширтэж,

- Харанхуй ой уулын чанад дахь оронд бий. Мио, чи энэ тухай мэдэж яах гэв? гэв.

- Өнөө орой сар гармагц би тийшээ давхиж очмоор байна гэж би хариулав.

Аав над уруу нэг л учиртай харав.

- Өө тийм хурдан уу? гэх нь улам ч гунигтай сонстлоо.

- Та дургүйцэж байна уу? гэж би лавлав.

- Намайг шөнө Харанхуй ойгоор давхина гэхлээр таны санаа зовж байна уу?

Аав толгой сэгсрэв.

Үгүй, чи яагаад тэгж бодов? Сарны туяанд амар амгалан нойрсох ой ямар ч муу юм хийхгүй гэж тэр хэлэв.

Тэгснээ гараараа толгойгоо барьсаар суугааг хараад маш гунигтай юм бодож байна даа гэж тааварлав.

Тэгэхлээр нь би аав дээрээ очиж гараа мөрөн дээр нь тавиад тайвшруулахыг оролдон түүнээс асуув.

- Та намайг гэртээ үлдээмээр байна уу?

Тэр над уруу гуниг тээсэн харцаар удаан гэгч ширтээд,

- Үгүй хүү минь, чи үлдэж болохгүй. Сар дээш хөөрч, Харанхуй ой чамайг хүлээж байгаа.

- Та гунигтай байна уу? гэж би асуулаа.

- Үгүй дээ гээд тэр миний толгойг гараараа илэв. Би Юм-Юмаас Харанхуй ой уруу хамт явах эсэхийг асуухаар гүйлээ. Намайг хэд алхтал,

- Мио хүү минь! гэж хашгирав.

Би эргэж харваас тэр миний хойноос гараа алдлаад зогсож байлаа. Би аав дээрээ гүйж очиход тэр намайг цээжиндээ наан удаан гэгч нь тэвэрлээ.

- Би удахгүй эргээд ирнэ шүү дээ гэж би хэлэв.

- Чи тэгнэ биз дээ? гэж аав шивнэн асуулаа.

Би Юм-Юмыг сарнайн цэцэрлэгийн цэцэрлэгчийн гэрээс олж, харанхуй ойг зорихоор шийдсэнээ дуулгав.

- Өө ашгүй дээ гэж Юм-Юм баярлав. Намайг Харанхуй ой уруу явах гэж байгааг хэлэхэд аав:

- Ийм хурдан уу? гэж Юм-Юм бас,

- Ашгүй дээ гэж хэлэх нь надад нэг л учир битүүлэг санагдлаа. Гэвч би тэр талаар удаан бодсонгүй.

- Чи хамт явах уу? гэж би Юм-Юмаас асуулаа.

- Юм-Юм уртаар амьсгаа аван,

- Тэгнэ ээ. Тэгье, Тэгье гэж хариулав.

Бид сарнайн цэцэрлэгт идшилж явсан Мирамисыг авчирч, түүнээс Харанхуй ой уруу хүргэж өгөхийг гуйлаа. Морь гэнэт цогиж эхэлсэн нь үүнээс илүү сайхан

зүйлийг удтал сонсоогүй гэлтэй байлаа. Ингээд Юм-Юм бид хоёр нуруун дээр нь мордоход тэр цахилгаан цахих мэт хурдлав.

Биднийг сарнайн цэцэрлэгээс гарч хурдлах үед "Мио!" гэж аавын минь хашхирах сонсдов. Тэр нь миний сонсч байсан бүх дуу хоолойноос хамгийн гунигтай нь байлаа. Гэхдээ би буцаж чадсангүй.

Уулын чанад дахь орон үнэхээр хол байлаа. Мирамис шиг морь байхгүй байсан бол бид тийшээ очиж чадахгүй байсан биз. Тэнгэр тулам өндөр уул уруу мацаж хэзээ ч чадахгүй сэн. Харин Мирамисын хувьд энэ нь юу ч биш байлаа. Тэр уулын орой дээгүүр шувуу мэт дүүллээ. Би түүнийг мөнх цастай хамгийн өндөр оргилд газардуулав. Бид Мирамисын нуруун дээрээс уулын хормойд биднийг угтах гэж байгаа орныг харлаа. Харанхуй ой бидний өмнө сарны гэрэлд үнэхээр үзэсгэлэнтэй, бас тийм ч их аюултай биш харагдлаа. Сарны гэрэлд амар амгалан нойрсох ой хэнд ч муу юм хийхгүй гэдэг нь үнэн байх нь ээ. Тийм ээ, аавын зөв байжээ. Энд хүмүүс төдийгүй бүх юм сайхан байлаа. Ой, нуга, горхи бас ногоон төгөл бүгд сайхан бөгөөд айх аюулгүй. Шөнө нь өдөр мэт сайхан, сарны туяа нар шиг гэрэлтэй, харанхуй нь ч гэсэн амар амгалан. Тэнд аймаар зүйл нэг их байсангүй.

Гэтэл айдас хүрмээр ганц л зүйл байлаа. Цорын ганц.

Мирамис мориндоо мордоход харанхуй ойн цаана амар амгалан бус хав харанхуй нөмөрсөн нутгийг харсан юм. Түүнийг харахад нэг л эвгүй жихүүдэс хүрмээр.

- Тэнд байгаа тэр аймаар ямар орон бэ? гэж би Юм-Юмаас асуув.

- Тэндээс Харанхуй орны хил хязгаар эхэлдэг гэж Юм-Юм хариулав.

- Дээрэмчин Катогийн орон гэж би хэлэв.

Мирамис даарч буй мэт чичрэхэд, хадны хэлтэрхий уулнаас ховхрон дуу чимээтэйгээр тэртээ доор харагдах хөндий үрүү өнхрөв. Тийм ээ, тэнд нэг л аюул байлаа. Тэр нь дээрэмчин Като. Түүнээс бүгд маш их айна. Гэхдээ би түүний тухай бодохгүй байхыг хичээлээ.

- Миний яг одоо очмоор байгаа газар бол Харанхуй ой гэж би Юм-Юмд хэллээ.

Мирамис уул цуурайттал сүрлэг дуугаар янцгаав. Тэгснээ алгуурхнаар уулын хормойд байрлах сарны туяагаар гэрэлтсэн ой уруу чиглэв. Хариуд нь тэр ойгоос зуун адуу янцгаах мэт чимээ гарав.

Мирамисын туурай модны оройг зөөлөн шүргэтэл улам доошилсоор л байлаа. Ногоон навчис дунд бид буулаа. Тийнхүү харанхуй ойд хүрэлцэн ирэх нь тэр.

Би ой хөвчөөр нэг их хэрэн яваагүй ч үүнтэй зүйрлэх ой үзээгүй. Харанхуй ой нэг нууцыг хадгалах мэт санагдана. Түүнийг нь сар халхлан байх мэт. Арай ч үгүй баймаар юм. Модон дунд сэрчигнэх чимээ гарч нууцыг нь шивнэсэн ч би юу ч ойлгосонгүй. Модод чимээ аниргүйд сэрийлцэн сарны туяанд гэрэлтэнэ. Тэд нууцыг нь мэдэж байгаа нь лавтай. Харин би юу ч мэдэхгүй байлаа.

Гэнэт холоос туурайн чимээ гарав. Шөнө дунд зуун адууны төвөргөөн гарах мэт. Мирамисыг янцгаахад хариу болгон зуун адуу янцгаах шиг болов. Туурайн төвөргөөн улам ойртсоор, янцгаах чимээ улам чангарсаар нэг л мэдэхэд Мирамис шиг намирсан дэлтэй зуун цагаан адуу





биднийг хүрээлэн ирэв. Мирамис адуун сүрэгт нийлэн бүгд ойн цоорхой уруу одов. Юм-Юм бид хоёр сарны туяанд модны доор зогсоод Мирамисын тэргүүлсэн цагаан адуун сүрэг ийш тийш давхилдахыг харлаа.

- Тэдэнд ямар сайхан байгаа бол? гэж Юм-Юм хэлэв.

- Юу нь сайхан гэж? гэж би асуув.

- Яагаад гэвэл Мирамис нутагтаа харьж ирсэн юм

чинь. Чи Мирамисыг харанхуй ойд амьдардаг байсан гэдгийг мэдэх юм уу? гэж Юм-Юм хэлэв.

- Үгүй ээ, би энэ тухай мэдэхгүй юм байна.

- Мио, чамд мэдэхгүй юм их байна аа гэж Юм-Юм надад хэлэв.

- Ингэхэд Мирамис яаж над дээр ирсэн юм бол? гэж би асуув.

- Манай эзэн хаан цагаан унаганаасаа нэгийг нь Ногоон нугын арал дээр очиж чинийх бол гэж зарлигдсан юм гэж Юм-Юм хэллээ.

Би Мирамисыг хэрхэн сарны туяанд баяр хөөртэй давхихыг хараад бодолд оров.

- Юм-Юм аа! Мирамис надтай хамт үлдэх болсондоо гунигтай байх болов уу? Тэр харанхуй ойдоо буцаж очихыг хүсдэг болов уу? гэж би асуув.

Тэр агшинд Мирамис над уруу ойртон ирэв. Тэр миний хүзүүн дээр толгойгоо тавиад аяархан янцгааж, удал зогсов.

- Харж байна уу, чамтай үлдэхийг хүсээд байгаа юм биш үү? гэж Юм-Юм хэлэв.

Би үүнийг сонсоод баярлав. Мирамисыг илээд ёотон өгөхөд тэр миний гараас зөөлөн уруулаараа авлаа.

Тэгээд ой дундуур цааш давхихад зуун цагаан адуу хойноос дагалаа. Биднийг давхиж ирэхэд ой мод, бидний дээгүүр зөөлнөөр сэрчигнэх ногоон далдуу мод, улиас, цагаан адуунууд, туурайн чимээнээр сэрсэн шувууд гээд бүгд л тэр нууцыг мэдэрч байлаа. Ганцхан би л юу ч мэдэхгүй. Юм-Юмын " Мио, чамд мэдэхгүй юм их байна аа" гэдэг нь үнэхээр үнэн байлаа.

Мирамис бусад адууны хамт давхилаа. Бид



хурдаллаа. Миний улаан нөмрөг модны мөчирт өлгөгдөв. Магадгүй мод намайг явуулахыг хүсэхгүй байна уу, эсвэл нууцаа ярьж өгөх гэсэн юм болов уу. Гэхдээ би яарч байсан тул огцом ухасхийсэнд нөмрөг минь урагдлаа.

Ойн цоорхойд яг л үлгэрт гардаг шиг сүрлэн дээвэртэй нэгэн жижиг цагаан байшин үзэгдэв. Эргэн тойронд алимны мод. Алимны цэцэгс сарны туяанд цайран гэрэлтэнэ. Онгорхой цонхоор нэгэн нижигнэсэн чимээ сонсож байв. Хэн нэгэн юм нэхэж байгаа ч юм шиг.

- Хэн юм нэхэж байгааг орж харах уу? гэж би Юм-Юмаас асуув.

- Тэгье л дээ.

Бид Мирамисын нуруунаас үсрэн бууж алимны модны дундах жимийг дагав. Биднийг хаалга тогшиход нөгөө чимээ алга болов.

- Бяцхан хөвгүүд ээ, нааш ороод ир. Би та нарыг хэчнээн удаан хүлээв дээ гэх дуулдлаа.

Бид байшинд орж, утас ээрч байгаа бүсгүйг харлаа. Сайхан зантай бүсгүй бидэн үрүү толгой дохилоо.

- Та яагаад шөнө дөлөөр утас ээрч байгаа юм бэ? гэж би асуув.

- Би зүүдэн хувцас нэхэж байна. Түүнийг зөвхөн шөнө л хийж болдог гэж хэлэв.

Цонхоор тусах сарны туяа тэр сонин хувцсан дээр



тусч үнэхээр гоё гялалзаж харагдлаа. Би түүнээс сайхан хувцас үзээгүй билээ.

- Та яаж ийм гоё нэхдэг юм бэ? гэж би асуув. Тэр хариулсангүй, харин үргэлжлүүлэн нэхсээр байлаа. Тэр нэхэх машинаа торжигнуулан ийнхүү дуулав:

*Зүрх сэтгэлээ шингээж
Зүүдний хувцас нэхэж байна.
Сарны мөнгөн туяа шиг
Сайхан хувцас болоорой.
Өвсөн толгой шүргэсэн
Шөнийн салхинаас хөнгөн.
Өтгөн ойд жиргэсэн
Гунигт шувууны дуу.*

Аядуу намдуу хэмнэлээр ийнхүү дуулсан нь тийм ч сайхан сонсогдсонгүй. Түүний дууг ойгоос өөр нэгэн аялгуу залган авав. Би түүнийг танилаа. Нэхмэлчний дуулснаар гунигт шувуу ойд жиргэн байв. Модны оройгоос зүрх шимшрэм дуу гарна.

- Гунигийн шувуу юун тухай дуулдаг вэ? гэж би нэхмэлчнээс асуув.

Тэгтэл тэр уйлж эхлэв. Нулимс нь хувцсан дээр дуслахад бяцхан сувд болон хувирч, даавуу урьд өмнөхөөс илүү гоё боллоо.

- Гунигийн шувуу юун тухай дуулдаг вэ? гэж би дахин асуув.

- Тэр миний хулгайлагдсан бяцхан охины тухай дуулж байгаа юм гэж нэхмэлчин эмэгтэй хэлснээ улам их уйлав.

- Хэн таны бяцхан охиныг хулгайлсан бэ? гэж би асуув. Хариуг нь би мэдэж байсан учраас сонсохыг

хүссэнгүй.

- Нэрийг нь битгий хэлээрэй гэж би түүнээс гуйлаа.

- Би хэлэхгүй ээ, эс тэгвээс сарны гэрэл алга болно. Сарны туяа алга болбол цагаан адуунууд цусаар уйлна гэж нэхмэлчин хэлэв.

- Яагаад цусаар уйлах гэж? гэж би асуув.

- Булаалгасан бяцхан унаганыхаа хойноос харамсан гашуудаж байгаа нь тэр. Чи гунигийн шувуу ойд хэрхэн дуулж байгааг сонс доо! гэж нэхмэлчин бүсгүй хэлэв.

Би нээлттэй цонхоор гунигийн шувууны дуулахыг сонслоо. Тэр сарнайн цэцэрлэгт надад дуу дуулж өгдөг байсан ч түүнийг нь би ойлгодоггүй байжээ. Харин одоо мэдлээ. Тэр дээрэмчин Катогийн өөрийн цамхагтаа хүчээр булааж аваачсан нэхмэлчний бяцхан охин, Нонногийн ах нар, Ийригийн дүү болон бусад олны тухай дуулж байсан юм байна.

Ногоон нугын арал, голын цаана, уулын ард орших орныхон тийм учраас гэр гэртээ гуниглан суудаг юм байна. Тэд алдагдсан бүх хүүхдүүдийнхээ төлөө гашуудах нь энэ аж. Харанхуй ой дахь цагаан адуунууд хүртэл алдагдсан нэгнийхээ төлөө гашуудаж, хулгайчийн нэрийг сонсох үедээ цусаар уйлдаг юм санж.

Дээрэмчин Като! Би түүнээс хэчнээн их айж байна аа. Маш их айж байна! Харин гунигийн шувууны дууг сонсч байхад надтай нэг гайхалтай явдал тохиолоо. Яагаад би шөнө дөлөөр Харанхуй ойг гаталж давхиснаа ойлголоо. Түүний цаана Харанхуй орны хил хязгаар эхэлдэг. Тийшээ явах ёстой. Би хэдийгээр үнэхээр их айж байвч дээрэмчин Катотай тулалдахаар явах хэрэгтэй. Тийм ээ, би маш их айж байлаа. Гэвч өөрийн

ях ёстойгоо бодохоор уйлмаар санагдлаа.

Нэхмэлчин хийж байсан ажлаа үргэлжлүүлээ. Тэр нэгэн хэмээр “Сарны гэрэл, сарангэрэл, зүрхний улаан цус” гэж аялан Юм-Юм бид хоёрыг анзаарахаа байв.

- Юм-Юм, би одоо Харанхуй орныг зорилоо гэж би хэлэв.

- Би мэднэ ээ гэж Юм-Юм хэлэв. Би бүр алмайрч орхив.

- Чи яаж мэдэв ээ? гэж би асуув.

- Би энэ шийдээ дөнгөж сая л гаргалаа шүү дээ.

- Мио, чамд мэдэхгүй юм их байна аа гэж Юм-Юм хэлэв.

- Гэхдээ чи, чи л бүхнийг мэдэх юм гэж би хэлэв.

- Тийм, би мэднэ ээ гэж Юм-Юм хэлэв.

- Чамайг харанхуй орон орохыг чинь аль хэдийнээс мэднэ ээ. Тэр тухай бүгд л мэдэж байгаа шүү дээ.

- Бүгдээрээ мэднэ гэнэ ээ?

- Тийм ээ, гунигийн шувуу мэднэ. Нэхмэлчин эмэгтэй мэднэ. Зуун цагаан адуу ч мэднэ. Харанхуй ой тэр аяараа мэднэ, моднууд энэ тухай шивнэж, өвс, алимны цэцэгс хүртэл мэдэж байсан.

- Тэд үнэхээр мэдэж байсан гэж үү? гэж би гайхшрав.

- Ногоон нугын арлын бүх малчид мэддэг бөгөөд энэ тухай шөнө лимбээрээ хөгжимддөг. Нонно, түүний эмээ, Ийри ба түүний ах дүүс, Үдэш үлгэр шивнэдэг худаг ч мэдэж байгаа. Ер нь бүгд л мэднэ.

- Тэгвэл миний аав...? гэж би шивнэв.

- Чиний хаан аав энэ тухай маш сайн мэддэг байсан гэж Юм-Юм хэлэв.

- Тэр намайг явуулахыг хүссэн гэж үү? гэж би асуулаа. Тийнхүү хэлэхэд хоолой минь чичигнэж байсныг ч нууж чадсангүй.

- Тийм ээ, тэр үүнийг хүссэн. Тэр хэдий гунигтай байгаа ч тийш явахыг чинь хориогүй гэж Юм-Юм хэлэв.

- Гэхдээ би үнэхээр их айж байна шүү дээ гэж би хэлээд уйлж гарав. Одоо л би өөрийнхөө хэчнээн их айсныг мэдрэв. Би Юм-Юмын гарыг атгалаа.

- Юм-Юм аа! Би чадахгүй нь ээ, аав заавал намайг явуулдаг нь ямар учиртай бол?

- Гагцхүү хааны удамтай хүүхэд л чадах учиртай гэж Юм-Юм хэлэв.

- Хэрвээ би амь үрэгдвэл яах вэ? гэж хэлээд Юм-Юмын гараас зуурлаа. Хариуд нь тэр дуугарсангүй.

- Миний аав тэгсэн ч гэсэн намайг яваасай гэж хүссэн гэж үү?

Нэхмэлчин эмэгтэй ажлаа зогсоож, байшинд чив чимээгүй болов. Гунигийн шувуу ч дуулахаа больжээ. Модны навчис шаржигнахаа больж эргэн тойронд чимээ аниргүй болов.

Юм-Юм толгой дохиж.

- Тийм ээ. Аав чинь тэгсэн ч гэсэн чамайг явуулахыг хүссэн гэж тэр сонсогдох төдий дуугарав. Би яах ч учраа олохгүй байлаа.

- Би чадахгүй ээ гэж хашгирав.

- Би чадахгүй! Би чадахгүй!

Юм-Юм нэг ч үг хэлэлгүйгээр над уруу харлаа. Гэтэл гунигийн шувуу дахин дуулж эхлэхэд миний зүрх зогсох шахав.

- Тэр миний бяцхан охины тухай дуулж байна гэж

нэхмэлчин хэлэхэд, түүний нүднээс унасан нулимс даавуун дээр сувд болон хувирч байлаа.

Би гараа зангидав.

- Юм-Юм, би ямар ч байсан явна аа. Би Харанхуй орон уруу явна аа.

Харанхуй ой шуугьж, гунигийн шувуу ертөнцийн аль ч ойд дуулж байгаагүй гэгэлгэн аялгуу гаргалаа.

- Би мэдэж байсан юм гэж Юм-Юм хэлэв.

- Сайн сууж байгаарай, хайрт Юм-Юм! гэж би бараг уйлах шахам түүнд хэлэв.

Над уруу харахад нүд нь яг Бэнкагийнх мэт найрсаг харагдлаа. Тэгээд тэр үл мэдэг инээмсэглэв.

- Би чамтай хамт явна аа гэж тэр хэллээ.

Юм-Юм бол миний найз, жинхэнэ найз байлаа. Түүнийг надтай хамт явна гэхэд би үнэхээр их баярлаж байлаа. Гэхдээ би түүнийг аюулд унагахыг хүссэнгүй.

- Үгүй ээ, Юм-Юм. Чи миний одоо очих гэж байгаа газар луу хамт явж болохгүй гэж би хориглов.

- Би явна аа. Ганц сайн найзаа бараа болгон дагуулж, алтан дэлтэй морио унасан хаан удмын хүүгийн тухай аль хэдийн зөгнөсөн байгаа. Чи мянга мянган жилийн урьдаас зөгнөн хэлсэн зүйлийг өөрчилж чадахгүй гэж Юм-Юм хэлэв.

- Мянга мянган жилийн өмнөөс намайг алимны модоо тарих үед салхи дуулж байсан тэр шөнийг санаж байна. Тэр цагаас хойш урт хугацаа өнгөрч дээ. Мянга, мянган жилийн өмнө гэж нэхмэлчин эмэгтэй хэлэв.

Тэр толгой дохив.

- Мио, чи нааш ир дээ, нөмрөгийг чинь нөхөөд өгье хэмээв.

Тэр даавуунаасаа нэг хэсгийг авч, ойд давхиж байхдаа урагдсан нөмрөгийг минь нөхөж өглөө. Тэр бүр гялалзсан даавуунаасаа нөмрөгийг минь доторлож өгөхөд урьд урьдынхаасаа улам ч зөөлөн, дулаан, хөнгөн болжээ.

- Бяцхан охиныг минь аврах хүнд л хамгийн сайн даавуунаасаа өгнө. Чамд бас цатгадаг талх хэрэг болно. Чи тэрнийгээ гамнаарай! Чамайг урт удаан аян зам хүлээж буй гэж нэхмэлчин хэлэв.

Тэр надад талхаа өгч, би түүнд талархсанаа илэрхийлэв. Дараа нь би Юм-Юм уруу харлаа.

- Юм-Юм, аян замдаа гарах уу?

Бид хаалгаар гарлаа. Бид алимны модны дундах замыг дагав. Бид мориндоо мордлоо. Тэгтэл гунигийн шувуу том хар далавчаа алдлан уул зорин нислээ.

Моддын дундуур давхихад зуун цагаан адуу бидний хойноос харж үлдэв. Тэд биднийг дагасангүй. Алимны модны цэцэгс сарны туяанд цас мэт гэрэлтэнэ. Цас мэт гэрэлтэнэ. Би ийм үзэсгэлэнтэй алимны цагаан цэцэгсийг дахин хэзээ ч үзэхгүй юм биш байгаа даа...



Илбэдүүлсэн шувууд

Би алимны модны цэцэг, салхинд сэрчигнэх ногоон модод, ширэг өвсийг дахиж хэзээ ч харахгүй юм биш байгаа даа. Учир нь бидний зорьж байгаа тэр оронд ямар ч ургамал ургадаггүй.

Бид шөнөжин давхилаа. Бид давхисаар л. Удалгүй нүдэнддулаансарныгэрэлтуссанойнбараачхарагдахаа болив. Тэгээд өмнөөс түнэр харанхуй нөмрөв. Сарны туяа үгүй. Эндхийн газар чулуурхаг бөгөөд хатуу. Нүцгэн хадан хясаа энд тэндээс цухуйна. Энэ бүгд бидэн үрүү улам их ойртсоор. Эцэст нь бид хоёр өндөр хар уулан дунд орших харанхуй нарийн жимээр давхилаа.

"Энэ зам гэрэлтэй, уулс нь тас хар биш, бид олуулаа ч болоосой" гэж Юм-Юм хүслээ.

Махирлаж мурилзсан жимийг тойрох тутамд аюул нуугдаж буй мэт. Мирамис ч түүнийг мэдрэв бололтой, бие нь дагжин чичирч, буцахыг хүсч байгаа мэт. Харин би жолоогоо чанга гэгч нь бариад, цааш давхиулж байлаа. Зам улам нарийсч, түүнийг хүрээлэх хар уулс ч улам өндөрссөөр. Харанхуй улам ихэссээр. Арайхийж бид хадны дундах хаалга бололтой нэгэн ангал дээр ирлээ. Түүний цаана ертөнцөд өөр хаана ч байхгүй түнэр харанхуй оршино.

- Энэ бол харанхуй оронд нэвтрэх хаалга нь гэж Юм-Юм шивнэлээ.

Мирамис хойд хөл дээрээ босч янцгаахад түүнийг

сонссон хэн бүхний зүрх шимширмээр. Хаалганы цаана чив чимээгүй. Харанхуй бидэн үрүү гэтээд ч байх шиг. Биднийг хил даваад орж ирэхийг л хүлээх мэт.

Би тэр харанхуй уруу орох ёстойгоо мэдсэн ч нэг их айсангүй. Намайг мянга мянган жилийн өмнөөс энэ харанхуй хаалгаар орохыг зөгнөсөн гэдгийг мэдсэн тул би зоригтой байлаа. Юу л болбол болог гэж би бодлоо. Хэзээ ч эргэж ирэхгүй байсан ч би айсангүй.

Мирамис харанхуй уруу орж, харанхуй замаар хурдаллаа. Бид шөнө юу ч үл үзэгдэх тас харанхуй дундуур давхилаа.

Юм-Юм минь надтай хамт явж байна. Ард минь сундалж, намайг чанга гэгч нь тэвэрч явахад сайхан байлаа. Би ганцаараа биш, олон жил зөгнөсөн сайн андтайгаа холын замд явна гэдэг сайхан.

Бид харанхуй дундуур хэчнээн давхисныг бүү мэд. Хэдхэн хором ч юм уу, олон цаг ч юм уу? Бүр мянга, мянган жил өнгөрсөн ч юм шиг. Нойрондоо цочин сэрсэн ч айлгасан хэвээр байдаг хар дарсан зүүдэн дундуур туулж байгаа мэт. Гэтэл энэ нь зүүд биш байлаа. Бид давхисаар л. Бид чухам хаашаа, хэр хол явж байгаагаа ч мэдсэнгүй. Шөнөжин давхилаа.

Мирамис гэнэт зогсов. Бид нууранд тулж очсон байв. Түүн шиг аймшигт зүүд хорвоод байхгүй биз. Заримдаа би цэлийсэн хар усны өмнө зогсож байна гэж зүүдэлдэгсэн. Харин миний өмнөх энэ тас хар усыг би ч, надаас өөр хэн нэгэн ч насандаа зүүдэлж байгаагүй. Тэр нь ертөнцөд цорын ганц хамгийн хар нуур билээ. Түүнийг арзгар, өндөр, нүцгэн, хар хаднууд л хүрээлнэ. Мандал дээр нь олон шувууд эргэлдэнэ. Өөрсдөө харагдахгүй ч

дуу нь сонсогдоно. Түүн шиг гунигт дууг би хэзээ ч сонсч байсангүй. Би шувуудыг өрөвдлөө. Тусламж гуйн уйлж байгаа ч юм шиг.

Нуурын нөгөө талд өндрөөс өндөр хадан дээр нэгэн том хар цайз үзэгдэнэ. Цорын ганцхан цонх гэрэлтэй аж. Тэр нь улаан, аймшигтай, муу ёрын, бидэнд муу юм ёрлосон нүд мэт харагдаж, шөнийн харанхуйд нааш ширтэнэ.



- Дээрэмчин Катогийн цайз гэж Юм-Юмыг шивнэхэд Мирамис дагжин чичирч эхлэв.

- Дээрэмчин Катогийн цайз гэнэ ээ? Хар нуурын эсрэг талд надтай тулалдах дайсны маань гэр байдаг байх нь. Би айхгүйг хэчнээн хичээсэн ч нуурын дээрээс ширтэх тэр муу ёрын нүд надад үнэхээр их айдас төрүүлнэ. Балчир жаал би яаж хорон санаатай, аюулт дээрэмчин Катог дийлэх вэ?

- Чамд илд хэрэгтэй гэж Юм-Юм хэлэв.

Түүнийг хэлж дуусав уу үгүй юу хэн нэгний ёолох дуу гарав.

"Ёо... ёо... ёо. Би өлсөж үхэх нь. Ёо... ёо... ёо!,"

Түүн үрүү дөхөж очвол аюултай гэдгийг би мэднэ ээ. Биднийг урхиндаа оруулах гэж байгаа ч юм билүү. Гэхдээ би хэн ч байсан түүнийг хайж олоод, аврал эрж буй эсэхийг нь мэдэхээр шийдлээ.

- Бид хэн бэ гэдгийг харах хэрэгтэй. Аврал эрсэн нэгэн байж магад гэж би Юм-Юмд хэллээ.


- Би чамтай хамт явна гэж Юм-Юм хариуллаа.

- Мирамис минь эндээ үлд дээ! гээд би хамрыг нь илэв. Тэр айсан мэт янцгааж байлаа.

- Зүгээр ээ, бид удахгүй эргээд ирнэ ээ гэж би түүнийг тайвшруулав.

Тэр ёолж байгаа хүн энэ хавьд л байгаа байх, гэвч харанхуйд яаж түүнийг олох билээ?

"Ёо... ёо... ёо. Би өлсөж үхэх нь, ёо... ёо... ёо!" гэх тэр дуу дахин сонсогдов. Бид чулуунд бүдэрч түнэр харанхуй уруу орлоо. Тэгсээр бид нэгэн яйжийж жайжийсан хуучин байшингийн дэргэд ирлээ. Тэр ханан хаданд налаастай байгаагүй бол аль хэдийн нураад



уначихсан даа. Цонхноос ёлтойх гэрлийн зүг очиж харваас цал буурал толгойтой, жижигхэн, насан өндөр болсон өвгөн сууж байлаа. Тэр дүрэлзэн асах галтай зуухны өмнө суугаад, наашаа цаашаа эргэж хөрвөн,

"Ёо... ёо... ёо. Би өлсөж үхэх нь. Ёо... ёо... ёо!" гэж бувтнана.

Бид гэрт орлоо. Өвгөн чив чимээгүй болж биднийг ширтлээ. Бидэн шиг хүнийг хэзээ ч үзэж байгаагүй мэт цоо ширтэнэ. Тэгснээ айж буй бололтой үрчийсэн

мойног гараа дээш өргөлөө.

- Надад муу юм бүү хийгээч. Надад муу юм бүү хийгээч! гэж тэр шивнэв. Бид түүнд муу юм хийхээр ирээгүй гэдгээ хэлэв.

- Өлсөж байгааг тань сонсоод танд талх өгөхөөр ирлээ гэж би учирлав.

Нэхмэлчин бүсгүйн өгсөн талхыг гаргаад түүнд өглөө. Гэтэл тэр намайг ширтсээр л. Би түүнд талхаа улам ойртуулсан ч, өвгөн өөрийг нь урхинд оруулах нь гэж бодсон мэт ихэд айсан харцаар харсаар байлаа.

- Талхыг авагтун. Биднээс айсны хэрэггүй!

Тэгтэл тэр гараа болгоомжтой гэгч нь сунгаад талхыг авлаа. Тэгээд гартаа талхыг барьж тэмтэрч үзлээ. Дараа нь үнэрлэснээ уйлж эхлэв.

- Энэ чинь өлссөн бүхнийг цатгадаг талх байна шүү дээ гэж тэр шивнэлээ. Тэгээд идэж эхлэв. Би хэзээ ч түүн шиг юм идэж байгаа хүн харсангүй. Өвгөн идэх хоорондоо уйлаад л байв. Идэж дуусаад хувцсан дээр унасан үйрмэг бүрийг түүн авч ухаан орсон мэт биднийг дахин ширтээд,

- Та нар хаанаас ирэв? Ийм талх хаана байдаг вэ? Та нар хаанаас ирснээ хэл л дээ хэмээв.

- Бид Алс холын орноос ирсэн. Тэнд ийм талх байдаг юм гэж би түүнд хариулав.

- Ямар хэргээр ирэв? гэж өвгөн шивнэв.

- Дээрэмчин Катотай тулалдахаар ирсэн билээ гэж би хэлэв.

Ингэж хэлүүт өвгөн хашгирч, сандлаасаа унах нь тэр. Тэр жижиг саарал бөмбөлөг мэт шалан дээр өнхрөн бидэн үрүү мөлхөж ирлээ. Тэр бидний хажууд ирснээ

нүдээ анивчиж, айсан шинжтэй хэлэх нь:

- Та хоёр ирсэн замаараа эргэн буц. Оройтоогүй дээрээ буц!

- Буцахгүй! Би дээрэмчин Катотай тулалдана гэж Чанга бөгөөд ойлгомжтойгоор хэллээ.

- Хөөх... хөөх... хөөх. Чимээгүй байцгаа! Оройтоогүй дээрээ буцацгаа гэж би та хоёрт хэлж байна шүү.

- Би буцахгүй. Би дээрэмчин Катотай тулалдахаар ирсэн гэж би зүтгэв.

- Чш, чимээгүй. Чимээгүй бай гэж байна шүү. Туршуулууд нь чамайг сонсчихно. Яг одоо чиний яриаг сонсч байгаа ч юм бил үү яаж мэдэх вэ? гэж тэр сэрэмжлүүлэв. Тэгснээ хаалга уруу мөлхөж очоод болгоомжтой чагнасхийв.

- Сонсогдох юм л алга. Гэхдээ байж юу магад. Энд тэндгүй бий. Муусайн туршуулууд.

- Дээрэмчин Катогийн туршуулууд аа? гэж би лавлав.

- Жаал минь, чимээгүй. Чи хар нялхаараа амиа алдахыг хүсч байна уу? Амаа хамхиж чадахгүй нь уу?

Тийнхүү хэлээд сандалдаа суув.

- Тийм ээ тийм, түүний туршуулууд хаа сайгүй. Өглөө ч өдөр ч орой ч, дандаа тагнана гэж өвгөн сонсогдох төдий өгүүлээд гараа над уруу сунгаж миний гарыг барилаа.

- Миний амьдрал өлсгөлөнд нэрвэгдсэн. Хэнд ч бүү итгэ! Чи нэг айлд ороод ... найзуудынхаа дунд байна гэж бодно. Гэтэл тэд дайснууд чинь байж чамайг барьж өгнө. Тэгээд нуурын нөгөө эрэг дээрх гарт оруулна. Ер нь хэнд ч бүү итгэ. Надад ч бас ялгаагүй итгэсний хэрэггүй!

Хаалгаар гараад явсны чинь дараа араас чинь туршуул тавихгүйг яаж мэдэж байгаа юм бэ?

- Таныг ийм зүйл хийхгүй гэдэгт итгэж байна гэж би хэллээ.

- Хэнд ч юунд ч итгэлтэй байж болохгүй. Чи хэзээ ч тийм байж болохгүй гэж хөгшин шивнэв. Тэр хэсэг зуур сууж бодолхийлснээ,

- Үгүй дээ, би чам уруу хэнийг ч явуулахгүй. Энэ оронд урвагч болоогүй хүмүүс бий. Бас зэвсэг хийдэг хүмүүс ч байна хэмээв.

- Бидэнд зэвсэг хэрэгтэй. Миод илд хэрэгтэй байна гэж Юм-Юм хэлэв.

Өвгөн хариу хэлсэнгүй. Цонх нээлээ. Нуурын зүгээс шувуудын гунигтай дуу сонсох нь цурхиран уйлах мэт байлаа.

- Сонсч байна уу? Чи тэдний нэг болмоор байна уу? гэж өвгөн надаас асуулаа.

- Тэд ямар учиртай шувууд вэ? гэж би асуулаа.

- Тэд бол илбэдүүлсэн шувууд. Хэн илбэдсэнийг таамаглаж байгаа биз. Хэн тэднийг булааж авсныг ч чи мэдэх биз. Дээрэмчинтэй тулалдвал яадгийг чи одоо мэдэх болно гэж өвгөн шивнэлээ.

Би түүний яриаг сонсоод ихэд гуниглав. Эдгээр шувууд нь тэгвэл дээрэмчин Катогийн булааж аваад илбэдсэн Нонногийн ах нар, Йиригийн дүү, нэхмэлчний бяцхан охин болон бусад хүмүүс байх нь ээ. Би түүнтэй тулалдахыг хүснэ.

- Миод илд хэрэгтэй. Илдгүй ямар тулалдаан байх билээ? гэж Юм-Юм хэллээ.

- Та зэвсэг хийдэг хүмүүс байна гэж хэлсэн шүү дээ

гэж би сануулав.

Өвгөн над уруу уурсан хараад,

- Амиа золиослох чинь дутаад байна уу? гэв.

- Зэвсэг хийдэг хүмүүс хаана байгааг зааж өгөөч гэж би түүнээс дахин гуйлаа.

- Чимээгүй бай! Туршуулууд чамайг сонсчихно шүү гэж өвгөн хэлээд цонхоо яаравчлан хаав.

Тэр хаалган дээр гэтэж очоод, чихээ наалдуулан чагнаснаа,



- Сонсогдох л юм алга. Гэхдээ тэд хаа сайгүй байгаа, муу туршуулууд гээд над уруу дөхөж ирсэнээ чихэнд шивнэн хэлэх нь:

- Чи илдний дархан дээр очоод Эно мэнд хүргэж байна гээрэй. Түүнээс чулуу хага цохидог илдийг нь гуйгаарай. Мөн өөрийгөө танилцуулж, Алс холын орноос ирсэн эр байна гэж хэлээрэй хэмээв.

Тэр намайг удаан гэгч ажсанаа,

- Би чамайг тийм л гэж бодож байна. Үнэн биз дээ? гэж лавлав.

- Тийм ээ, энэ бол Алс холын орноос ирсэн эр бөгөөд хаан хүү Мио мөн. Түүнд илд л хэрэгтэй байна даа гэж Юм-Юм миний өмнөөс хариуллаа.

- Илдний дархан хаана суудаг вэ? гэж би асуув.

- Хараас хар уулын гүнээс гүн агуйд. Сөнөсөн ой дундуур яваарай! Одоо явцгаа! гэж хөгшин зөвлөв.

Тэр цонхоо нээв. Нуурын зүгээс шөнө дунд цурхирах шувуудын дууг би дахин сонслоо.

- Хаан хүү Мио, аян замдаа гар даа. Би эндээс бүх юм сайнаар төгсөөсэй гэж хүсье. Эс тэгвээс маргааш шөнө нуурын дээгүүр бас нэг шинэ шувуу эргэлдэх байх даа гэж өвгөн хэллээ.

Сөнөсөн ойд

Эногийн гэрийн хаалгыг хаах зуурт би Мирамисын янцгаахыг сонслоо. Тэрээр “Мио, нааш ирж надад туслаарай!” гэх мэт чанга янцгаав.

Би маш их айж, зүрх минь зогсох дөхлөө.

- Юм-Юм, тэд Мирамисыг яаж байна аа? Сонс доо! Тэд морийг минь яаж байна аа?” гэж би хашгирав.

- Чимээгүй бай, тэд нар ... туршуулууд түүнийг барьж авсан байна...

- Юу? Мирамисыг барьж авсан гэнэ ээ? гэж би хэн нэгэн сонсчих вий гэж болгоомжлолгүй чанга асуув.

- Чимээгүй байхгүй бол тэд бид хоёрыг ч бас олзолно шүү гэж Юм-Юм сануулав.

Тэгж хэлэхийг нь ч би тоосонгүй. Миний морь Мирамис! Тэд надаас морийг минь салгах гэж байна шүү дээ! Мирамис бол ертөнцийн хамгийн сайхан морь.

Дахин янцгаах нь “Мио, чи надад тусалж чадахгүй юм уу?” гэж асуух мэт санагдлаа.

- Явъя, тэд түүнийг яаж буйг очиж харъя гэж Юм-Юм хэллээ.


Бид харанхуйд хад уруу мөлхөж, авирч явлаа. Би хадны хурц ирмэгт хуруугаа зүссэн ч тоосонгүй, гагцхүү би морио л бодож байлаа.

Тэр харанхуйг цагаан өнгөөрөө гэрэлтүүлэн хадны оройд үзэгдэнэ. Миний Мирамис ертөнцийн хамгийн сайхан, цав цагаан морь!

Тэр аюулаас мултрах гэж чанга янцгаан цамнаж байлаа. Гэвч таван туршуул түүнийг тойрч зогссоноос хоёр нь Мирамисын цулбуурыг атгажээ. Морь айх нь аргагүй биз. Тас хар туршуулууд аймаар бөгөөд нэг л сонин сөөнгө хоолойгоор ярьж байлаа. Юм-Юм бид хоёр тийш ойртлоо. Бид хадны ард нуугдан яриаг нь чагналаа.



- Энэ морийг хар завиндаа хийгээд Сөнөсөн нуурыг гаталъя гэж тэдний нэг нь санал болгов.



- Тийм ээ, Като эзэнд шууд хүргэж өгье гэж нөгөө нэг нь хариулав.

Морийг минь орхиоч дээ гэж хашгирмаар байсан ч амаа хамхихаас өөр аргагүй байлаа. "Туршуулуудад баригдчихвал хэн Катотай тулалдах вэ. Ингэхэд ер нь яагаад заавал би түүнтэй тулалдах ёстой гэж?," Би хадны ард ингэж бодоод харамсан хэвтэж байлаа. Хэрвээ би хаан аавтайгаа гэртээ үлдсэн байсан бол хэн ч миний морийг булаахгүй дээ! Нууран дээгүүр эргэлдэх илбэдүүлсэн шувуудын гаслант ганганааг сонссон ч би тоосонгүй. Алтан дэлтэй Мирамисаа л буцааж авч байвал тэдгээр шувууд илбэдүүлсэн хэвээрээ үлдэнэ биз.

- Хэн нэгэн энэ цагаан морийг унаж, хил гатлан орж иржээ. Дайсан бидний дунд байна гэж туршуулуудын нэг нь хэлэв.

- Хэрвээ дайсан бидний ойролцоо байвал бидэнд л барьж авахад амар. Като түүнийг төдийчинээ хурдан устгана гэж өөр нэг туршуул хариулав.

Би ийнхүү ярихыг нь сонсоод маш их айлаа. Хил гатлан орж ирсэн дайсан нь би байх нь. Тэгээд Като намайг устгана гэнэ. Би энд хэрэггүй л ирж дээ. Би ааваа санаж, тэр бас намайг бодож, надад санаа нь зовж байгаа болов уу гэж эргэцүүлэв. Аав минь энд байгаад надад тусалдаг ч болоосой. Хоромхон зуур ч болов түүнтэй ярилцах сан. Би ингэж хэлнэ: "Та намайг дээрэмчин Катотай тулалдуулахыг хүсэж буйг би мэднэ ээ. Гэвч намайг үүнээс хэлтрүүлж хайрлаач. Мирамисыг буцааж аваад харихад минь туслаач! Надад өөрийн гэсэн морь урьд нь хэзээ ч байгаагүйг та мэднэ. Би Мирамистаа үнэхээр их хайртай. Намайг бас аавгүй байсныг та мэднэ. Дээрэмчин Като намайг олзолбол би тантай хэзээ ч хамт байж чадахгүй. Эндээс явахад минь туслаач! Би энд удмааргүй байна. Би тань дээр очмоор байна. Мирамистайгаа Ногоон нугын арал дээрээ эргэж очмоор байна."

Ийнхүү бодон хадны ард нуугдан хэвтэх хооронд би гэнэт хаан аавынхаа дуу хоолойг сонсох мэт боллоо. Санаандаа ургуулан бодсон байх л даа, гэвч гарцаагүй түүний дуу байсан юм.

- Мио, хүү минь! гэж тэр өгүүлэв.

Өөр юу ч хэлсэнгүй. Морио булаалгасан ч хүүхэд мэт уйлж унжихын оронд зоригтой байгаасай гэж аавынхаа

хүсч буйг би ойлголоо. Би чинь хариг эр шүү дээ. Би Сарнайн цэцэрлэгт овоохой босгож, Ногоон нугын арлын дов толгод дамжин лимбэ тоглодог Мио одоо биш болсон байлаа. Би бол хариг эр, Катогийн дэргэд жинхэнэ сайн эр мөн. Хариг эр нь зоригтой бөгөөд уйлдаггүй юм.

Иймээс би туршуулууд Мирамисыг нуурын зүг чирч, том хар завинд оруулахыг харсан ч нулимс унагасангүй. Мирамис ташуурдуулаад янцгаахад, харанхуй усан дотор завины сэлүүр дуугарсан ч бас уйлсангүй. Нуурын эргээс гарах чимээ бүдгэрсээр, хар завийн бараа тасрахаас өмнө Мирамис аргаа баран эцсийн удаа янцгаах нь сонстлоо. Гэвч би уйлаагүй. Учир нь би хариг эр шүү дээ.

Би уйлаагүй гэж үү? Тиймээ, би хадны ард духаа хатуу газар нааж хэвтэхдээ насандаа уйлж үзээгүйгээр уйлсан. Шударга хариг эр үнэнээ хэлдэг байх ёстой. Би Мирамисыгаа бодож уйлсан нь үнэн билээ. Түүний тун үнэнч нүдийг бодох тусам улам мэгшиж уйллаа. Нэхмэлчин эмэгтэй зуун цагаан морь, хулгайд алдсан унагануудынхаа хойноос цусаар уйлдаг гэж хэлж байсан. Би бас цусаар уйлсан ч юм билүү, хэн мэдэх вэ? Хав харанхуй байсан тул юу ч харагдсангүй. Алтан дэлтэй Мирамис минь! Би түүнийг дахиж хэзээ ч харахгүй байх даа.

Юм-Юм над уруу тонгойж, гараа мөрөн дээр минь тавиад,

- Мио, битгий уйлаач дээ. Бид зэвсгийн дархан дээр очиж илдтэй болмоор байна гэж хэлэв.

Надад дахин уйлах нулимс зөндөө байсан ч би чадах чинээгээрээ нулимсаа барилаа. Ингээд бид зэвсгийн

дархныг хайхаар явлаа.

- Сөнөсөн ой дундуур яваарай гэж Эно хэлсэнсэн. Гэтэл тэр нь хаана байдаг юм бол?

- Бид дархныг үүр цайхаас өмнө олох хэрэгтэй. Харанхуй биднийг туршуулуудаас нууна. Иймээс энэ шөнө л зорьсон газраа хүрэх хэрэгтэй гэж Юм-Юм хэлэв.



Бид хад дамжин буцаж Эногийн байшинд ирлээ. Тэнд дүнсгэр бөгөөд чив чимээгүй, байшин дотроос сонсогдох л юм алга. Бид шөнийн харанхуйд улам цаашлан явсаар сөнөсөн ойд ирлээ. Тэнд навч үлээх салхигүй, салхинд найгах ногоон навч ч байсангүй. Тэнд гагцхүү хатсан, хар мөчиртэй амьгүй модод байлаа.

- Бид Сөнөсөн ойд орж ирлээ гэж Юм-Юм модон дунд оронгоо өгүүлэв.

- Тийм ээ, ирэх нь ирлээ. Гэхдээ эргэж гарч чадах болов уу гэж би хариулав.

Учир нь тэнд хэн ч дорхноо төөрмөөр нөгөө зүүдний зэвүүн ой мөн байв. Дотор нь яваад л, яваад л байдаг, гарах арга байдаггүй.

Юм-Юм бид хоёр сөнөсөн ой дундуур хөтлөлцөн явлаа. Бид төөрсөн бололтой. Хатсан шигүү модод дундуур цаашаа явахад нэн бэрх байлаа.

- Модод нь шигүү биш, хав харанхуй бус, бид хоёулаа биш олуулаа байдаг ч болоосой гэж Юм-Юм хэлэв.

Бид улам цаашаа явсаар л. Заримдаа хаа нэгтээ ярих чимээ холоос сонстоно. "Дээрэмчин Катогийн туршуулууд хаа сайгүй байгаа шүү," гэж Эногийн анхааруулан хэлсэн үнэн байх нь. Тэд сөнөсөн ойгоор дүүрэн биз. Тэдний хоорондоо ярилцахыг сонсоод Юм-Юм бид хоёр түр зуур зогсоод, амьсгаа авахдаа хүртэл айцгаав.

Бид улам цаашаа явсаар л.

- Сөнөсөн ойд шөнө удаан өнгөрөх юм, харин зэвсгийн дархны агуй их л хол байх даа гэж Юм-Юм өгүүлэв.

- Юм-Юм, бид хоёр түүнийг олох болов уу? гэснээ би дуугүй болов. Ганц ч үг миний хоолойгоор давсангүй. Учир нь модон дундаас яг бидэн үрүү бүлэг хар туршуулууд ирж явлаа. Тэд яг бид хоёрыг чиглэн ирж байсан тул би бүх зүйл үүгээр төгсөж байна гэж бодлоо. Юм-Юм бас тэднийг харж, миний гарыг чанга атгалаа. Тэд биднийг харахан харж амжаагүй ч тун удахгүй





биднийг олзолно, тэгээд бүх юм өнгөрөх нь тэр. Би хэзээ ч дээрэмчин Катотай тулалдаж чадахгүй. Маргааш орой гэхэд Эно нууран дээгүүр эргэлдэх шинэ хоёр шувууны гаслант ганганааныг сонсох болно.

Туршуулууд улам ойртсоор, бид ч байрандаа хөдлөлгүй зогссоор. Гэтэл гайхалтай юм тохиолоо. Бид хоёрын дэргэдэх хөгшин мод нээгдлээ. Дотроо хов хоосон. Нэг л мэдэхэд Юм-Юм бид хоёр модны хөндийд орчихсон, харцаганаас нуугдах ангаахай мэт дагжин чичирч байлаа. Туршуулууд бараг хажууд ирсэн тул бид юу ярихыг нь сайн сонсч авав.

- Сөнөсөн ойд хэн нэгний дууг олж сонслоо. Хэн байж таарах вэ? гэж тэдний нэг нь асуулаа.

- Дайсан бидний дунд байна. Сөнөсөн ойд дайсан л ярьсан байж таарна гэж хоёр дахь туршуул өгүүлэв.

- Дайсан сөнөсөн ойд байвал бид удахгүй барьж авна аа. Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! гэж гурав дахь туршуул тушаав.

Модон дундуур хайхыг нь бид сонсч л байлаа. Гэтэн алхлахыг нь чагнан суухдаа бид хоёр ухаан алдталаа айж байв.

Тэд хэчнээн хайвч биднийг олсонгүй. Тэдний дуу улам холдон бүдгэрсээр. Тэгсгээд чимээгүй боллоо. Модны хөндий бидний амийг аварлаа.

Яагаад биднийг аварсан юм бол? Учрыг нь би ойлгосонгүй. Сөнөсөн ой тэр аяараа Катог үзэн яддаг тул дээрэмчинтэй тулалдахаар ирсэн хүнд тусалсан юм болов уу? Тэр мод цагтаа салхинд сэрчигнэн дуугарсан олон ногоон навчтай, залуу сайхан мод байсан юм болов уу? Дээрэмчин Като хорон санаалж түүнийг хөнөөсөн байх. Ногоон навчсаа тасчуулсан модод түүнийг яахин уучлаа аж. Тиймээс л тэр мод Катогийн эсрэг тэмцэхээр ирсэн хэнд ч болов туслахыг хичээсэн бололтой.

- Сайн санаат мод чамд их баярлалаа гэж модны хөндийгөөс гарахдаа би хэлэв. Гэвч сөнөсөн мод юу ч хэлсэнгүй. Бид сөнөсөн ой дундуур улам цаашилсаар л.

- Үүр цайх гэж байна, бид харин зэвсгийн дархны агуйг олоогүй л байдаг гэж Юм-Юм санаа зовнин өгүүлэв.

Тийм ээ, шөнө дуусч байлаа. Гэхдээ үүр цайж байгаа гэхэд манай нутгийнх шиг биш. Өглөө нь саарал, зэврүүн, харанхуйвтар байлаа. Би Ногоон нугын арал дээр үүрээр Мирамисаа унаад шүүдэр гялтганасан өвсөн дээгүүр давхиж явснаа санав. Би бодолдоо автсаар хаана байгаагаа ч умартав. Морин туурайн чимээ ойртоход огтхон ч сандарсангүй. Мирамис ирж байна даа гэж би бодлоо. Гэтэл Юм-Юм миний гарыг

чанга атгаж,

- Сонсч байна уу? Туршуулууд ой дундуур давхиж явна хэмээв.

"Ингээд л бүх зүйл дуусдаг юм байжээ," гэж би бодов. Одоо биднийг юу ч аврахгүй. Удахгүй модон дундаас хар туршуулууд гарч ирээд биднийг олж харна. Тэд салхин шуурга мэт довтлон ирээд, ганцхан тонгойн биднийг мориндоо сундлан, дээрэмчин Катогийн цайз уруу давхиж одно биз. Би хэзээ ч дээрэмчин Катотай тулалдаж чадахгүй. Маргааш орой гэхэд Энэ нууран дээгүүр эргэлдэх шинэ хоёр шувууны гаслант ганганааныг сонсох биз.

Бүх юм өнгөрлөө. Би мэдээд байсан юм. Туурайн төвөргөөн улам ойртсоор л. Гэтэл гайхалтай юм тохиолоо. Бидний өмнөх газар нээгдэж, нүх харагдав. Нэг л мэдэхэд Юм-Юм бид хоёр тэр нүхэн дотор орчихсон, үнэгнээс нуугдах бүжин мэт дагжин чичирч суулаа.

Энэ бол эцсийн мөч байв. Туурайн төвөргөөн улам ойртсоор л. Туршуулууд яг бидний чанх дээгүүр давхилаа. Нүхэн дотор суухдаа бид хоёр тэдний морьдын төвөргөөн, хүнд туурайн пижигнэхийг сонслоо. Дээрээс бидэн үрүү шороо унана. Бид хоёр тэнд айсан жижиг хүүхдүүд л байв.

Гэтэл чимээгүй боллоо. Сөнөсөн ойд туршуулууд байхгүй мэт чив чимээгүй. Бид удал хүлээлээ.

- Эндээс гарах уу даа гэж би эцэст нь хэллээ.

Яг тэрхэн хоромд аймшигт туурайн чимээ дахин гарав. Туршуулууд буцаж ирэх нь тэр. Бидний толгой дээр туурайн пижигнэх чимээ гарч, туршуулууд орилж хашгична. Тэд мориноосоо бууж нүхний амсарт суув.

Бид тэднийг нүхний цоорхойгоор харж байв. Гар хүрэхээр тийм ойрхон байлаа. Тэдний юу хэлэхийг сайн сонсч авав.

- Дээрэмчин Катогийн зарлигаар дайсныг баривчлагтун! Цагаан унага унаж ирсэн тэр дайсныг энэ шөнийн дотор баривчлагтун. Энэ бол дээрэмчин Катогийн зарлиг гэж тэдний нэг нь хэллээ.

- Дайсан бидний дунд байна. Бид түүнийг барина аа. Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! гэж өөр нэг туршуул нь өгүүлнэ.

Бидний бараг дэргэд сууж, яаж барих талаар ярилцана. Аймшигтай хар туршуулууд үүр цайх зэвхий саарал туяанд, эргэн тойрон сөнөсөн моддын дунд сууна. Тэдний хар морьд нь эргэн тойронд бие биенээ зэрлэгээр хазаж, газар дэвсэлнэ.

- Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! Тэр газар дахь юун нүх вэ? гэж нэг туршуул нь асуухад нөгөө нь:

- Газрын хонгил байна. Дайсан тэнд нуугдан байж магад. Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! хэмээлээ.

Юм-Юм бид хоёр бие биедээ наалдлаа. Одоо ингээд хамаг юм өнгөрөх нь, би мэдэж байсан юм.

- Би жадаа дүрээд үзье. Дайсан байвал би жадаараа цоо хатгая гэж нэг туршуул нь хэлэв.

Хар жад хонгилын нүхээр орж ирэхийг бид харлаа. Бид хоёр чадах чинээгээрээ л доошоо газарт наалдав. Гэвч хурц жад бидэн үрүү улам ойртсоор л. Жад хатгаад байсан ч биднийг оносонгүй. Юм-Юм бид хоёрын завсарт буй хонгилын ханыг хатгаж байлаа.

Сөнөсөн ой дундуур хайцгаа! Дээрэмчин Катогийн зарлигаар дайсныг ол. Тэр энд алга. Өөр газар хайцгаа!

гэж нэг туршуул хэллээ.

Туршуулууд хар мориндоо мордоод цааш давхилаа.

Биднийг газрын хонгил аврахад ямар учиртай юм бол гэж би гайхлаа. Газар шороо хүртэл Катог үзэн ядаж, түүнтэй тулалдахаар ирсэн хүнд туслах гэсэн юм болов уу? Урьд нь тэнд торгон ногоон өвс ургаж байсан ч юм билүү? Дээрэмчин Катогийн хорон санаа түүнийг хөнөөсөн байх. Торгон ногоон өвсөө хуйхлуулсан газар түүнийг лавтай хэзээ ч уучилж чадахгүй. Тийм учраас газар Катогийн эсрэг тэмцэхээр ирэгсдийг хамгаалалдаа авсан бололтой.

- Сайн санаат газар чамд их баярлалаа гэж би явахдаа хэллээ. Гэтэл тэр юу ч хариулсангүй. Газар доорх хонгил харин ор сураггүй алга болсон байлаа.

Бид явсаар сөнөсөн ойгоос гарлаа. Бидний өмнө уул хад гарч ирлээ. Би тээнэгэлзэв. Энэ чинь сөнөсөн нуурын хавийн хаднууд байна шүү дээ. Юм-Юм бид хоёулаа эргэлзлээ. Санасан бүхэн маань ингээд нурлаа гэж үү? Зэвсгийн дархныг бид хэзээ ч олохгүй нь. Шөнөжин сөнөсөн ой дундуур явж явчхаад харин одоо анх гараагаа эхэсэн газар ирсэн байх гэж. Эногийн жижиг саарал жайжийсан байшин ч харагдлаа. Тэр байшинг өндөр, нүүрс мэт хар хадыг түшүүлэн барьсан байв.

- Энэ лав ертөнцийн хараас хар уул мөн байх гэж Юм-Юм таамаглав. Хав хар уул мөн байна аа. Харин тэнд л зэвсгийн дарханы агуй байгаа. "Хараас хар уулын гүнээс гүн агуйд," гэж Эно хэлсэн.

- Юм-Юм, чи хар даа гэснээ би дуугаа хураав.

Ингээд л бүх юм дуусах нь тэр гэж би бодлоо.



Сөнөсөн ой дотроос хар туршуулууд уртаас урт эгнээгээр дахин гарч ирлээ. Тэдний зарим нь явган, зарим нь хар мориороо давхиж, бүгд л наашаа явж байв. Тэд биднийг олж харуутаа муухай сөөнгө хоолойгоор чанга хашгиран,

- Дайсан бидний дунд байна. Яг энд байна. Түүнийг баригтун! Дээрэмчин Катогийн зарлигийн дагуу баригтун! гэцгээв.

Юм-Юм бид хоёр нуруугаараа уулын хана налан, туршуулууд улам ойртохыг харж зогслоо. Тийм ээ, бүх юм өнгөрлөө. Би хэзээ ч дээрэмчин Катотай тулалдаж чадахгүй нь. Би маш их гуниглав. Би газар хэвтээд уйлмаар байлаа. Шөнийн нууран дээгүүр бусад шувуудаас илүү гунигтай ганганааг Эно сонсох нь. Эно тэгээд цонхон дээрээ зогсоод, "Хан хүү Мио гадаа нисч байна" гэж бувтнах байх даа.



Хараас хар уулын гүнээс гүн агуйд

Гэтэл гайхалтай юм тохиолоо. Бидний налан зогсож байсан уулны хана нээгдлээ. Нэг л мэдэхэд Юм-Юм бид хоёр уулан дотор орчихсон, чононоос нуугдах хурга мэт дагжин чичирч суулаа.

Аюул өнгөрлөө. Бид уулан дотор, туршуулууд харин гадаа үлдлээ. Хадны хана хаагдаж, ямар ч нүх сүвгүй бив битүү боллоо. Одоо биднийг барьж чадахгүй гэж бодсон ч тэдний гадаа орилолдох нь тод сонсогдож

байлаа.

- Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! Дайсан дөнгөж сая бидний ойролцоо байж байгаад алга боллоо. Хаа сайгүй хайцгаа! гэж тэд бахиралдана.

- Хайцгаа л даа, та нар бид хоёрыг эндээс яасан ч олохгүй юм чинь гэж би хэлэв.

Юм-Юм бид хоёр баярласандаа уулан дотор чанга инээлдэв. Гэвч Мирамисыг бодоод би инээхээ болив.

Бид эргэн тойрноо ажихад бид харанхуйвтар том агуй дотор байлаа. Хаанаас гэдэг нь мэдэгдэхгүй бүдэг гэрэл гарна. Бидний зогсож буй хөндийгөөс салаалсан олон харанхуй гарц үзэгдэнэ.

Хараас хар уулын гүнээс гүн агуйд зэвсгийн дархан суудаг гэж Эно хэлсэн. Эдгээр олон гарцуудын нэг нь тийш хүргэх юм биш байгаа. Гэтэл аль нь вэ? Бид даанч мэдэхгүй юм. Зөв замаа олтол нэлээн л явах байх даа.

- Хоёулаа ямар ч байсан хав харанхуй уулан дотроо ороод иржээ гэж Юм-Юм өгүүлэв.

- Тийм ээ, ирэх нь ирлээ. Гэхдээ бид эндээс эргэж гарч чадах болов уу гэж би хариулав.

Учир нь тэнд хүн амархан төөрч болох бөгөөд зүүдэнд ордог уул мөн байв. Хачирхалтай харанхуй замаар яваад л, яваад л байдаг, гарц харин олддоггүй.

Юм-Юм бид хоёр хөтлөлцөөд, уулын гүн үрүү явлаа. Бид бол энд өчүүхэн амьтад байлаа. Бас төөрсөн гэдгээ ч мэдэрч байв. Гүнээс гүн агуй хүртэлх зам хол биз дээ.

- Энэ агуй ийм аймаар биш, гарц нь харанхуй бус, бид хоёулхнаа биш, олуулаа байдаг ч болоосой гэж Юм-Юм хэлэв.

Бид улам цаашаа явсаар л. Уулан доторх гарц зүг бүрт салаалжээ. Заримдаа бүдэг гэрэл яльгүй тодорч, нэлээн хэдэн метрийн цаадтайг олж харна, заримдаа юу ч үзэгдэхгүй тас харанхуй болно. Хааяа гарц нь зогсоогоороо явахын аргагүй нам, хааяа харин сүм мэт өндөр байлаа. Уулын хананд ус нэвчсэн, хүйтэн тул бид даарахгүйн тулд нөмрөгөө өмслөө.

- Магадгүй бид эндээс хэзээ ч гарч чадахгүй, зэвсгийн дархны агуйд хүрэхгүй байх гэж Юм-Юм хэллээ.

Маш их өлсөж байсан тул цатгадаг талхнаасаа идлээ. Хэдий хүртэл явахыг сайн мэдэхгүй учир талхнаасаа жаахан л идлээ. Идэх зуураа цааш явсаар. Тэгсээр гурван тийш салаалсан гарцтай өөр нэг газар хүрэв.

Хадны хананаас ус доошоо урсана. Миний ам ч цангаж байлаа. Би түүнээс уухад амт нь ч мэдэгдсэнгүй. Гэхдээ тэнд өөр усгүй юм чинь. Би усаа уугаад Юм-Юм уруу эргэж харав. Гэтэл тэнд Юм-Юм алга. Намайг ус залгилах хооронд хойноосоо явж байна гэж санаад нөгөө гарцны нэгээр цаашаа явсан юм болов уу.

Эхлээд би айгаагүй. Салаалсан замын эхэнд зогсоод, Юм-Юм хаагуур нь явсан бол гэж бодлоо. Тэр лав холдож амжаагүй байх, юу ч байсан хойноос нь дуудаад үзье.

"Юм-Юм, чи хаана байна?" гэж би чадах чинээгээрээ чанга хашграв.

Гэтэл миний дуу хачин гэгч нь шивнээ болж хувирав. Тэр уул ямар учиртайг би мэдсэнгүй. Хадан хана нь миний дуугарсан дууг өөртөө шингээж аваад, гадагш гаргахдаа харин дууг минь боомилон шивнээ

болгожээ. Миний хашгирсан тэр дуу шивнэсэн цуурай болж гарлаа.

"Юм-Юм, чи хаана байна? Юм-Юм, чи хаана байна ... Юм-Юм, чи хаана байна?" гэж харанхуй хонгилоос цуурайтна.

Би айж эхэллээ. Улам чанга хашгирсан боловч, уул шивнэсэн хэвээрээ. Надад сонсогдож буй тэр авиа миний хоолой гэдэгт би итгэсэнгүй. Уулан дотор байгаа өөр хэн нэгэн надаар даажигнах мэт.

"Юм-Юм, чи хаана байна? Юм-Юм, чи хаана байна ... Юм-Юм, чи хаана байна?" гэж шивнэнэ.

Би ямар их айв аа! Би замын зүүн салаа уруу гүйж орсноо, буцаж байрандаа ирээд, баруун тал уруу эргэснээ буцаж ирээд, дунд зам уруу нь орлоо. Юм-Юм, чи ямар замаар явсан бэ? Тэр гарч буй дуу жихүүцмээр муухай тул би дахиж хашгирч дуудахаа байлаа. Гэхдээ Юм-Юм намайг өөрийг нь ямар их үгүйлэн байгааг мэдрээд над дээр эргээд ирмээр юм даа.

Зам дахин салаалсаар. Харанхуй зам зүг бүрт гарч, би тэдгээрийн хооронд гүйсээр л. Нээрээ би чинь хариг эр шүү дээ. Тэгэхлээр яаж уйлах вэ? Гэвч яг одоо би хариг эртэй манатай. Юм-Юм намайг хайж, харанхуй хонгилоор гүйж яваа даа, бас. Тийнхүү бодтол туршуулууд Мирамисыг авч явахад би яаж уйлсантай адил, хүйтэн хадан дээр хэвтээд нулимс асгаруулж гарлаа. Одоо би морь ч үгүй, найз ч үгүй боллоо. Гав ганцаар үлдэв. Тийнхүү уйлж хэвтэхдээ, энэ оронд юунд ирлээ хэмээн амаа барьж, мөн аав яагаад намайг Катотай тулалдуулахаар явуулсныг ойлгохгүй байлаа. Энд байдаг ч болоосой. Тэгвэл энэ тухайгаа түүнд хэлэх

сэн.

"Намайг яаж ганцаардан шаналж байгааг та харж байна уу? Миний хамгийн сайн найз Юм-Юм алга боллоо. Би гав ганцаараа. Та л намайг дээрэмчинтэй



тулалдуулахыг хүссэнээс ийм юм боллоо" гэж би түүнд хэлэх юм сан.

Намайг ийм адал явдалтай учруулсан аавыгаа буруутгах бодол анх удаа орж ирэв. Ийнхүү уйлж хэвтэх хооронд би гэнэт хаан аавынхаа дуу хоолойг сонсох мэт боллоо. Санаандаа ургуулан бодсон байх л даа, гэвч гарцаагүй түүний дуу мөн байсан юм.

- Мио, хүү минь гэж тэр өгүүлэв.

Өөр юу ч хэлсэнгүй. Тэр надад битгий ингэж гуниглаач гэж хэлэхийг хүссэн бололтой. Тэгэхлээр нь би зориг орж, Юм-Юм заавал олдоно байх гэж итгэлээ.

Газраас босоход, халааснаас минь нэг юм уналаа. Тэр нь Нонногийн надад урлаж өгсөн жижигхэн лимбэ байлаа. Ногоон нугын арал дээр түүдэг галын дэргэд суугаад тоглож байсан миний лимбэ.

Нонногийн бидэнд зааж өгч байсан тэр нэгэн эртний аялгууг тоглож үздэг юм билүү гэсэн санаа надад төрлөө.

Бие биенээсээ төөрвөл энэ аяыг л тоглоно шүү гэж бид хоёр тэр үед хэлж байснаа саналаа.

Би хөгжмийг уруулдаа хүргэлээ. Гэвч би зориглон үлээж чадахгүй л байв. Түрүүн намайг хашгирахад гарсан шиг жихүүцэм дуу гарвал яана гэхээс айж байв. Гэлээ ч би оролдож үзэхээр шийдэв. Ингээд би аялгуу тоглож эхлэв.

Хөөх, тэр ая тодоос тод дуулдлаа! Тэр харанхуй агуйд Ногоон нугын арал дээрхээс илүү гоё, цэвэрхэн, чихэнд чимэгтэй сонсогдлоо.

Ая тоглож дуусчхаад би чагнав. Холоос хол, уулын хойноос нэг хөнгөн аялгуу дуулдав. Сонстох төдий тэр аяыг би сонсоод, Юм-Юм надад хариу өгч буйг мэдлээ. Би хэзээ ч ингэж баярлаж байсангүй.

Хэдийгээр би баяртай байсан ч уйлсаар л байлаа. Би агуй дотор цааш явахдаа лимбээ үлээж, бас жаахан жаахан уйлсаар л байлаа. Аялгуу тун ойр дуугарч, би ч тэр зүг үрүү алхлав. Хөгжим улам ойртсоор. Нөгөө лимбэнээс гарах эртний аялгуу улам тодорч, чангарсаар.

Гэнэт Юм-Юм харанхуй гарц дотор, миний өмнө зогсож байв. Миний хамгийн сайн найз Юм-Юм! Би гараа сарвайж түүний мөрөн дээр тавив. Мөн үү, биш үү гэдгийг шалгасан юм. Тийм ээ, тэр мөн байна, миний хамгийн сайн найз.

- Хэрвээ би Ноннотой хэзээ нэгэн цагт уулздаг юм бол, бидэнд лимбэ хийж өгсөнд нь талархана аа гэж Юм-юм хэлэв.

- Би ч гэсэн тэгнэ гэж би хариулав.

Дараа нь "Ноннотой уулзах цаг ирэх болов уу," гэж

бодлоо.

- Юм-Юм, аль замаар явах вэ? гэж намайг асуухад.

- Хоёулаа хамт л явж байвал аль ч замаар явсан яахав гэлээ.

Би ч гэсэн тэгж л бодож байна. Бид хоёр хөгжмөө тоглоод л цаашаа яваад байв. Хамтдаа болохоор айхаа ч болив. Хав харанхуй ууланд эгшиглэх эртний энэ нэгэн аялгуу биднийг дэмжиж, зоригжуулах мэт тодоос тод дуугарна.

Зам улам доошилсоор. Харанхуйг гэрэлтүүлэх бүдэг гэрэл улам тодорсоор. Хаа нэгтээ гал асч байгаа болов уу гэмээр. Тийм ээ, уулын дүнсгэр хананд гэрэлтэх нь гал мөн байлаа. Сүүмэлзсээр улам тод болно.

Галд дөхөж ирлээ. Зэвсгийн дархны агуйд орохдоо эртний нэгэн аялгуугаа тоглосоор л байв.

Тэгээд их гал дүрэлзүүлсэн төмрийн дархны газар ирлээ. Тэнд томоос том дөш, өмнө нь нэгэн эр зогсож байлаа. Түүнээс том, хүчтэй эрийг би хэзээ ч харж байсангүй. Тэр өтгөн улаан үс, өтгөн улаан сахалтай аж. Тортог болсон тэр эр томоос том, тас хар гартай бут мэт шигүү хөмсөгтэй бөгөөд биднийг ороход хөмсгөө өргөн, маш их гайхаж харлаа.

- Хэн миний ууланд хөгжимдөнө вэ. Тэр хэн гээч вэ? гэж асуулаа.

- Алс холын орноос ирсэн хариг эр, дагуултайгаа явна. Хаан хүү Мио таны ууланд хөгжимдөв гэж Юм-Юм хариулав.

Зэвсгийн дархан над уруу ойртлоо. Хөө тортог болсон долоовор хуруугаа миний духанд хүргээд,

- Нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой хүү байна. Чи

миний ууланд ямар сайхан хөгжимдөнө вэ хэмээв.

- Би танаас илд гуйж ирлээ. Эно намайг тань уруу явуулсан билээ гэж би хэлэв.

- Чи илдээр яах гэсэн юм? гэж зэвсгийн дархан асуув.

- Би дээрэмчин Катотай тулалдах гэсэн юм гэж үнэнээ хэлэв.

Үгээ хэлж дуусав уу үгүй юу дархан миний урьд өмнө хэзээ ч сонсч байгаагүй аймаар чанга дуугаар,

- Дээрэмчин Като, дээрэмчин Като! Тэр сөнөвөл таарна! гэж уулыг доргитол орилов.

Холын харанхуй гарцаар аянга ниргэх мэт их чимээ гарлаа. Зэвсгийн дархныг ийнхүү хашгирахад, түүний дуу шивнээ болсонгүй. Уулын хананд цуурай нь тэнгэр нижигнэхээс ч илүү чанга дуугарав.

Зэвсгийн дархан гараа зангидан зогсож, хилэнт бараан нүүрэн дээр нь галын гэрэл тусна.

- Дээрэмчин Като, тэр сөнөвөл таарна! гэж тэр ахин дахин хашгирлаа.

Галын дөл, хананд эгнүүлэн өлгөөстэй хурц илдийг гэрэлтүүлэхэд гялтганан үзэгдэх нь сүртэй. Би сайн харахын тулд чанх урд нь очиж зогслоо. Дархан хашгичсан хэвээр над уруу ойртлоо.

- Миний ширээсэн илдийг харж байна уу? Бүгдээрээ хурц. Би дээрэмчин Катод энэ бүгдийг хийж өгдөг. Катогийн зэвсгийн дархан нь би байна гэж тэр хэллээ.

- Та түүний дархан нь байж яагаад Катог сөнөөсэй гэж хүсээд байгаа юм бэ? гэж би асуулаа.

Тэр гараа хувхай цагаан болтол нь зангидав.

- Яагаад гэвэл зэвсгийн дархан нь Катог хамгийн их

үзэн ядддаг гэсэн хариу өглөө.

Зэвсгийн дархан уулын хананд гинжээр уяатай байсныг би дөнгөж сая л олж харлаа. Алхам бүрт нь гинж хангинана.

- Таныг яагаад гинжилсэн юм бэ? Та наадахаа гал дээр улайсгаад, дөшин дээрээ тавиад тасалчхаж болдоггүй юм уу? гэж би асуув.

- Дээрэмчин Като энэ гинжийг өөрийн гараар хийсэн юм. Ямар ч гал, ямар ч алх үүнийг үл дийлнэ. Катогийн хорон санааны гинжийг тасална гэдэг тийм ч амар юм биш гэж дархан хэллээ.

- Та яагаад ийм гинжээр гинжлүүлсэн юм бэ? гэж би асуув.

- Би зэвсгийн дархан. Би сайн санаатай, гэмгүй хүмүүсийг хөнөөх зэвсгийг нь хийж өгдөг. Ийм учраас Като намайг хамгийн бат бөх гинжээр гинжилсэн юм. Миний илдгүйгээр тэр оршин тогтнохгүй гэж дархан хариуллаа.

Тэрээр намайг дүрэлзсэн гал мэт нүдээр ширтэв.

- Би агуйд сууж, өдөр шөнөгүй л Катод илд урладаг. Харин нэг илдний талаар тэр юу ч мэдэхгүй, тэр нь энэ байна гэж дархан өгүүлээд, агуйн тас харанхуй буланд очиж, хадны завсраас нэгэн илдийг сугалан гаргалаа. Тэр илднээс гал маналзах шиг.

- Мянга мянган жилийн өмнө би чулуу зүсдэг илд урласан билээ. Энэ шөнө л миний хэрэг бүтэх нь байна гэж тэр хэллээ.

Дархан илдээ далайн, ганцхан цавчихад уулын хана зүсэгдэн унав.

- Миний илд, миний галын дөл. Чулуу цавчигч илд



минь гэж тэр бувтнана.

- Та чулуу цавчдаг илдээрээ яах гэж байгаа юм бэ? гэж би асуув.

- Би чамд учрыг нь хэлээд өгье. Энэ илдийг сайн санаатай гэмгүй хүмүүст зориулж хийгээгүй. Зөвхөн дээрэмчин Катод зориулсан билээ. Түүнийг чулуун зүрхтэй хүн гэж чи мэдээгүй хэрэг үү? гэж дархан тайлбарлав.

- Үгүй, би ер нь түүний тухай бараг юу ч мэдэхгүй. Гагцхүү түүнтэй тулалдахаар ирснээ л мэдэж байна гэж би хэлэв.

- Тэр чулуун зүрх, төмөр сарвуутай гэж дархан хэлэв.

- Төмөр сарвуу?

- Чи мэддэггүй байсан юм уу? Түүний баруун гарын оронд төмөр сарвуу байдаг юм гэж дархан өгүүлэв.


- Тэр тэгээд төмөр сарвуугаараа яадаг юм бэ? гэж би асуув.

- Тэр түүгээрээ хүмүүсийн цээжнээс зүрхийг нь суга татан авдаг. Төмөр сарвуугаа дотогш ганцхан оруулаад л зүрхийг нь гаргаад ирнэ, оронд нь тэр чулуун зүрх хийж өгдөг билээ. Түүний ойр хавьд байх бүх хүмүүс чулуун зүрхтэй байх хэрэгтэй гэсэн зарлигтай гэж зэвсгийн дархан хэллээ.

Үүнийг сонсоод хамаг бие арзасхийв. Түүнтэй тулалдах юм сан гэж би улам их хүслээ.

Зэвсгийн дархан миний хажууд зогсоно. Тэр тортогтой гараараа илдээ илнэ. Тэр илд лавтай түүний хамгийн нандин юм нь байх.

- Чулуу хага цавчдаг илдээ надад өгөөч. Дээрэмчин



Катотай тулалдахад хэрэгтэй байна гэж би түүнээс гуйв.

Зэвсгийн дархан удаан гэгч нь бодолхийлснээ, над уруу хараад,

- Тийм ээ, чи миний галын дөлийг ав даа. Учир нь чи нүүрэндээ галтай, нүдэндээ цогтой хүү байна. Чи бас миний ууланд маш сайхан хөгжимдсэн гэж тэр эцэст нь хэлэв.

Гал мэт илдээ надад бариулахад, илдний дөл миний биеэнд шингэн орж, миний бие хүч чадлаар дүүрээд ирэх шиг боллоо.

Зэвсгийн дархан дараа нь уулын ханан дээр очиж, хадан хавцлыг хажуу тийш болгов. Тэнд нь том нүх

онгойн гарлаа. Хүйтэн салхи орж ирж, усны хөөсөрсөн давалгааны чимээ гарлаа.

- Дээрэмчин Като их юм мэднэ. Гэхдээ намайг ууландаа цоорхой гаргасныг мэдэхгүй. Шоронгоос гарах хаалгатай болохын тулд би олон жил хөлсөө урсгасан юм гэж дархан өгүүлэв.

Би онгорхой дээр очоод, сөнөсөн нуурын цаана орших дээрэмчин Катогийн цайзыг харлаа. Шөнө болсон байв. Миний урьд нь харж байсантай л адил дүнсгэр, харанхуй цайз үзэгдэв. Мөн урьдын л адил тэндхийн цорын ганц цонх муу ёрын нүд мэт нууран дээрээс ёлтойно.

Юм-Юм хажууд минь ирлээ. Бид чив чимээгүй зогсоод, тулалдаан удахгүй болох нь ээ гэж бодлоо.

Миний араас зэвсгийн дархны ярих сонсогдов.

- Удахгүй, тун удахгүй дээрэмчин Катогийн эцсийн тулалдаан болно гэж тэр бувтнана.

Төмөр сарвуу

Нууран дээгүүр бараан үүл нүүж, илбэдүүлсэн шувууд тэнгэрээр нэг ганганана. Давалгаа хөөсөрч, сөнөсөн нуур луу жижиг завийг шидэлнэ. Магадгүй давалгаа тэр завийг Катогийн цайзын доорх хаданд мөргүүлж, хэмх цохих ч юм билүү.

Өндөр хадан хавцлын дундах тохойд байрлах завины уяаг тайлахыг минь зэвсгийн дархан харж зогслоо.

Като ихийг мэдэх ч сөнөсөн нуур миний уулнаас эх авдгийг, бас хадан хавцлын цоорхой дор завины нууц зогсоол буйг тэр мэдэхгүй.

- Та гинжлүүлсэн байж завиар яах гэж байгаа юм бэ? гэж би асуув.

- Би цоорхойн дундуур гарч, чадах ядахаараа гинжээ чирэн, гурван завины хэртэй урт газар сэлүүрддэг гэж тэр хэлэв.

Том биетэй, тортог болсон тэрээр зогсоол дээр зогсоход харанхуйд түүнийг олж харахад ч бэрх байв. Гэхдээ би дарханы инээхийг сонслоо. Хачин, аймаар ч юм шиг инээв. Тэр ер нь хүн яаж инээдгийг мэддэггүй мэт сэтгэгдэл төрүүлэв.

Като ихийг мэдэх ч, өнөө шөнө сөнөсөн нуурыг хэн завиар гатлахыг мэдэхгүй гэж түүнийг хэлэхэд би:

- Танд ч бас мэдэхгүй юм нэг байна. Та завиныхаа

барааг дахин харах эсэх. Өнөө орой далайн ёроолд орох ч юм билүү. Юм-Юм бид хоёр тэнд мөнх нойрссон байвал та яах вэ? гэж асуухад зэвсгийн дархан гүнзгий санаа алдаад,

- Тэгвэл би, "Ханхүү Мио, тайван нойрсоорой," л гэнэ дээ гэлээ.

Би завиа сэлүүрдэж, дархныг дахиж харсангүй. Тэр харанхуйд үзэгдэхгүй ч бидний хойноос хашгирах нь сонстов. Нууц зогсоол, сөнөсөн нуур хоёрын дундах нарийхан нүхээр гарах зуур тэр хэлэх нь:

- Ханхүү Мио, болгоомжтой байгаарай! Төмөр сарвуу харагддаг л юм бол илдээ бушуухан гаргаарай. Эс тэгвээс ханхүү Мио өнгөрөнө шүү!

"Ханхүү Мио өнгөрөнө шүү ... ханхүү Мио өнгөрөнө шүү" гэж хадан хавцлаар нэг гунигтай гэгч нь цуурайтлаа. Гэвч надад энэ талаар бодох цаг байсангүй. Сөнөсөн нуурын ширүүн давалгаа биднийг дархныхаас аль хэдийн холдуулсан байв.

Юм-Юм бид хоёр хөлгүй далайгаар аялахдаа эмээж явсан нь мэдээж.

- Завь ийм жижигхэн, далай ийм гүнзгий, давалгаа ийм ширүүн, чи бид хоёр ийм жаахан биш байдаг ч болоосой гэж Юм-Юм өгүүлэв.

Сөнөсөн нуурын давалгаа догшрохыг яана! Би хэзээ ч ийм аймшигтай тулгарч байсангүй. Давалгаа бидэн үрүү дайрч, өндөрт гаргаж, өөдөөс дахин ирэх ширүүн давалгаа уруу шидэлнэ. Завиа сэлүүрдэх ч арга үгүй. Юм-Юм бид хоёр сэлүүрээ чанга атгасаар. Гэтэл тал талаас эрчлэн боссон давалгаа хоёр сэлүүрийг юу ч үгүй хамж аваад явчхав. Цаанаас нь исгэцсэн, хөөсөрсөн,



бургилсан, байшингийн дайтай өндөр давалгаа ар араасаа хуйлран ирэх нь тэр.

- Бид сэлүүргүй болсон. Хэрвээ давалгаа Катогийн хадан хавцал мөргөвөл бид удахгүй завиа алдах нь ээ гэж Юм-Юм хэлэв.

Илбэдүүлсэн шувууд тал талаас нисч ирлээ. Тэд биднийг тойрч, хашгиран, улам ойртлоо. Гялалзсан, гунигтай, жижигхэн нүд нь харанхуйд тодхон.

- Чи Нонногийн ах уу? Чи Йиригийн дүү юу? гэж би асуулаа.

Гэтэл тэд над уруу гялалзсан, гунигтай, жижигхэн нүдээрээ харж, цөхрөнгөө барсан аятай л ганганана.

Сэлүүрээ алдаж жолоогүй болсон завь Катогийн цайзны чанх өөдөөс ойртсоор. Давалгаа биднийг хадан хавцал мөргүүлж, дээрэмчин Катогийн хөлд сөхрүүлэх нь. Аюултай хад, муу ёр шингээсэн нүдтэй цайз улам ойртсоор, давалгаа ч хурдассаар, ширүүссээр.

- Мио, одоо ... одоо ингээд бүх юм өнгөрөх нь!

Гэтэл гайхалтай юм тохиолоо. Бүх зүйл дуусах нь гэж бодох зуур давалгаа зөөлөрсөөр намдав. Нуур намуухан долгиолж эхэллээ. Давалгаа завийг маань аймшигт хадан цохионы хажуугаар зүгээр өнгөрөөж, Катогийн цайз байрлах хар хавцлын зүг аажим чиглэлээ.

Догшин давалгаа яагаад гэнэт номхорсныг би ойлгосонгүй. Магадгүй давалгаа хүртэл дээрэмчнийг үзэн ядах тул түүнтэй тулалдахаар яваа хэн нэгэнд туслахыг бодсон юм болов уу. Энэ нуур цагтаа эргэн тойрон хадтай, баяр баясгалантай, жижигхэн цэнхэр нуур байсан байх даа. Зуны сайхан өдрүүдэд нар тусч, найрсаг бяцхан давалгаанууд чулуу долоож нааддаг

байсан биз ээ. Магадгүй тэр цагт илбэдүүлсэн шувуудын гаслант дууны оронд эрэгт нь наадаж, усанд сэлэн яваа хүүхдүүдийн инээд хангинаж байсан ч юм билүү. Тэгээд л давалгаа хилэгнэж, цайзнаас ширтэх ганц нүд ба бидний хооронд хөөсөн хана босгосон байх.

- Сайн санаат нуур чамдаа баярлалаа. Догшин давалгаа та нартаа ч бас адил талархъя гэж би хэлэв.

Давалгаа арилж, нуурын хар ус юу ч үл хэлнэ. Дээрэмчний цайз тээр дээр, эгц хадан дээр харагдана. Бид эрэгт нь ирсэн байлаа. Катод хэзээ ч тийнхүү ойртож очоогүй бөгөөд тулааны шөнө биднийг хүлээж байна.

Мянга мянган жилийн турш энэ мөчийг хүлээсэн түмэн олон шөнийн тулаан болоод миний тухай мэдээ болов уу? Аав миний тухай бодож байгаа болов уу? Тэр хаа нэгтээ намайг бодон гуниглаж, "Мио, хүү минь" гэж шивнэн суугааг би мэднэ ээ. Галын дөл мэт хурц илдээ би тэмтэрлээ. Эрэгчин эмэгчнээ үзэх аймшигт тулааныг би тэсэн ядан хүлээнэ. Үхсэн ч сэхсэн ч Катотай нэгийгээ үзнэ дээ.

- Мио, би маш их өлсч байна гэж Юм-Юм хэлэв.

Ингээд Катогийн цайзны доорх хадны ёроолд сууж, цатгадаг талхнаасаа идлээ. Гэдэс цадаж, хүч тэнхээ тэгширч ирлээ. Сүүлчийн талхаа идчихлээ. Хэзээ дахин хоолтой залгахыг бүү мэд.

- Одоо хоёулаа хадан дээр гаръя. Катогийн цайз уруу нэвтрэх ганц боломж гэж би Юм-Юмд хэлэв.

Тэгээд эгц, өндөр хаданд авирч эхэллээ.

- Хад ийм эгц, шөнө ийм харанхуй, бид ийм жижигхэн бус ч болоосой гэж Юм-Юм амандаа хэлнэ.

Хүнд хэцүү ч аажим аажмаар дээшилсээр. Хадны

аль л ирмэг, хонхорхойг олж гишгэн дээш ахисаар байлаа. Заримдаа яахаа үл мэдэн, “Гэнэт доош унавал яана,” гэсэн бодол орж ирнэ. Азаар ямар нэг барих юм хаднаас олдсоор байлаа. Хариугүй унахын даваан дээр хад өөрөө надад гишгүүр гаргаж өгөөд байгаа мэт. Нүцгэн хад хүртэл Катог үзэн ядаж, түүнтэй тулалдахаар ирэгсдэд туслахыг хүссэн юм болов уу.

Катогийн цайз нуурнаас тэнгэрт тулам өндөрт оршино. Тэр зүг тасралтгүй авирсаар байлаа.

- Удахгүй бид хүрэх гэсэн газартаа очих нь гэж би Юм-Юмд шивнэв. Тэгээд хэрэм даваад...

Шөнө дунд болж байх шиг. Гэтэл хоорондоо ярилцах туршуулын дуу гарлаа. Манаанд гарч байгаа хоёр туршуулын яриа чих дэлслээ.

- Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! Катогийн зарлигийн дагуу цагаан морь унаж ирсэн дайсныг баригтун. Уулын агуй, ойн модон дунд, газар тэнгэр, хол ойргүй хайцгаа! гэж тэдний нэг хэлэв.

- Ойр хавьдаа хайцгаа. Дайсан бидний дунд байж магад. Шөнөөр хэрэм давж байгаа ч юм билүү. Хаа сайгүй хайцгаа! гэж өөр нэг туршуул хэлэв.

Түүнийг бамбар асаахыг хараад зүрх минь зогсох шахав. Тэр хэрэм үрүү гэрэл тусгах л юм бол биднийг олж харна. Тэр жадаараа ганцхан хатгаад л, түлхэхэд л цагаан унага унаж ирсэн дайсныг ахиж хэзээ ч хайх хэрэггүй болно. Бид яахав, орь дуу тавьсаар л сөнөсөн нуур луу унаж живэх биз.

- Хай, хаа сайгүй хайцгаа! Хэрмийг бамбараараа гэрэлтүүл. Дайсан хананд авирч байж магад. Хаа сайгүй хайцгаа! гэж нэг туршуул хэлнэ.

Нөгөө нэг туршуул нь барьж байсан бамбараа хэрэм өөд өргөлөө. Хадны хананд гэрэл тусахад бид муурнаас нуугдах хулгана мэт дагжин айв. Бамбарын гэрэл ханаар мөлхөж, улам ойртсоор.

- Мио, бүх юм өнгөрлөө! гэж Юм-Юм шивнэв.

Гэтэл гайхалтай юм боллоо. Нуурын зүгээс шувуун цуваа айсуй. Илбэдүүлсэн шувууд далавчаа сүр сар хийтэл дэвсээр ирлээ. Тэдний нэг нь туршуулын гартаа барьсан бамбарыг мөргөхөд, тэр нь доошоо сөнөсөн нуур луу унах нь тэр. Тэгтэл усанд бас нэг хэсэг гал дүрэлзэж харагдав. Аварсан шувуу далавчаа галд хуйхлуулан нуурын мандал дээр унан, живж байлаа. Шатсан далавчтай тэр сөнөсөн нуурын давалгаанд орж алга боллоо.

Хөөрхий тэр шувууг бид хэчнээн өрөвдсөн гээч.

- Шувуухай та нартаа их баярлалаа гэж шувуу биднийг хэзээ ч сонсохгүйг мэдсэн ч гэсэн би шивнэн хэллээ.

Нүдэнд нулимс цийлгэнэвч би туршуулуудыг бодлоо. Одоохондоо хэрэм давж амжаагүй тул бидний өмнө олон аюул нүүрлэсэн хэвээрээ.

Туршуулууд нөгөө шувуунд маш их хилэгнэж байлаа. Тэд яг бидний дээр хэрмийг хамгаалан зогсоно. Тэдний зэвүүн, хар малгай зэрвэс үзэгдэж, хоорондоо ярих жигшүүртэй муухай дуу нь сонсогдоно.

- Хайцгаа, хаа сайгүй хайцгаа! Дайсан хадны нөгөө талаар авирч байж магад. Хайцгаа! гэж тэд орилолдоно.

Тэдний алхаа холдох нь, өөр зүг үрүү гүйцгээв бололтой.

- Одоо! гэж би Юм-Юмд шивнэв.

Тэр агшинд хэрэм өөд авирлаа. Харанхуйд хэрмийг маш хурдан давж Катогийн цайз уруу гүйлээ. Хар хананд нь наалдан хөдөлгөөнгүй зогсохдоо, туршуулууд харах вий гэсэн айдас биднээс салахгүй байлаа.

"Тийшээ яаж орох вэ? Ертөнцийн хамгийн хар цайзад хэрхэн нэвтрэх вэ?" гэж Юм-Юм гайхширна.

Түүнийг хэлж дуусмагц хананд зэрх хаалга онгойлоо. Бидний хажуугийн хар хаалга чив чимээгүй нээгдлээ. Ер бусын, аймаар нам гүн болчхов. Хэрвээ тэр хаалга аяархан ч болов чахарч дуугарсан бол ийм аймаар байхгүйсэн! Гэвч тэр нь хамгийн дуугүй нээгдсэн хаалга байлаа.

Юм-Юм бид хоёр хөтлөлцсөөр цайзад нэвтэрлээ. Бид урьд урьдынхаасаа илүү их айж байв.

Учир нь Катогийн цайзан доторх шиг ийм тас харанхуй, ийм зэврүүн хүйтэн, ийм чив чимээгүй байдал өөр хаана ч байхгүй билээ.

Хаалгаар ормогц нарийхан бараан шат харагдав. Түүнээс өөр, харанхуй өндөр шат би хэзээ ч үзэж байсангүй.

- Энэ харанхуй ямар аймаар юм бэ. Като ийм хэрцгий бус, чи бид хоёр ийм жижигхэн биш болоосой гэж Юм-Юм шивнэв.

Би илдээ ташаандаа зүүгээд эхэнд нь, Юм-Юм миний араас шатаар өгслөө.

Зүүдэндээ би хааяа таньж мэдэхгүй харанхуй, жихүүцэл төрөм байшин дотор явдаг сан. Амьсгаа бачимдуулсан хар өрөө, алхахаар л доошоо цөмөрч унам шал, яйжгий шат гээд л. Гэвч Катогийн цайз нь



ямар ч зүүдний байшинтай зүйрлэшгүй зэвүүн.

Бид өгсөөд л байлаа, шатны эцэс хаана байгааг даанч мэдэхгүй юм даа.

- Мио, би айгаад байна гэж Юм-Юм миний ард шивнэлээ. Би эргэж хараад, гараас нь хөтлөх гэтэл Юм-Юм алга. Тэр газрын ангал уруу орсон мэт гэнэт алга болсон байлаа. Зэвсгийн дархны ууланд төөрч байсан маань юу ч биш юм шиг санагдлаа. Би хашгирч зүрхэлсэнгүй, чичирсэн гараараа хажуугийн ханаа тэмтрэн,

- Юм-Юм аа, чи хаана байна? Эргээд ирээч дээ! гэж уйлав.

Гэвч хүйтэн, хатуу хана хариугүй. Юм-Юмыг хаа нэгтэйгээс гаргаад ирье ч гэсэн ямар ч нүх цоорхой алга. Эргэн тойрон чив чимээгүй. Хэчнээн их нулимс асгаруулсан ч найз минь хариу байдаггүй.

Ертөнц дээр цорын ганцаар үлдсэн мэт эвгүй бодол өвөрлөн шатаар аажуухан дээшилж хөлөө дааж ядан зөөлөө. Учир нь шат маш өндөр, гишгүүр нь маш олон.

Гэлээ ч эцсийн гишгүүрт хүрлээ. Би түүнийг хамгийн сүүлийнх гэж мэдсэнгүй. Харанхуйд шатаар авирч байгаа юм чинь мэдэхийн ч аргагүй.

Нэг алхтал хөл доор минь хоосон агаар. Би орилоод доош уналаа. Азаар би хамгийн сүүлийн шатнаас зуурч амжив. Би хөлөө савчин, хөл хүрэх газрыг тэмтрэн хайлаа. Гэтэл барьцгүй харанхуйгаас өөр юу ч алга. Доошоо унаж, бүх юм өнгөрөх нь гэж бодлоо. Надад хэн нэгэн тусалдаг ч болоосой доо!

Шатаар хэн нэгэн өгсөж байлаа. Юм-Юм биш байгаа?

- Юм-Юм найз аа, надад туслаач! гэж би гуйв.

Харанхуйд түүний нүүр харагдсангүй. Би найзынхаа инээмсэглэсэн царай, Бэнкатай адил нүдийг нь олж харсангүй. Гэтэл тэр надад юм хэлээд ч байх шиг.

- Надад гараа өг, тэгээд би чамд туслая гэх нь сонсдов.

Ингээд би түүний гараас барилаа. Гэтэл тэр нь гар бус, төмөр сарвуу байв.



Аюултай илд

Нэг л өдөр би түүнийг мартана. Нэг мэдэхэд л би дээрэмчин Катогийн жихүүцэл төрүүлсэн нүүр, нүд, төмөр сарвууг мартсан байх болно. Би тэр өдрийг хүлээсээр. Тэгвэл би түүний өрөөг ч бас мартана.

Дээрэмчний цайзын нэг өрөөнд агаар нь уур хорслоор дүүрсэн байдаг. Като тэр өрөөндөө өдөр шөнөгүй сууж, муу юм бодож олдог тул тэр бүхэн агаарт нь шингээд, амьд амьтан амьсгалахад нэн бэрх ажээ. Тэндээс урсаж гарах хорон санаа гадаа байгаа бүх сайн сайхан, амьтай бүхнийг хордуулна. Иймээс тэндхийн цэцэг навч, зүлэг юу ч үгүй алга болжээ. Түүгээр ч зогсохгүй муу санаа нь нарыг халхалж, хэзээ ч өдөр үзэхээ байж. Шөнө нь шөнөтэй төстэй нэг юм л байдаг аж. Тэр өрөөний цонх сөнөсөн нуурын хажуугаас муу ёрын нүд мэт харагдах нь ийм учиртай. Като тэндээ сууж хорон санаагаа цонхоороо дамжуулдаг. Тэр өдөр шөнөгүй өрөөндөө суудаг юм санж.

Намайг тэр өрөөндөө аваачсан юм. Миний хоёр гар чөлөө завгүй, илдээ сугалах амжил өгөлгүйгээр Като намайг барьж авсан. Хар туршуулууд нь харин энд хүргэсэн. Тэнд Юм-Юм цонхийсон царайтай, гуниглангуй зогсоно. Намайг хараад тэр:

- Мио, одоо ингээд бүх юм өнгөрлөө гэж шивнэв.

Дээрэмчин өрөөндөө орж ирлээ. Бид түүний жигшмээр муухай нүүрний өөдөөс харж зогслоо. Тэр

хөдөлгөөнгүй зогсоод, биднийг ажна. Түүний хорсол усны хүйтэн урсгал мэт урсаж, шатах гал мэт бидний бие үрүү орно. Бид түүгээр нь амьсгалж, хамаг бие сул оргив. Би илдээ ч сугалж авах тэнхэлгүй болжээ. Туршуулууд миний илдийг Катод дамжуулахад тэр татвалзан,

- Би ийм аюултай илд хэзээ ч харж байсангүй гэж өөрийн хамгаалагч туршуулнартаа хэлэв. Тэр цонхондоо ойртоод, илдийг барьж үзнэ.

- Би үүгээр яах вэ? Сайн санаатай болон гэмгүй хүмүүсийг устгах илд биш байна. Би одоо үүгээр яах болж байна?

Намайг илдээ авахыг хэчнээн их хүсч буйг тэр могойн нүдээрээ ажиглан харна.

- Би түүнийг сөнөсөн нуурын хамгийн гүн үрүү нь шидэж живүүлнэ. Би үүн шиг аюултай илд хэзээ ч харж байсангүй гэж Като өгүүллээ.

Тэр илдийг цонхоор чулуудав. Агаарт эргэлдэх сэлмээ хараад би цөхрөнгөө барав. Зэвсгийн дархан мянга мянган жилийн өмнө чулууг зүсэх шидтэй тэр илдийг урласан билээ. Тэр үеэс авахуулаад л Като г дийлнэ гэж найдсаар иржээ. Гэтэл дээрэмчин илдийг сөнөсөн нуур луу шидчихлээ. Би сэлэмээ ахиж хэзээ ч харахгүй байх даа.

Като бидэн үрүү ойртож ирэхэд, хорон санаанд нь би багтрах шахав.

"Намайг устгахаар ирсэн дайснуудаа би одоо яаж шийтгэх вэ? Сайн тунгааж үзье. Би тэднийг шувуун дүрстэй болгоод мянга мянган жилийн турш сөнөсөн нууран дээгүүр эргэлдүүлдэг юм билүү."

Тэрээр ингэж эргэцүүлэн бодох хоорондоо могойн



мэт нүднийх нь харц бидэн дээр тусна.

- Тиймээ шувуу болгоод хувиргая. Эсвэл би зүрхийг нь суга татаж гаргаад, оронд нь чулуун зүрх суулгая. Чулуун зүрх суулгачихвал өөрийн зарцаа болгоно оо гэж Като хэлэв.

"Намайг шувуу болгочих,, гэж хэлмээр байлаа. Учир нь чулуун зүрхтэй болох шиг аймшигтай юм хаа байхав. Гэвч би юу ч хэлсэнгүй. Яагаад гэвэл шувуу болгооч гэж гуйвал Като тэр дор нь чулуун зүрх цээжинд минь хийхийг би мэдэж байлаа.

Като биднийг дээрээс доош могойн нүдээрээ нэвт харна.

- Эсвэл би эднийг гянданд хийгээд өлсгөлөнд оруулдаг юм билүү. Надад зөндөө олон шувуу, зарц нар байна.

Като хэдэн алхам ухарснаа бодож гарав. Түүнээс гарч буй бодол бүр нь агаарыг улам хордуулна.

- Миний цайзад нэг шөнийн дотор л турж үхдэг. Шөнө нь маш урт, өлсгөх нь маш их учир ганцхан шөнийн дотор та хоёр үгүй болно оо.

Тэр миний өмнө зогсоод, жихүүцэл төрүүлсэн сарвуугаа мөрөн дээр минь тавилаа.

- Ханхүү Мио, би чамайг танина аа, цагаан морийг чинь хараад л чамайг ирж гэж мэдсэн. Би энд суугаад хүлээж байлаа. Чи ч ирсэн. Тулалдааны шөнө болно гэж чи бодоо биз.

Тэр тонгойгоод, чихэнд минь хорсолтойгоор өгүүлэх нь:

- Тулалдааны шөнө болно гэж бодсон бол чи эндүүрчээ, ханхүү Мио. Өлсгөлөнгийн шөнө. Өглөө

болоход өчүүхэн цагаан яснаас өөр юм үлдэхгүй. Мио, түүний дагуул хоёроос өөр юу ч үлдэхгүй.

Өрөөний голд байрлах том чулуун ширээг Като төмөр сарвуугаараа тогшиход, туршуулууд гүйлдэн орж ирлээ.

- Эднийг гянданд хорь! Долоон түлхүүрээр цоожил. Хаалганы хажууд долоо, цайзанд нийт далан долоон харуул гарга гэж дээрэмчин бидэн үрүү төмөр сарвуугаараа чичлэн хэлэв.

Тэгээд ширээнийхээ ард суулаа.

- Би өрөөндөө тайван сууж, муу муухайг бодож олмоор байна. Ханхүү Мио одоо надад саад болохгүй. Шөнө өнгөрөхөд та хоёроос үлдсэн хувхай цагаан ясыг чинь харна аа. Баяртай, ханхүү Мио. Өлсгөлөнгийн гянданд тавтай нойрсогтун!

Туршуулууд биднийг барьж аваад, цайз дундуур чирч гулдарсаар гянданд хүргэхээр явлаа. Хаа сайгүй л дээрэмчнийг хамгаалах харуулууд. Ийм олон харуул гаргахыг бодвол Като надаас тийм их айж буй хэрэг үү? Долоон туршуулаар сахиулсан, долоон цоожны цаана суух зэвсэггүй нэгнээс тэгтэл их айх гэж үү?

Туршуулууд гараас чанга атган, том харцайз дундуур явлаа. Тортой нэгэн цонхны хажуугаар өнгөрөхөд, гадсанд гинжлүүлсэн хар морь, хар унаганыхаа хамт зогсоно. Би тэр морийг хараад Мирамисаа саналаа. Дахиж түүнийхээ барааг харах өнгөрөв бололтой. Мирамисыг ер нь яасан бол, тэр амьд болов уу? Гэтэл туршуулууд намайг угз татан авч, цааш чирлээ.

Бид сүүлчийн шөнөө өнгөрөөх гянданд хүрэлцэн ирлээ. Хүнд төмөр хаалга нээж биднийг тийш нь



түлхлээ. Хаалга хангинан хаагдаж, туршуулууд бид хоёрыг долоон түлхүүрээр түгжих сонсдов. Юм-Юм бид хоёр тэнд хоёулаа үлдэв.

Зузаан чулуун ханатай бөөрөнхий энэ өрөөнд том төмөр тортой жижиг салхивч байна. Тэр салхивчаар сөнөсөн нууран дээгүүр эргэлдэх илбэдүүлсэн шувуудын ганганаа дуулдана.

Бид шалан дээр суулаа, айсан хоёр бяцхан хүүхэд өнөө шөнө үгүй болохоо мэдэж байв.

- Бид зовж үхэхгүй юм сан, бид хоёр ийм бяцхан бөгөөд ганцаардсан бус болоосой гэж Юм-Юм хэлэв.

Бид гар гараасаа хөтлөлцлөө. Хүйтэн чулуун шалан дээр гар гараасаа тас атган сууна. Ингэж байтал бид урьд өмнө нь хэзээ ч өлсөж байгаагүйгээр өлсөж эхлэв. Бид хамаг хүч тэнхээгээ соруулсан мэт болж, хэвтмээр

ч юм шиг, унтмаар ч юм шиг оргив. Гэхдээ бид сэрүүн байхыг хичээлээ. Мөхлөө хүлээх зуур Алс холын орны тухай ярилцав.

Аавыгаа бодтол нүдэнд минь нулимс бүрхээд ирэв. Өлсөж туйлдсан миний нулимс хацраар аажуухан урсана. Юм-Юм бас чимээгүй уйлна.

- Алс холын орон, Ногоон нугын арал ойрхон ч байдаг болоосой гэж Юм-Юм шивнэнэ.

- Юм-Юм аа, чи бид хоёр Ногоон нугын арал дээгүүр лимбэдэн гүйж явсанаа санаж байна уу?

- Санаж байна аа, гэхдээ тэрнээс чинь хойш нэлээд хугацаа өнгөрсөн.

- Хоёулаа энд ч гэсэн хөгжимдөж болно шүү дээ. Өлсөөд, нойрстлоо эртний нөгөө аялгууг тоглох уу? гэж би асуулаа.

- Тэгье, дахиад нэг хөгжимдье.

Ингээд лимбээ гаргалаа. Бидний сульдсан гар арай гэж хөгжмөө барьсан ч тэр нэгэн аялгууг тоглолоо. Юм-Юм маш их уйлж, нулимс нь хацраар нь нэг урсана. Би ч гэсэн тэгсэн байх, яаснаа мэдэхгүй байна. Эртний ая үнэхээр сайхан эгшиглэсэн ч удалгүй чимээгүй болохоо мэдэх мэт аяархан дуугарна. Гэвч илбэдүүлсэн шувууд тэр аялгууг сонсч амжсан байлаа. Тэд бүгдээрээ салхивчин дээр нисч ирлээ. Би тэдний гялалзсан, гунигтай бяцхан нүдийг торны завсраар харлаа. Удалгүй шувууд алга болж, бид үргэлжлүүлэн хөгжимдөж чадахаа болив.

- Хамгийн сүүлийн удаа хөгжимдлөө гэж хэлээд би лимбээ халаасандаа хийлээ.

Халаасанд бас нэг юм тэмтрэгдэв. Тэр нь Йиригийн

эгчийн жижиг халбага байлаа.

"Илбэдүүлсэн шувууд дахин наашаа ирээсэй," гэж хүслээ. Халбагаа харуулбал Йиригийн эгч лав танина даа. Гэтэл шувууд салхивчнаас аль хэдийн холджээ. Миний гар ямар ч тэнхэлгүй болсон тул, халбагаа газар унагав.

- Юм-Юм, үүнийг хар даа, чи бид хоёрт халбага байна шүү гэж би хэлэв.

- Тийм ээ, гэхдээ хоолгүй байхад хоосон халбагаар ч яах билээ дээ.

Юм-Юм тэгж хэлүүтээ л нүдээ аниад, шалан дээр хэвтээд өгөв. Би ч гэсэн туйлдав. Өлссөндөө юу ч хамаагүй идмээр санагдана. Хоолойгоор л давах юм байвал бушуухан нэг юм идэх сэн. Би цатгадаг талх, амны цангаа тайлдаг булгийн усыг үгүйллээ. Гэхдээ би ахиж хэзээ ч тийм юм үзэхгүй байх даа. Эдла эгчийн өглөө бүр надад хийж өгдөг миний дургүй сүүтэй будаа хүртэл санаанд орлоо. Одоо надад сүүтэй будаа өгсөн ч дургүйцэхгүй. Ямар ч юм хамаагүй ... юу ч хамаагүй идэх сэн! Сүүлчийн хүчээ шавхаж би идэх хоол байгаа мэт халбагаа амандаа хийв.

Тэгсэн чинь гайхалтай зүйл боллоо. Халбага хоосонгүй байв. Цатгадаг талх, амны цангаа тайлагч ус амтагдлаа. Надад түүнээс сайхан юм байхгүй санагдлаа. Бие минь тэнхээтэй болж, өлсөхөө ч болилоо. Хоосордоггүй халбага мөн хачин аа. Дахин дүүрэх халбаганаас би цадталаа идэж авлаа.

Юм-Юм нүдээ анин газар хэвтэнэ. Би түүнийг халбагаараа хооллов. Тэр нүдээ нээлгүй хооллохгоод:

- Хөөх Мио, би ямар сайхан зүүд зүүдэлсэн гээч.



Зовлонг ч туулж гарахад тустай зүүд. Цатгадаг талхнаас би идэж байна гэж зүүдэлээ.

- Тэр чинь зүүд биш байсан гэж би хариуллаа.

Юм-Юм босч суугаад, цатгалан бөгөөд амьд байгаагаа мэдэрлээ. Бид хоёулаа гайхахын ихээр гайхаж, хэдий зовлонд унасан ч баяртай байв.

- Бид хоёрыг турж үхээгүй байхыг хараад Като яах бол оо? гэж Юм-Юм бодлогошров.

- Чулуун зүрх л битгий суулгаасай. Би түүнээс л их эмээж байна, учир нь цээж зүсч өвтгөнө дөө гэж би хэлэв.

- Шөнө хараахан дуусаагүй байна. Като ирэх болоогүй. Цаг нөхцөөж, Алс холын орны тухай ярья. Хоёулаа ойртож суувал ингэж их даарахгүй болов уу гэж Юм-Юм тайтгаруулав.

Хүйтэн гянданд бид хөлдөж үхэх дөхөв. Миний нөмрөг шалан дээр унасан байлаа. Би түүнийгээ авч нөмрөв. Нэхмэлчин бүсгүйн надад зориулж зүүдний даавуугаар урласан нөмрөг.

Яг тэр хоромд Юм-Юм:

- Мио Мио, чи хаана байна аа? гэж хашгирахад би:

- Би энд л байна шүү дээ. Хаалганы хажууд гэв.

Сүүлчийн шөнөө гэрэлтүүлэх гэж авсан жижиг лааны хугархай барьсаар Юм-Юм тал тал уруу ихэд айсан шинжтэй харна.

- Чи надад харагдахгүй байна аа. Хаалга, цоож гээд бусад юм надад үзэгдэхийг бодвол би сохроогүй байлтай.

Нөмрөгийнхөө дотор талыг гадагш нь харуулж өмссөнөө би анзаарав. Нэхмэлчний зүүдний даавуугаар оёсон гялалзсан дотор гадагшаа харсан байв. Би нөмрөгөө тайлсан чинь Юм-Юм дахиад л хашгирлаа.

- Чи намайг ахиж ингэж бүү айлгаарай. Чи хаана нуугдсан байсан бэ?

- Чи намайг одоо харж байна уу? гэж би асуув.

- Харалгүй яахав? Чи түрүүн хаана байсан бэ?

- Нөмрөгөн дотроо. Нэхмэлчин надад үл үзэгдэгч нөмрөг өгчээ.

Бид олон удаа туршиж үзлээ, зүүдний даавуугаар урласан дотрыг гадагш нь харуулан нөмрөхөд үнэхээр үл үзэгдэгч болж байв.

- Хоёулаа чанга хашгиръя. Тэгэхээр туршуулууд орж ирнэ, харин чи хажуугаар нь үл үзэгдэгч нөмрөгөө нөмрөн цайзнаас гарч Алс холын орон дахь гэртээ харь гэж Юм-Юм хэлэв.

- Юм-Юм аа, чи яах болж байна?

- Би энд үлдэнэ ээ. Чамд үл үзэгдэгч болгодог нөмрөг ганцхан л байгаа шүү дээ гэж хэлэхэд түүний хоолой ялимгүй зангирч байлаа.

- Надад үл үзэгдэгч нөмрөг ч ганц, сайн найз ч ганц байна. Бид хоёрт эндээс амьд гарах арга олдохгүй бол үхсэн ч чамтай хамт гэж би хэлэв.

Юм-Юм намайг тэврээд,

- Би чамайг эндээс оргоод, эсэн мэнд гэртээ хариасай гэж маш их хүсч байна. Гэтэл чи надтай хамт үлдэнэ гэх юм.

Тийнхүү хэлж дуусав уу, үгүй юу л гайхамшигтай явдал тохиолдлоо. Илбэдүүлсэн шувууд тортой салхивчин дээр жигүүр дэвэн хүрч ирлээ. Тэд хошуундаа нэг юм зуусан харагдана. Бүгд л нэг хүнд юм дамжлан авч ирэх шиг. Тэр нь чулуу зүсэх шидтэй миний илд байв.

- Хөөх Мио, шувууд чиний илдийг сөнөсөн нуурын ёроолоос гаргаж иржээ гэж Юм-Юм дуу алдав.

Би салхивчны дэргэд гүйж очоод, гараа сарвайн торны цаанаас илдээ авлаа. Гал мэт дүрэлзэх илднээс ус дусна. Тэрхүү дусал нь хүртэл галын дөл мэт гэрэлтэн байлаа.

- Сайн санаат шувууд та нартаа баярлалаа гэж би хэлэв.

Гэтэл тэд над уруу гялалзсан, гунигт, жаахан нүдээрээ харснаа сөнөсөн нуурын зүг нисэн одлоо.

- Хоёулаа лимбээрээ хөгжимдсөн нь тун сайн боллоо. Тэгээгүй бол чи бид хоёрыг тэд хэзээ ч олохгүй байсан байх гэж Юм-Юм өгүүллээ.

Би илдээ барьж зогслоо. Миний илд, миний галын дөл! Би амьдралдаа хэзээ ч ийм их хүч тэнхээтэй байсангүй. Миний толгой дүнгэнэнэ. Би аавыгаа бодлоо, тэр ч гэсэн миний тухай бодож байгаа нь лав.

- Юм-Юм аа, одоо Катогийн эцсийн тулалдаан болно оо.

Юм-Юмын царай цонхийсноо, нүд нь нэг л сонин гялалзав.

- Долоон цоожийг чи яаж онгойлгох гэв? Хорин долоон туршуулын хажуугаар чи яаж гарах гэв?

- Долоон цоожийг би илдээрээ онгойлгоно, үл үзэгдүүлэгч нөмрөг намайг хорин долоон туршуулаас нуух болно гэж би хариуллаа.

Би нөмрөгөө мөрөн дээрээ тохлоо. Үлгэрийн даавуу харанхуйд гэрэлтэнэ. Тэрээр Катогийн цайзад гэгээ оруулах гэсэн мэт гялалзана. Юм-Юм хэлсэн нь:

- Мио, чи надад харагдахгүй ч чамайг энд байгааг би мэднэ. Чамайг эргэн иртэл би энд хүлээнэ.

- Хэрвээ би буцаж ирэхгүй бол гээд би дуугүй болов. Эцсийн тулалдаанд хэн ялахыг би яаж мэдэх билээ.

Шоронд чив чимээгүй болов. Удтал чимээгүй суусны дараа Юм-Юм хэлсэн нь:

- Мио, хэрвээ чи ирэхгүй бол хоёулаа бие биенийхээ тухай бодъё. Чадах хэрээрээ бодъё.

- Тэгнэ ээ, Юм-Юм, эцсийн мөчид би чамайг болон аавыгаа бодно оо.

Би илдээрээ төмөр хаалгыг гурил мэт зүслээ. Чулуу зүсэх шидтэй илдэнд төмөр хаалга нь гурил хэрчихтэй адил билээ. Би хэдэн удаа цавчиж, том цоожнуудыг бас мулталж гаргалаа.

Дараа нь хаалгаа онгойлголоо. Аяархан чохарч байна. Долоон туршуул манаатай. Бүгд хаалганы зүг эргэж харлаа. Нөмрөг маань харагдмаар илт гэрэлтэж байгаа байх гэж би бодлоо.

- Чахрах чимээ надад сонстлоо гэж нэг туршуул өгүүлэв.

- Тиймэ ээ, нэг юм дуугарах шиг болсон гэж нөгөө туршуул нь залгуулж хэлэв. Тэд ийш тийш хараад юу ч олсонгүй.

- Катогийн муу санаа л хажуугаар чохарч өнгөрсөн байх гэж тэдний нэг нь таамаглав. Харин би аль хэдийн холдож амжсан байлаа.

Илд барьж, нөмрөгөө нөмөрсөн чигээрээ Катогийн өрөө үрүү хар хурдаараа гүйлээ.

Энд тэндгүй харуулууд. Хар цайзаар дүүрэн хар туршуул. Гэвч тэд намайг харсангүй. Намайг сонссонгүй. Би дээрэмчний өрөөний зүг гүйсээр л.

Миний л айдас улам л багассаар байв. Би хэзээ ч ийм зоригтой байж үзээгүй сэн. Би чинь одоо Сарнайн цэцэрлэгт овоохой барьж тоглодог Мио биш ээ. Тулаанд орох гэж буй хариг эр болсон. Ингээд би цаашаа Катогийн өрөө үрүү хурдалсаар.

Би хурдан гүйлээ. Харанхуй цайзад миний үлгэрийн нөмрөг гэрэлтэн намилзана.

Гал мэт гэрэлтэх илдээ өргөн барьж Катогийн өрөөний зүг гүйсээр л.

Би аавынхаа тухай бодлоо. Тэр ч гэсэн лавтай намайг бодож байгаа. Удахгүй эхлэх тулалдаанаас би айгаагүй. Би гартаа сэлэмтэй зоригт баатар эр байлаа. Дээрэмчний өрөөний зүг гүйсээр л.



Толгойд усан оргилуур орчихсон мэт нэг л хачин. Би Катогийн ерөөний хаалган дээр ирлээ.

Хаалгыг нээлээ. Като чулуун ширээний ард сууна. Тэр над уруу нуруугаа харуулан сууж байв. Түүнийг хорон санаа тойрон эргэлдэнэ.

- Дээрэмчин Като, наашаа хар даа! Одоо чиний эцсийн тулалдаан болно! гэж намайг хашгирахад тэр эргэж харлаа. Би нөмрөгөө тайлаад, гартаа илдээ барьсаар зогсов. Катогийн жигшүүртэй муухай царай үрчийж сааралтан, нүдэнд нь үзэн ядалт, айдас тодорлоо. Илдээ тэр ширээн дээрээс давхийн шүүрч авахад дээрэмчин Катогийн эцсийн тулалдаан эхэллээ.

Түүний илд аймаар байсан ч минийхийг гүйцэхгүй. Миний илд гялалзаж, туяарч, дүрэлзэж, агаарт гал мэт гэрэлтэн, Катогийн илдтэй хайр найргүй цавчилдана.

Мянга мянган жилийн өмнөөс хүсэн хүлээсэн тулалдаан нэг цаг үргэлжлэв. Миний илд агаарт галын

дөл мэт гялсхийж, Катогийн сэлмийг гараас нь унагалаа. Зэвсэггүй болсон дээрэмчин өөрийн мөхөл ирж буйг мэдэв бололтой. Тэр хар хилэн нөмрөгөө тайлж шидлээ.

- Зүрхийг минь цавчаарай! Энэ чулуун зүрх миний цээжийг зүсэн орж, удтал шаналгасан. Зүрх үрүү минь бүлээрэй! гэж тэр бархирав.

Нүд үрүү нь харвал Като чулуун зүрхээ тас цавчуулахыг хүсч байгаа нь илт байв. Өөрөө өөрийгөө тэгж их үзэн ядах гэж байдаг аа, бас.

Би агшин зуур гал бадрах илдээ далайж, Катогийн бузар муухай чулуун зүрх үрүү дүрлээ.

Яг тэр мөчид Като алга болов. Түүний оронд харин газар овоолгоостой чулуу хэвтэж байв. Зөвхөн овоолсон чулуу л үлдэж. Бас нэг төмөр сарвуу.

Дээрэмчин Катогийн цонхны тавцан дээр жижигхэн саарал шувуухай суугаад цонх уруу тоншино. Тэндээс гарахыг хүссэн нь мэдээж. Түүнийг би урьд нь анзаарсангүй. Хаана нуугдаж байсан юм бол? Би цонх



нээлээ. Чөлөөт шувуу тунгалаг агаарт баясгалантайгаар жиргэж эхлэв. Тэр хорионд удсан биз.

Шувуу цааш нисэн одохыг нээлттэй цонхоор харав. Тэгсэн чинь аймшигт шөнө өнгөрч, авралт өглөө хэдийн болсон байлаа.

Миний хүү Мио

Тийм ээ, өглөө болж гадаа ямар сайхан байна аа. Намайг цонхны дэргэд зогсож байхад нар ээж, зуны зөөлөн салхи үсийг минь илэх мэт үлээнэ. Би доошоо тонгойж нуурын зүг харлаа. Нарны туяа тусгасан, найрсаг цэнхэр нуур болжээ. Илбэдүүлсэн шувууд харагдсангүй.

Хөөх, ямар сайхан өдөр вэ! Гадаа гарч тоглоход яг таарсан сайхан өдөр байна. Би өглөөний салхинд долгиолон байгаа усыг харлаа. Тийшээ ямар нэгэн юм шидэхийг хүслээ. Ус харахаар надад дандаа тэгж бодогддог. Ийм өндөр дээрээс юм чулуудвал мөн догио. Илднээс өөр зүйл байгаагүй тул би илдээ шидчихэв. Илд агаарт эргэлдсээр, нууранд цүлхийн орлоо. Усан мандал дээр илдний унасан хэсэгт том, гоё долгион үүсч, улмаар улам томорсоор нуураар нэг тархав. Тэр нь хөгжилтэй харагдлаа.

Гэхдээ надад энэ долгионыг алга болтол нь харж зогсох зав байсангүй. Би Юм-Юм уруу яаралтай буцаж очих хэрэгтэй. Тэр намайг хүлээж сэтгэл нь түгшиж байгааг би мэдэж байв.

Нэг цагийн өмнө ирсэн тэр замаараа буцаж гүйлээ. Урт хонгил, том танхимуудад хүнгүй нам гүм байв. Хар тагнуулуудаас нэг нь ч алга. Хоосон танхимуудыг нар гийгүүлнэ. Тортой цонхны цаанаас гийх нарны гэрэл таазнаас унжих аалзны шүлсэн дээр тусахад, Катогийн

цамхаг хэчнээн хуучин бөгөөд үзэмжгүй муухай нь харагдлаа.

Эргэн тойронд эзгүй, чив чимээгүй. Юм-Юм бас явчихсан биш байгаа гэж би гэнэт сандарлаа. Ингээд би улам хурдлан гүйлээ. Шоронд дөхөж очиход Юм-Юмын лимбэдэх сонсогдлоо. Миний санаа амарч, баярлах сэтгэл төрөв.

Шоронгийн хаалгыг онгойлгоход Юм-Юм шалан дээр сууж байлаа.

Тэр намайг хараад нүд нь гэрэлтэж, босон харайв.

- Миний санаа маш их зовж байсан тул би хөгжмөөрөө тасралтгүй тоглосон гэж тэр хэлэв.

- Одоо чи санаа зовох хэрэггүй гэж би түүнд хэллээ.

Бид хоёр маш их аз жаргалтай байв. Бид бие биенээ ширтсэнээ инээлдэв.

- Эндээс явъя. Дахиж хэзээ ч энд ирэхгүй гэж би хэлээд бид гар гараасаа хөтлөлцөн Катогийн цамхгаас гүйн гарав. Гадаа гартал миний урдаас хэн давхиж ирсэн гэжч? Мирамис! Алтан дэлтэй Мирамис минь! Түүний хажууд жижигхэн цагаан унага шогшино. Мирамис над дээр давхиж ирэхэд, би хүзүүгээр нь тэвэрч толгойгоо наан удаан зогсов. Тэгээд чихэнд нь:

- Мирамис, миний Мирамис! гэж шивнэв.

Мирамис над уруу үнэнч нүдээрээ харахад, би түүнийг хэчнээн их санасан шиг тэр бас намайг санасан гэдгийг мэдлээ.

Гадаах баганын дэргэд хэвтэх гинжийг хараад Мирамис бас илбэдүүлсэн байсныг би ойлголоо. Шөнийн цагт энэ задгай талбайд гинжлүүлсэн байсан



хар морь бол Мирамис байж. Харин тэр бяцхан унага бол Харанхуй ойгоос дээрэмчин Катогийн хулгайлсан унага байлаа. Зуун цагаан адуу тэр унагнаас болж цусаар уйлж байж. Удахгүй тэр бяцхан унага эргээд очих тул тэд дахин уйлах хэрэггүй болжээ.

- Илбэдүүлсэн шувууд хаачсан бэ? гэж Юм-Юм гайхширав.

- Нууран дээр очиж үзье гэж би хэлэв.

Мирамисаа унаж, бяцхан унага ч бас чадлынхаа хэрээр араас хурдлаллаа. Бид цайзны хаалгаар гарлаа.

Энэ мөчид бидний ард аймшигтай бөгөөд хачин чимээ гарлаа. Газар нүргэлсэн их чимээ. Харваас



Катогийн цайз нурж унаад, түүнээс овоолгоостой чулуу л үлджээ. Шорон, хоосон танхим, харанхуй шат, тортой цонх гээд юу ч үгүй боллоо. Овоолсон чулуу л үлдэж.

- Дээрэмчин Катогийн цайз үүрд байхгүй боллоо гэж Юм-Юм хэлэв.

- Чулуу л оронд нь үлдлээ гэж би хэллээ.

Хадан цохионоос нуур луу чиглэсэн эгц жим гарчээ. Огцом, нарийнхан, аюултай зам. Гэлээ ч Мирамис тэр жимийг туйлын болгоомжтой дагаж, бяцхан унага ч адил дуурайж явлаа. Бид эрэг дээр аюулгүй хүрэлцэн ирэв.

Хадны ёроолд хэдэн хүүхдүүд тойрон цугласан байв. Мэдээж тэд биднийг хүлээж байсан хэрэг. Яагаад гэвэл тэд бидэн үрүү дөхөж ирж, инээмсэглэлээр угтсан юм.

- Хөөх, эд нар чинь Нонногийн ах нар байна. Йиригийн бага охин дүү гээд бүгд байна. Одоо тэд илбэдүүлсэн



шувууд биш болжээ гэж Юм-Юм дуу алдав.

Бид Мирамисын нуруун дээрээс үсрэн буув. Бүх хүүхдүүд бидэн үрүү ирэв.

Тэд жаахан ичингүйрсэн харагдсан боловч их нөхөрсөг, аз жаргалтай харагдав. Ноногийн ах нарын нэг нь миний гарыг барин,

- Чи миний нөмрөгийг өмссөнд, бас одоо илбэдүүлсэн шувуу биш болсондоо их баяртай байна гэж бусдад сонсуулахыг хүсээгүй бололтой аяархан хэлэв.

Йиригийн бага охин дүү бас бидэн рүү хүрч ирэв. Тэр ичимхий охин тул над уруу эгц харахгүй, нуурын зүг харан байж намуухан дуугаар,

- Чи миний халбагыг авсанд, бид бас илбэдүүлсэн шувуу биш болсондоо би маш их баяртай байна гэж хэлэв.

Нонногийн өөр нэг ах нь миний мөрөн дээр гараа тавьж,

- Чиний илдийг гүнээс гаргаж авч чадсан, бид бас илбэдүүлээгүйдээ маш их баяртай байна гэж хэлэв.

- Миний илд одоо тэр нуурын ёроолд байгаа, тэр нь ч зөв хэрэг. Учир нь надад одоо илд хэзээ ч хэрэг болохгүй гэж би хэлэв.

- Одоо бид нар илбэдүүлээгүй байгаа учраас тэрнийг дахин хэзээ ч гаргаж ирж чадахгүй гэж Нонногийн ах хэлэв.

Тойрон зогссон хүүхдүүдийг би хараад,

- Та нарын хэн чинь нэхмэлчний бяцхан охин бэ? гэж би асуухад бүгд чив чимээгүй болов. Хэн ч юу ч хариулсангүй.

- Нэхмэлчний бяцхан охин хэн бэ? гэж би дахин

асуув. Учир нь түүний ээж нь миний нөмрөгийг шидэт даавуугаар доторлосон байсан гэдгийг би хэлэхийг хүссэн юм.

- Нэхмэлчний бяцхан охин чинь Милимани шүү дээ гэж Нонногийн ах хэлэв.

- Тэр хаана байна? гэж би асуулаа.

- Милимани тэнд хэвтэж байгаа гэж Нонногийн ах хэлэв.

Хүүхдүүд хажуу тийш болцгоов. Усны захад хавтгай чулуун дээр бяцхан охин хэвтэнэ. Би түүн үрүү гүйн очиж хажууд нь өвдөглөн суув. Тэр нүдээ аньж, хөдөлгөөнгүй хэвтэнэ. Тэр амиа алджээ. Бяцхан нүүр нь хувхай цайж, бие нь түлэгджээ.

- Тэр бамбар өөд нисчихсэн юм гэж Нонногийн ах хэлэв.

Миний зүрх шимшрэв. Милимани миний төлөө нас баржээ. Би маш их гуниглав. Милимани намайг аврахаар амиа алдсан тул миний баяр баясгалан хоромхон зуурт үгүй болов.

- Бүү гунигла. Милимани үүнийг өөрөө хүссэн юм. Түүний далавч нь шатна гэдгийг тэр мэдэж байсан ч тэр бамбар өөд ниссэн юм гэж Нонногийн ах хэлэв.

- Гэхдээ тэр одоо өнгөрсөн байна шүү дээ гэж би цөхрөн хэлэв.

Нонногийн ах Милиманигийн түлэгдсэн бяцхан гарыг барив.

- Милимани, бид чамайг энд орхих болж байна. Гэхдээ бид явахаасаа өмнө чамд зориулж дуу дуулж өгье гэж хэлэв.

Хүүхдүүд Милиманийг тойрон чулуун дээр сууж

өөрсдийн зохиосон дуугаа дуулж өгөв.

*Бидний бяцхан дүү Милимани
Давалгаанд орсон бидний дүү
Түлэгдсэн далавчтай живсэн юм.
Милимани , Милимани минь
Нам гүн нойрсоно, хэзээ ч сэрэхгүй,
Милимани дахин хэзээ ч хар усан дээгүүр нисэхгүй.*

- Одоо тэр ус хар байхаа больсон. Харин Милиманид бяцхан, найрсаг давалгаанууд эрэг дээр хэвтэж нойрсоход нь дуу дуулж өгнө гэж Юм-Юм хэлэв.

- Бидэнд түүнийг хучих ямар нэгэн юм байдаг ч болоосой. Тэгвэл тэр хатуу чулуун дээр хэвтэхгүй шүү дээ гэж Йиригийн дүү хэлэв.

- Милиманийг миний нөмрөгөөр хучаад, ээжийнх нь нэхсэн даавуунд орооё гэж би хэлэв.

Зүүдний даавуугаар доторлосон нөмрөгөөрөө би Милиманийг хучив. Энэ нь алимны модны цэцэгнээс зөөлөн, шөнийн сэвшээ салхинаас намуухан, зүрхний улаан цуснаас дулаахан, төрсөн ээжийнх нь нэхсэн хувцас байлаа. Түүнийг чулуун дээр зөөлөн хэвтүүлэхийн тулд би нөмрөгөөрөө болгоомжтой гэгч ороолоо.

Гэтэл гайхалтай явдал тохиолоо. Милимани нүдээ нээж, над уруу харлаа. Эхлээд тэр намайг ширтэн хэвтэж байснаа өндийн сууж бүх хүүхдүүд үрүү гайхан харав. Тэр эргэн тойрноо улам их гайхаж ажина. Тэгээд тэр:

- Нуур ямар цэнхэр байна аа хэмээв.

Тэр өөр юу ч хэлсэнгүй. Тэгснээ тэр хучсан нөмрэгийг

сөхөөд босов. Түүний биен дээр түлэгдсэний ямар ч ул мөр байсангүй. Түүний амь аврагдсаны дараа бид улам их аз жаргалтай боллоо.

Тэртээд нэг завь биднийг чиглэн ирж явна. Хэн нэгэн хүчтэй сэлүүрдэж харагдана. Завийг ойртон ирэхэд би зэвсгийн дархан сэлүүрдэж, хажууд нь Эно хамт явааг харагдлаа.

Удалгүй тэдний завь эрэг мөргөн зогсоход тэд бууж ирлээ.

- Би юу гэж хэлж байлаа? Дээрэмчин Катогийн эцсийн тулалдаан гэж хэлээгүй юу? гэж зэвсгийн дархан нүргэлэх мэт дуугаар өгүүлэв.

Эно тэсэж ядсан байдалтай над уруу ойртон ирэв.

- Ханхүү Мио, би чамд нэг юм үзүүлэх гэсэн юм гэж тэр хэлэв.

Тэрээр үрчийсэн гартаа нандигнан атгасан зүйлээ үзүүллээ. Тэр нь жижигхэн ногоон навч байв. Нимгэн, доторх нь гэрэлтсэн, эмзэг, цайвар ногоон навч.

- Сөнөсөн ойн модонд ургаж байна, бид түүнийг хэдхэн хормын өмнө оллоо гэж Эно хэлэв.

Тэрээр сэтгэл хангалуунаар буурал толгойгоо дээш доош болгон дохино.

- Би одоо өглөө бүр үхмэл ойд очиж ногоон навч ургасан эсэхийг шалгаж байна аа. Ханхүү Мио, чи үүнийг ав гэж тэр хэлээд, навчийг надад өглөө.

Тэрээр хамгийн сайхан бэлэг өгч байна гэдэгтээ нэн итгэлтэй харагдав. Тэр дахин толгойгоо дохиод:

- Ханхүү Мио, би чамд сайн сайхныг хүсч гэртээ суусан. Би юу гэж хэлж байлаа? Дээрэмчин Катогийн эцсийн тулалдаан гэж хэлээгүй юу? гэж зэвсгийн дархан

чанга өгүүлэв.

- Та завиа яаж буцааж авсан бэ? гэж би дархнаас асуув.

- Нуурын давалгаанд туугдаад ирсэн юм.

Би зэвсгийн дархны уул болон Эногийн байшингийн зүг нуурын дээрээс харав. Миний урьд өмнө зүс үзээгүй дүүрэн хүн суулгасан зөндөө олон завинууд нууран дээр гарч ирэв. Тэдгээр цонхигор царайтай жижигхэн хүмүүс нар болон цэнхэр нуурыг гайхан ширтэнэ. Тэд ер нь нарыг хэзээ ч үзээгүй биз ээ. Нуур, эргэн тойрны хадан цохионд нарны гэрэл тусч үнэхээр сайхан харагдана.

Зөвхөн хадан цохион дээрх бөөн чулуунууд таатай биш байлаа. “Эдгээр нүцгэн чулуун дээр нэг л өдөр хөвд ургачих байх даа,” гэж би бодов. Удалгүй зөөлөн ногоон хөвдөнд хучигдаж, үүний доор Катогийн цамхаг байгаа гэж хэн ч мэдэхгүй болно. Би хөвдөн дээр ургадаг ягаан цэцгийг урьд нь харж байсан. Энэ нь урт мөлхөө навчин дээр ургадаг жижигхэн хонхон цэцэгтэй адилхан. Хэсэг хугацаа өнгөрөхөд магадгүй дээрэмчний цайзыг бүрхсэн хөвдөн дээр жижиг ягаан хонхон цэцэг ургаж ч магадгүй. Тэгвэл энэ маш үзэсгэлэнтэй харагдана гэж би бодлоо.

Гэр лүүгээ явах зам урт боловч алхаж явахад амар байлаа. Жижиг хүүхдүүд Мирамисыг унаж харин хамгийн бага нь унагыг унаж явлаа. Энэ нь тэдэнд маш хөгжилтэй санагдаж байв. Бид харин Харанхуй ой хүртэл явган явж ирэв.

Биднийг энд ирэх үед Харанхуй ойд шөнө болж, яг урьдын адил сарны туяа тусна. Моддын дунд чив чимээгүй. Харин Мирамисыг чангаар янцгаахад сарны туяан ойн гүнд зуун цагаан адуу хариуд нь мөн



адил чангаар янцгаав. Тэд бидний зүг давхин ирэхэд туурайнаас нь оч цахилна. Бяцхан унага дуурайн янцгаав. Унага том морьдыг дуурайн чангаар янцгаахыг оролдсон боловч сонсогдохтой үгүйтэй дуугарав. Харин зуун цагаан адуу түүний дууг сонсчээ. Унагыг гэртээ эргэн ирсэнд тэд ямар их баярласан гээч! Тэд түүнийг тойрон бүчиж аль болох ойртож, үнэхээр ирсэн гэдэгт итгэхийн тулд шөргөөж байв.

Одоо бид зуун морьтой болсон учраас хэн ч явган явах шаардлагагүй боллоо. Хүүхэд бүр унаж явах морьтой болов. Би Мирамисыг унаж, Юм-Юм урьдынх шигээ надтай сундалж явлаа. Тэр Мирамисаас өөр морь



унах дургүй. Хүүхдүүдээс хамгийн бяцхан охин унагыг унаж явав.

Бид ойн дундуур давхихад сарны гэрэлд зуун цагаан адуу үнэхээр сайхан харагдана.

Удалгүй би нэхмэлчний байшингийн хажууд ургах алимны моддын цагаан цэцэгсийг харлаа. Эдгээр цэцэгс үлгэрийн мэт санагдуулах байшинг тойрч, цасан хунгар мэт харагдана. Байшин дотор нижигнэх чимээ сонстов.

- Миний ээж даавуугаа нэхэж байна гэж Милимани хэлэв.

Тэр гэрийнхээ үүдэнд ирээд мориноосоо үсрэн бууж бидэн үрүү гараа даллан,

- Би гэртээ ирсэндээ маш их баяртай байна. Алимны

мод цэцэглэж дуусахаас өмнө би гэртээ ирсэндээ баяртай байна хэмээв.

Тэр моддын дунд байгаа нарийхан зөрөг замаар гүйж, байшин уруу оров. Байшин дотор дүнгэнэсэн чимээ гарахаа зогсов.

Бид Ногоон нугын арал хүртэл их урт зам туулах хэрэгтэй болов. Би гэрээ болон аавыгаа их санаж байлаа. Мирамисыг дагасан зуун цагаан адуу харанхуй ой дээгүүр хөөрч, өндөр уулнаас өндөрт гарч Ногоон нугын арал уруу нислээ.

Үүрийн гэгээний гүүрэн дээр биднийг хүрч ирэхэд өглөө болж байв.

Харуулууд гүүрийг дөнгөж буулгаж байсан бөгөөд алтлаг өнгөөр гялталзаж байх тэр үед зуун цагаан адуу дэлээ намируулсаар гүүрээр давхин гарав. Харуулууд гайхаж биднийг ширтэнэ. Гэнэт тэдний нэг нь бүрээгээ гарган маш чангаар үлээхэд, бүрээн дуу Ногоон нугын аралдаяарцуурайтлаа. Хүүхдүүдээ алдчихаад гашуудан шаналж байсан хүмүүс бүгд гэр гэрээсээ гүйн гарч ирэв. Биднийг бүгдээрээ цагаан морь унаад ирж байхыг тэд харлаа. Ганц ч хүүхэд дуталгүй гэртээ эргээд ирэх нь тэр.

Цагаан морьд хээр талаар давхиж, удалгүй бид миний хаан аавын цэцэрлэгт ирэв. Хүүхдүүд мориноосоо үсрэн буухад ээж аав нар нь гүйн ирсэн нь бяцхан унагыг эргэж ирэхэд зуун цагаан адуу угтаж ирсэнтэй адил байлаа. Тэнд Нонно, түүний эмээ, Йири ах дүү нартайгаа, Юм-Юмын ээж аав байснаас гадна миний огт харж байгаагүй олон хүн байв. Тэд бүгдээрээ эргэж ирсэн хүүхдүүдээ тэвэрч үнсэж, хамт уйлцааж байв.

Харин миний аав тэнд байсангүй.

Бидэнд одоо зуун цагаан адуу хэрэггүй болсон тул тэд харанхуй ой уруугаа буцав. Би тэднийг нуга дундуур давхин одохыг харав. Тэдний урд талд бяцхан цагаан унага давхина.

Юм-Юм ээж аавдаа болсон бүх явдлыг ярьж байх зуураа намайг сарнайн цэцэрлэгийн жижиг хаалгыг онгойлгосныг анзаарсангүй. Намайг сарнайн цэцэрлэгт орохыг ч бас анзаарсангүй. Тэр нь ч дээр байлаа. Би тийшээ ганцаараа явахыг хүссэн юм.

Мөнгөн улиангар яг урьдынхаа адилаар аялгуу эгшиглүүлж, сарнай цэцэгс урьдын адилаар цэцэглэж байхыг харав.



Тэгээд би аавыгаа харлаа. Тэр намайг харанхуй ой уруу давхиад явсан тэр нэгэн өдөр зогсож байсан тэр л газраа байв. Тэр над уруу гараа сунгахад би гүйн очиж наалдав. Би түүнийг чанга тэврэхэд тэр бас намайг өөртөө наалдуулан шивнэсэн нь:

- Мио, хүү минь!

Аав минь надад маш их хайртай. Би ч бас адил.

Би өдрийг маш зугаатай сайхан өнгөрөөсөн. Юм-Юм, Нонно, түүний ах нар, Йири болон түүний ах дүүс, бусад бүх хүүхдүүдтэй хамт сарнайн цэцэрлэгт тоглолоо. Тэд Юм-Юм бид хоёрын барьсан овоохойг үзээд "Их сайхан овоохой болжээ," гэж хэлсэн. Бид Мирамисыг унан давхихад тэр сарнайн бутан дээгүүр үсэрнэ. Бид миний нөмрөгөөр тоглов. Нонногийн ах нөмрөгөө буцааж авахыг хүссэнгүй.

- Нөмрөгний дотор чинийх шүү дээ, Мио гэж тэр хэлсэн.

Бид нөмрөгөө өмсөн нуугдаж тоглоцгоов. Би нөмрөгний дотор талыг гадагш харуулан өмсөөд хэнд ч харагдахгүй болчихоод,

- Намайг хэн ч барьж чадахгүй дээ гэж хашхиран сарнайн бутыг тойрон гүйв.

Тэд хэчнээн хичээсэн боловч намайг барьж чадаагүй.

Харуй бүрий болж, хүүхдүүд гэр гэртээ харих хэрэгтэй боллоо. Гэртээ эргэж ирсэн эхний өдөр байсан учраас ээж аав нь тэднийг гадаа удаан байлгахыг хүссэнгүй.

Юм-Юм бид хоёр хоёулхнаа овоохойдоо сууж үлдэв. Бид жаргаж буй нарны бүдэг гэрэлд лимбээ

үлээж тоглолоо.

- Хоёулаа лимбээ хадгална аа. Хэрэв бид салж явахад хүрвэл өөрсдийнхөө эртний аяыг тоглоно шүү гэж Юм-Юм хэлэв.

Яг энэ үед хаан аав минь намайг хайсаар хүрч ирэв. Би Юм-Юмд сайхан нойрсоорой гэсний дараа тэр гэрийн зүг гүйлээ. Овоохойн дэргэд бэлчих Мирамист би бас тавтай нойрсоорой гэлээ. Аав намайг хөтлөөд, сарнайн цэцэрлэгээс гарч явав.

- Мио, чи гэрээсээ хол яваад ирэхдээ их өссөн байна. Өнөө орой хоёулаа гал тогооны хаалган дээрээ шинэ зураас тавих хэрэгтэй байх аа гэж аав хэлэв.

Бид мөнгөн улиангарын доогуур явлаа. Үдшийн бүрий нь зөөлөн цэнхэр манан мэт сарнайн цэцэрлэгийг тэр аяар нь бүрхжээ. Цагаан шувууд үүрэндээ оржээ. Хамгийн өндөр мөнгөн улиангарын орой дээр гунигийн шувуу суугаад жиргэнэ. Алга болсон хүүхдүүд эргээд ирсэн болохоор тэр одоо юун тухай дуулж буйг би мэдэхгүй. Гэхдээ тэр шувуунд дуулах юм дандаа байдаг болов уу.

Хээр талд яваа малчид түүдэг галаа асаав. Үдшийн бүрийд нэг нэгээр нэмэгдэн гялалзах түүдгийн гэрэл үнэхээр гоё. Алсад хоньчдын хөгжимдөх сонсогдоно. Тэд хуучин танил эртний аялгуугаа хөгжимдөнө.

Би аавынхаа гараас хөтлөн хоёр гараа савлан явлаа. Аав тонгойн над уруу хараад инээхэд би түүн үрүү аз жаргалаар бялхсан харцаар харав.

- Мио, хүү минь гэж харих зуураа аав өгүүлэв.

Тэр өөр юу ч хэлсэнгүй.

Үдшийн бүрий тасарч, шөнө боллоо.


Би энэ Алс холын оронд ирснээс хойш нэлээд хугацаа өнгөрчээ. Би хааяа л Упплансготан гудамжинд амьдарч байсан тэр үеийн тухай боддог юм. Юм-Юмтай маш адилхан байсан учраас Бэнкагийн тухай л хааяа боддог. Тэр намайг хэтэрхий их санаагүй байх гэж би найдаж байна. Учир нь хэн нэгнийг санах гэдэг ямар хэцүү болохыг надаас өөр хэн ч мэдэхгүй. Бэнка бол аав ээжтэй, одоо бодвол шинэ найзтай болоо биз дээ.

Заримдаа би Эдла эгч, Сикстэн ахын тухай боддог ч тэдэнд гомдохоо больсон. Намайг алга болоход тэд юу гэж хэлснийг мэдэх сэн. Тэд хэзээ ч миний төлөө санаа зовж байгаагүй учраас миний алга болчихсоныг мэдээгүй байж ч магад. Эдла эгч намайг Тэгнэрлюндэн цэцэрлэгт хүрээлэнгийн сандал дээрээс олдоно гэж бодож байгаа болов уу. Тэр намайг цэцэрлэгт хүрээлэнгийн дэнлүүний доорх сандал дээр суугаад, алим идэн, хоосон шар айрагны шил юм уу эсвэл ямар нэг хогоор тоглоод сууж байгаа гэдэгт итгэлтэй байж ч магадгүй. Эсвэл тэр намайг тэнд суугаад, цонх нь гэрэлтсэн байшингууд дахь ээж аавтайгаа хамт оройн хоолоо идээд сууж байгаа хүүхдүүдийг харж байгаа гэж бодож байж ч болно. Эдла эгч тийм бодолтой байгаа бол намайг жигнэсэн талхаа аваад харьсангүй гэж уурлаж байгаа даа.

Гэтэл Эдла эгч андуурчээ. Тийм ээ, тэр ямар их андуурна вэ. Боссэ цэцэрлэгт хүрээлэнгийн сандал дээр суугаагүй. Учир нь тэр Алс холын оронд байгаа. Алс холын оронд шүү. Тэр одоо мөнгөн улиангар мод эгшиглэсэн, шөнийн харанхуйг гэрэлтүүлсэн түүдэг гал, өлссөн хүнийг цатгадаг талх, түүнийг маш их хайрладаг хаан аав байдаг тэр газар байгаа.

Миний хүү Мио

Тийм ээ, ийм л байна даа. Бу Вильхельм Ольссон
Алс холын оронд өөрийн хаан аавын хамт маш сайн
байгаа.





Астрид Линдгрэн (1907-2002)

Астрид Линдгрэн нэгэн үе Стокхольм хотын ойролцоо орших Уппландсготан гудамж болон Тэгнэрмондэн цэцэрлэгт хүрээлэнгийн хавьд оршин суудаг байжээ. “Миний хүү Мио” номын гол баатар Боссэгийн адал явдал чухам тэндээс эхэлдэг. Олон жилийн хойно гарсан нэгэн ярилцлагад, цэцэрлэгт хүрээлэн дундуур алхаж явахдаа модон сандал дээр сууж байсан нэгэн хүүг зохиолч олж харснаар уул номын санаа анх төрсөн гэдэг.

“Би бодож эхлэв, хм, жаал хүү энэ хавийн нэг байранд л суудаг байх”, яг энэ мөчөөс эхэлж Астрид Линдгрэн нь Боссэ, бирд хоёрын тухай богиновтор түүх зохиосон аж. Олон жилийн дараа зохиолч нөгөө түүхээ үргэлжлүүлж, Боссэгийн Алс холын орон дахь адал явдалыг бичжээ.

Астрид Линдгрэн амьдралынхаа турш дэлхийн сая сая хүүхдийн амтархан уншдаг олон сайхан ном туурвижээ. Тэгнэрмондэний цэцэрлэгт хүрээлэнд зохиолчийн хүрэл хөшөө байдаг.

Миний хүү Мио

Бу Вильхельм Ольссон нь лонхоос суллагдсан бирдийн тусламжтайгаар өдөр шөнийг туулан аялаж, оддын цаана орших Алс холын оронд очно. Тэнд, түүнийг есөн жилийн турш хайсан хаан аав нь хүлээж авна. Хүү өөрийнхээ жинхэнэ нэр Мио гэдэг болохыг мэдэж, Стокхольм хотод өргөж авсан эцэг эхтэйгээ амьдарч байх үедээ хэзээ ч хүртэж байгаагүй хайр халамжинд умбана. Гэвч хаан аавтайгаа учирсан энэ гайхамшигтай уулзалтын үеээр Мио мянга, мянган жилийн урьдаас гарсан нэгэн зөн билгийн талаар мэдэж авна. Тэрээр хамгийн сайн найз Юм-Юм болон алтан дэлтэй Мирамис морьтойгоо хамт хэригий дээрэмчин Катотай тулалдахаар Харанхуй орныг зорино.

Анх 1954 онд швед хэл дээр хэвлэгдэн гарсан “Миний хүү Мио” зохиол нь дэлхийн хүүхдийн сонгодог номын нэг болжээ. Энэхүү монгол хэл дээр анх удаа гарч байгаа номын орчуулгыг хийхдээ Астрид Линдгрэний швед эх зохиолын аяс болон хэмнэлийг алдагдуулахгүй байхыг хичээсэн юм.



Хэвлэн нийтлэлийг
Интерпресс ХХК



Дэлхийн банстай хамтран хэрэгжүүлж буй
“Хөдөөгийн боловсролыг дэмжих
(READ) төсөл”-ийн хүрээнд хэвлэв.
Худалдахыг хориглоно.